

**ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ  
ДЭЛГЭРҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ АСУУДАЛ,  
САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ**

**/ЖУРАМ, АРГАЧЛАЛ/**



# ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ .....	3
1. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх .....	4–13
2. Монгол Улс ба Хориг арга хэмжээ .....	14–18
3. “Журам батлах тухай” МУ–ын Засгийн газрын тогтоол .....	19
4. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам .....	20–27
5. Аргачлал батлах тухай ТЕГ–ын даргын тушаал .....	28
6. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны аргачлал .....	29–115
7. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль .....	116–135
8. Мөнгө угаах болон Терроризмыг санхүүжүүлэх тухай .....	136–162
9. Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний хүрээнд тогтмол тавигддаг асуултууд .....	163–174

## ӨМНӨХ ҮГ

Терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх гэмт хэргийн хор уршгийг урьдчилан тооцоолох аргагүй бөгөөд дэлхийн улс орнууд түүний аюул заналаас гадна оршино гэж үгүй. Иймд улс орон бүр терроризм болон зэвсэг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүй, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох замаар терроризмын аюул занал, эрсдэлийг бууруулах арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлж байна.

Терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагын зүгээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой зөвлөмж, чиглэлийг боловсруулж дагаж мөрдүүлж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолын дагуу дээрх гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд улс орон, тэдгээрийн иргэд, байгууллагын эсрэг хориг арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн. Ялангуяа террорист байгууллага, этгээдтэй хамтран ажилладаг, тэдгээрийг санхүүжүүлдэг, нөгөө талаас үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдэж буй хүн, хуулийн этгээдийн эсрэг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг НҮБ-ын гишүүн улс орон бүр авч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

Монгол Улс нь НҮБ-ын өмнө болон нэгдэн орсон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг өдөр тутмын практик хэрэглээндээ удирдамж болгох замаар хэрэгжүүлэх шаардлагатай.

Иймд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг терроризм, түүнийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагч, банк, санхүүгийн байгууллагын ажилтан, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээд та бүхэн хэрхэн хэрэгжүүлэх талаарх энэхүү аргачлалыг Австрали Улсын Засгийн газраас үзүүлсэн техник туслалцааны хүрээнд боловсруулж үүгээр толилуульж байна.

Тус аргачлалд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой дотоодын эрх зүйн зохицуулалт, арга ажиллагаа зэргийг нарийвчлан тусгаснаар Та бүгдийн өдөр тутмын үйл ажиллагаанд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дотны зөвлөгч байж, байнгын дэмжлэг үзүүлж, хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү эмхэтгэлийг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн Сангийн яам, Монголбанкны удирдлага, хамт олонд гүн талархал илэрхийлье.

Терроризмтой тэмцэх зөвлөлийн дарга Д.Гэрэл

## **ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ**

### **Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэж юуг ойлгох вэ?**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх нь хүний амь нас, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, цаашлаад олон улсын энх тайван, аюулгүй байдалд ноцтой хор уршиг учруулж байна. Террорист байгууллага, бүлэглэл болон бусад этгээдийн зүгээс түүнийг олж авахыг эрмэлзэж байгаа нь эрсдэл дагуулж байна. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэхэд тухайн төрлийн гэмт хэрэг үйлдэхээр зэхэж буй этгээдүүдтэй холбоотой аливаа санхүүгийн урсгалыг таслан зогсоох нь чухал ач холбогдолтой юм.

Олон Улсад “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх”–ийн ойлголтын талаар нэгдсэн тодорхойлолтод хараахан хүрээгүй байгаа бөгөөд НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн 1540 тогтоолд үй олноор хөнөөх зэвсгийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын үүрэг, хариуцлагыг тогтоож, үр дүнтэй тэмцэхэд улс орнуудыг эрүүгийн, иргэний, захиргааны эрх зүйн чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг уриалж байна. НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн Хоригийн хорооноос тогтоол гаргаж БНИран Улс болон БНАСАУ–ын эсрэг үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авч байна. НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн эдгээр тогтоолууд нь үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн санхүүгийн өргөн хүрээний арга хэмжээг агуулдаг. Тиймээс үй олноор хөнөөх зэвсгийг санхүүжүүлэх нь санхүүгийн гэмт хэргийн эрсдэл мөн хориг арга хэмжээний эрсдэлд тооцогдож байна.

Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх гэмт хэргийг үйлдэхээр зэхэж буй этгээдүүдийн мөнгөн хөрөнгийн шилжилт, хөдөлгөөний урсгалтай тэмцэхээр гаргасан НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолуудын нэгээхэн хэсэг юм. Олон улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ) нь Иран, Хойд Солонгосын цөмийн зэвсэг дэлгэрүүлэх хөтөлбөртэй тэмцэхэд чиглэсэн санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх стандартыг тогтоодог. ФАТФ–ын 7–р зөвлөмж болон Шууд хэрэгжилт (Immediate Outcome) 11–т зэвсэг түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой

зорилтот хориг арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх олон улсын стандартыг тусгайлан тусгасан байдаг.

“Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.20–д зааснаар “Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглосон цөмийн, химийн, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах, ашиглахад бүрэн, эсхүл хэсэгчилсэн санхүүгийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхийг” хэлнэ.

Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл НҮБ–ын <https://www.un.org/securitycouncil/sanctions/information> цахим хуудсанд байрласан.

НҮБ–аас тавьж буй аливаа хориг арга хэмжээ нь санхүүгийн зорилтод хориг арга хэмжээнээс гадна үйл ажиллагаанд суурилсан санхүүгийн хориг, эдийн засаг, тодорхой нэг салбарын хориг арга хэмжээ болон холбогдох санхүүгийн хориг, сонор сэрэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг багтаана. Түүнчлэн лавлах жагсаалт, НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолуудын хориг арга хэмжээний үүргийн дэлгэрэнгүй тайлбарыг тус тус багтаасан байна.

Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах холбоосоор танилцах боломжтой:

- Үй олноор хөнөөх зэвсгийн санхүүжилттай тэмцэх талаар ФАТФ–аас гаргасан удирдамж: НҮБ–ын Аюулгүй байдлын зөвлөлийн үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэх тогтоолын санхүүгийн заалтуудын хэрэгжилт (2018).

<http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Guidance-CounteringProliferation-Financing.pdf>

- Anagha Joshi, Удирдамжийн баримт бичгийн нэмэлт материал: Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх загвар журам, RUSI, 2 дахь хэвлэл (2018):

[https://rusi.org/sites/default/files/20181002\\_model\\_law\\_2nd\\_edition\\_final\\_for\\_web.pdf](https://rusi.org/sites/default/files/20181002_model_law_2nd_edition_final_for_web.pdf)

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх арга хэлбэр болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй харьцуулах нь:

Мөнгө угаах нь тойрог хэлбэртэй үйл явц бөгөөд гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг угааж хууль ёсны хэлбэрт оруулан дахин ашиглах боломжтой болгох үйл явц юм. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлж буй этгээдүүд мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх арга, хэрэгслийг ашиглан хууль бусаар олсон хөрөнгийг аливаа улсын сахүүгийн системээр дамжуулан шилжүүлж болох ч энэ үйл явц нь шулуун байдаг. Тиймээс, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх үйл явц нь терроризмыг санхүүжүүлэх үйл явцтай илүү төстэй юм. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхэд ашиглаж буй хөрөнгийг тодорхой үе шаттайгаар шилжүүлдэг ба уг хөрөнгийг үй олноор хөнөөх зэвсгийг бүтээхэд шаардагдах бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлбөрт зарцуулдаг.

Center For New American Security судалгааны төвөөс гаргасан тайланд үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гурван үе шатыг тодорхойлсон байна:

1. Хөрөнгө босгох үйл ажиллагаа;
2. Олон Улсын санхүүгийн системээр дамжигдаж буй хөрөнгийг нуун дарагдуулах;
3. Олон Улсын зах зээлээс үй олноор хөнөөх зэвсэг бүтээхэд шаардагдах бараа, материал, технологийн худалдан авалт хийх.

Түүнчлэн Их Британи аюулгүй байдал судалгааны институт (RUSI)–ээс гаргасан тайланд үй олноор хөнөөх зэвсгийг санхүүжүүлэх үйл ажиллагааг дараах гурван төрөлд хуваасан:

1. Үй олноор хөнөөх зэвсэг бүтээхэд шаардлагатай бараа, материалын худалдан авалтыг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглан хийх: Үй олноор хөнөөх зэвсэг бүтээхэд шаардагдах бараа (импортын/экспортын, түүнчлэн тээврийн бараа), бүтээгдэхүүний худалдан авалтыг хийхэд санхүүжилт болон төлбөр тооцооны дэмжлэг үзүүлэх санхүүгийн үйлчилгээнүүдийг ойлгоно.

Жишээлбэл, бизнесийг дэмжих санхүүгийн үйлчилгээ, далайн болон тээврийн даатгал, экспортын бараа, бүтээгдэхүүний баталгаа гэх мэт.

2. Орлого нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа: Зэрлэг ан амьтны наймаа, хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлт, галт зэвсгийн худалдаа, цахим гэмт хэрэг, луйвар, бараа бүтээгдэхүүн хууль бусаар хил давуулах, залилан зэрэг үйлдлүүд орно.

Түүнчлэн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх ажиллагааг нуун дарагдуулахад чиглэсэн хууль ёсны бизнесийн үйл ажиллагаа багтана. Жишээлбэл: барилга, үйлчилгээний салбарын бизнес, хүнс, нэхмэл бүтээгдэхүүний экспорт, урлаг, тансаг зэрэглэлийн бараа бүтээгдэхүүний худалдаа наймаа, хөдөлмөрийн үйлчилгээ, ашигт малтмал, байгалийн баялгийг ашиглах, түүнийг эргэлтэд оруулах зэрэг үйл ажиллагаа.

3. Дээрх хоёр үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн компанийн эсхүл санхүүгийн дэд бүтэц бий болгох: Үүнд, дээрх хоёр ангилалд дурдагдсан үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэгчдийн (ялангуяа БНАСАУ) байгуулсан цогц сүлжээг ойлгоно. Энэхүү ангиллын үйл ажиллагаанд хамтарсан үйлдвэр байгуулах, халхавчийн компани байгуулах, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх (жишээ нь, дамжуулагч хэлбэрээр лиценз эзэмшдэггүй компаниуд гэх мэт), хил дамнансан тээврийн үйлчилгээ үзүүлэгч дундын этгээдүүд зэрэг үйл ажиллагаа байна. Энэ үйл ажиллагаанд тогтсон хэвийн, хууль ёсны дагуу үйл ажиллагаагаа эрхэлж буй компанийг ашиглаж болохоос гадна тухайн хуулийн этгээдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тэдэнд мэдэгдэлгүйгээр ашиглах боломжтой.

Цаашид үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргийг үйлдэх түгээмэл арга, хэлбэрийн талаарх судалгааг доорх цахим хуудаснаас харна уу.

- НҮБ–ын Шинжээчдийн зөвлөлийн Хойд Солонгостой холбоотой нөхцөл байдлын судалгааг агуулсан нарийвчилсан тайлан:  
[https://www.un.org/securitycouncil/sanctions/1718/panel\\_experts/reports](https://www.un.org/securitycouncil/sanctions/1718/panel_experts/reports)
- Jonathan Brewer, Final Report on the Study of Typologies of Financing of WMD Proliferation, King's College London (2017), which contains a broad

range of typologies or case studies including those related to North Korea, Iran, Syria and others:

<https://projectalpha.eu/wp-content/uploads/sites/21/2018/05/FoP-13-October-2017Final.pdf>

- FATF, Proliferation Financing Report, June 2008:  
<http://www.fatfgafi.org/media/fatf/documents/reports/Typologies%20Report%20on%20Proliferation%20Financing.pdf>

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэл

Аливаа улс орнууд үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлд дараах байдлаар өртдөг. Үүнд:

- Тухайн улс нь санхүүгийн томоохон төвүүдийн нэгд тооцогддог эсэх. Хэрэв тийм бол бохир мөнгөн хөрөнгийг түүнд шингээхэд илүү хялбар байх болно.
- Аливаа улс нь өөрийн газар нутаг дээр ачаа тээвэрлэх томоохон төвтэй эсэх.
- Олон улсын ханган нийлүүлэгчийн дэглэмээр хянагдах үй олноор хөнөөх зэвсэг бүтээхэд шаардлагатай бараа, бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг эсэх.
- Газар зүйн байршлын хувьд үй олноор хөнөөх зэвсэг бүтээдэг, түүнийг дэлгэрүүлдэг улс оронтой ойр байрладаг эсэх.
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлж буй улс нь бусад орнуудтай дипломат харилцаатай эсэх.
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлж буй улсад томоохон компани, худалдааны сүлжээ бий эсэх.
- Тухайн улс нь өөрийн төрийн далбааг тээвэрлэлтэд ашиглуулдаг эсэх.

Санхүүгийн салбар дахь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийг дараах хүчин зүйлүүдийг ашиглан судлах шаардлагатай:

- Гадаад улс, орнууд холбогдсон эсэх;
- Харилцагчийн болон түүний эрхэлж буй үйл ажиллаганы төрөл;
- Санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ;
- Эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх сувгууд.

Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын талаар нэмэлт мэдээ, мэдээллийг доорх эх сурвалжаас авч болно. ФАТФ–ийн зааварт эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулах ерөнхий мэдээллүүд агуулагдсан байдаг. RUSI гарын авлага нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний аргачлалын талаар ойлголт, нэмэлт мэдээ, мэдээллийг өгдөг. Энэ нь үндсэндээ аливаа улс, орны засгийн газарт зориулагдсанаас гадна санхүүгийн салбар дахь эрсдэлийг үнэлэх аргачлалын талаар заасан байдаг. Шинэ Америкийн аюулгүй байдлын төв (Center for New American Security)–өөс гаргасан заавар нь үндсэндээ санхүүгийн байгууллагуудад чиглэсэн байдаг.

FATF Guidance, National Money Laundering and Terrorist Financing Risk Assessment, February 2013:

[https://www.fatfgafi.org/media/fatf/content/images/National\\_ML\\_TF\\_Risk\\_Assessment.pdf](https://www.fatfgafi.org/media/fatf/content/images/National_ML_TF_Risk_Assessment.pdf)

Joshi, Dall, Dolzikova, Guide to Conducting a National Proliferation Financing Risk Assessment, RUSI Occasional Papers, May 2019:

[https://rusi.org/sites/default/files/20190513\\_guide\\_to\\_conducting\\_a\\_national\\_proliferation\\_financing\\_risk\\_assessment\\_web.pdf](https://rusi.org/sites/default/files/20190513_guide_to_conducting_a_national_proliferation_financing_risk_assessment_web.pdf)

Dr Jonathan Brewer, The Financing of WMD Proliferation: Conducting Risk Assessments, CNAS, November 2018:

<https://s3.amazonaws.com/files.cnas.org/documents/CNASReportFoPRiskAssessment-FINAL-min.pdf?mtime=20181030125029>

ФАТФ–ын үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн гол индикатор буюу шалгуур:

- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой аливаа иргэн, хуулийн этгээдэд хамаарах санхүүгийн гүйлгээнүүд.
- Хорлон сүйтгэх үйл ажиллагаатай холбоотой аливаа иргэн, хуулийн этгээдэд хамаарах санхүүгийн гүйлгээнүүд.
- Экспорт болон импортын бараа бүтээгдэхүүнүүдийн тээвэрлэлттэй холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн орчин сул хэрэгжиж буй орнуудаар дамжуулан хийгдсэн санхүүгийн гүйлгээнүүд.
- Ердийн тээвэрлэлтийн бүсээс гадуур хийгдсэн ачилтын төлбөр, тооцоотой холбоотой гүйлгээнүүд.
- Техникийн түвшинд нийцэхгүй барааг ачиж тээвэрлэх, жишээ нь хагас дамжуулагч үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг электроникийн үйлдвэрлэлгүй улсад хүргэх зэрэг орно.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын сул тогтолцоотой орнуудаар дамжийн хийгдсэн санхүүгийн гүйлгээнүүд.
- Гүйлгээнд хамрагдсан баримт бичиг дээр үндэслэн ачилтын үнийг тээвэрлэлтийн зардалтай харьцуулбал доогуур үнэлэгдсэн.
- Худалдааны бичиг баримт, санхүүгийн урсгал, тухайлбал нэр, компани, хаяг, эцсийн хүрэх газар гэх мэт мэдээллийн зөрүүтэй байх.
- Хэрэглэгчийн үйл ажиллагаа нь бизнесийн профайлтай нийцэхгүй байна, эсвэл эцсийн хэрэглэгчийн мэдээлэл нь эцсийн хэрэглэгчийн бизнес профайлтай таарахгүй байна. Бараа захиалах явцад тухайн эцсийн хэрэглэгчийн улсаас өөр гадаадын фирм, хувь хүмүүст бараа байрлагдах.
- Үйлчлүүлэгчид өгсөн мэдээлэл нь тодорхойгүй, бүрэн бус, нэмэлт мэдээлэл олж авахад ээдрээтэй байх.
- Шинэ үйлчлүүлэгч зээлийн гүйлгээний хүсэлтийг гаргаж шинэ дансны зөвшөөрлийг хүлээх.
- Худалдан авагч эсвэл гэрээт этгээд, түүний хаяг нь "таггалзсан хүмүүсийн" жагсаалтад орсон талуудын аль нэгтэй төстэй юмуу эсхүл экспортын хяналтын зөрчилтэй түүхтэй байх.
- Ачаа тээвэрлэх тойрог зам (боломжтой бол) ба / эсхүл санхүүгийн гүйлгээний эргэлтийн чиглэл.

- Гүйлгээ нь бараа солилцдог компаниудын төлөөлөгчид, өөрөөр хэлбэл ижил өмчлөгчид эсвэл удирдлага хоорондын холбоог харуулах.
- Гүйлгээ нь халхавчийн компаниудыг хамарна (жишээ нь компаниуд капиталжуулалтын түвшин өндөр биш эсхүл бусад халхавчийн компанийн үзүүлэлтүүдийг харуулах).
- Ачаа тээвэрлэх фирм нь бүтээгдэхүүний эцсийн цэг болох жагсаалтад багтсан болно.
- Аккредитив эсвэл бусад баримт бичгүүдийн эх хувь дээр тодорхойлогдоогүй талуудаас үүссэн мөнгөний төлбөр, төлбөрийг өгөх заавар.
- Ер бусын хэв маягийг илтгэх эсвэл ямар ч тодорхой зорилго тавиагүй шилжүүлгийн үйл ажиллагааны хэв маяг.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхийг бууруулах арга хэмжээ

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой санхүүгийн зорилт хориг арга хэмжээг дагаж мөрдөх үйл ажиллагааны журам, түүний аргачлалыг ТТЗ, ТЕГ, СМА, СЗХ–ны албан ёсны цахим хуудаснаас харах боломжтой. [www.nctc.gov.mn](http://www.nctc.gov.mn); [www.gia.gov.mn](http://www.gia.gov.mn); [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn); [www.frc.mn](http://www.frc.mn).

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийг илүү өргөн хүрээнд бууруулах талаар авч үзэхийн тулд түүний санхүүжилтийн асуудлыг авч үзэх хэрэгтэй:

- Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөр
- Харилцагч болон бизнесийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ
- Удирдах албан тушаалтнуудад чиглэсэн хяналтын үйл ажиллагаа
- Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны үйл явц
- Гүйлгээнд тавих хяналтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөр
- Тайлагнах үйл явц, түүний журам
- Газарзүй болон үйл ажиллагаа нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлд өртөж байгаа эсэхийг ойлгох

- Олон улсын санхүүгийн үйлчилгээ нь дотоодын зах зээлд нөлөөлж буй байдал
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээр зэхэж буй этгээдийн харилцан хамаарлыг харгалзах.
- Өөрийн бизнесийн үйл ажиллагааны эрсдэлийг ойлгох, үнэлэх  
Харилцагчийг таньж мэдэх
- Шинээр болон одоо байгаа харилцагчдын үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлсэн байх ёстой.
- Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд тусгай асуултуудыг оруулах. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл явц нь зарим үед хамааралгүй байж болно.
- Экспортын хяналтын журам хэрэгжиж байгаа эсэхийг тодруулах.
- Харилцагчийн эрхэлж буй бизнесийн ердийн үйл ажиллагаанд ямар эрсдэл байгааг тогтоох.
- Үй олноор хөнөөх зэвсэг бүтээхэд шаардагдах бараа, бүтээгдэхүүнтэй хамааралтай ажилладаг харилцагчдын эрсдэлийг үнэлэх.
- Харилцагчийн эрх буй үйл ажиллагааны газар зүйн байршил, харилцааг үнэлэх. Шууд бус байдлаар холбогдож байж болно.

Үй олноор хөнөөх зэвсэг бүтээхэд шаардагдах бараа, бүтээгдэхүүн болон үйл ажиллагааг тодорхойлох

- Бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй үйлчилгээ нь тавигдсан шаардлагуудыг хэрэгжүүлж байх.
- Бараа болон санхүүгийн үйлчилгээний эцсийн чиглэлийг тодорхойлох.
- Экспортыг хянах дэглэмийн жагсаалт болон бусад үйлдвэр / бүрэлдэхүүн хэсгүүдийн жагсаалт дээр зурах.
- Бусад салбартай холбогдож байгаа эсэх (даатгал / тээвэр).

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой НҮБ–ын АЗ–өөс гаргасан үндсэн тогтоолууд:

НҮБАЗ–өөс үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх чиглэлээр баталсан тогтоол: НҮБАЗ–ийн 1540 тогтоол. /НҮБАЗ–өөс 2004.04.28–ны өдөр баталсан/ болон дээрх тогтоолуудын залгамж бусад тогтоолууд хамаарна.

НҮБАЗ–өөс БНАСАУ–ын эсрэг хэрэгжүүлэхээр баталсан тогтоолууд:

НҮБАЗ–ийн 1718 тогтоол. /НҮБАЗ–өөс 2006.10.14–ний өдөр баталсан/

НҮБАЗ–ийн 1874 тогтоол. /НҮБАЗ–өөс 2009.06.12–ны өдөр баталсан/

НҮБАЗ–ийн 2087 тогтоол. /НҮБАЗ–өөс 2013.01.22–ны өдөр баталсан/

НҮБАЗ–ийн 2094 тогтоол. /НҮБАЗ–өөс 2013.03.07–ны өдөр баталсан/

НҮБАЗ–ийн 2270 тогтоол. /НҮБАЗ–өөс 2016.03.02–ны өдөр баталсан/

НҮБАЗ–ийн 2321 тогтоол. /НҮБАЗ–өөс 2016.11.30–ны өдөр баталсан/

НҮБАЗ–ийн 2371 тогтоол. /НҮБАЗ–өөс 2017.08.05–ны өдөр баталсан/

НҮБАЗ–ийн 2375 тогтоол. /НҮБАЗ–өөс 2017.09.11–ний өдөр баталсан/

НҮБАЗ–ийн 2397 тогтоол. /НҮБАЗ–өөс 2017.12.22–ны өдөр баталсан/ болон дээрх тогтоолуудын залгамж бусад тогтоолууд хамаарна.

НҮБАЗ–өөс Иран Улсын эсрэг хэрэгжүүлэхээр баталсан тогтоолууд:

НҮБАЗ–ийн 2231 тогтоол. /НҮБАЗ–өөс 2015.07.20–ны өдөр баталсан/

## **МОНГОЛ УЛС БА ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ**

### **Хориг арга хэмжээ**

НҮБ–ын Дүрмийн дагуу НҮБ–ын Аюулгүйн Зөвлөл нь олон улсад энх тайван, аюулгүй байдлыг бий болгох, түүнийг сахин хамгаалахтай холбоотой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр заасан. НҮБ–ын Дүрмийн 41–р зүйлд “НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлөөс зэвсэг, хүч хэрэглэхгүйгээр хориг арга хэмжээ болон бусад арга хэмжээ авч хэрэгжүүлж болно” гэж заасан.

Хориг арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна. Үүнд: Эдийн засаг, худалдааны хориг арга хэмжээ, зэвсгийн хориг, санхүүгийн хязгаарлалт, бараа бүтээгдэхүүний хязгаарлалт болон аяллын хориг гэх мэт. НҮБ–ын гишүүн улсын хувьд Монгол Улс нь НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол, түүний дотор хориг арга хэмжээ авахтай холбоотой тогтоолыг дагаж мөрдөх үүрэгтэй.

### **Терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ**

Терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол нь гишүүн улс орнуудыг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ хэрэгжүүлэхийг шаарддаг.

Санхүүгийн хориг арга хэмжээ нь дараах хоёр төрөлтэй байна:

1. Террорист этгээд, террорист байгууллагын жагсаалтад орсон этгээдийн хөрөнгөтэй холбоотой эсхүл тэдгээрт санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой асуудлаар санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ.

2. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд чиглэсэн санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ.

Терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах үндсэн дөрвөн хориг арга хэмжээний дэглэмийг удирдлага болгоно:

### **Терроризмтой холбоотой хориг арга хэмжээ:**

- НҮБ–ын АЗ–ийн 1267 /1999/ тогтоол болон түүнтэй холбоотой дагалдах бусад тогтоолууд (Энэ тогтоол нь Аль–Кайда, Талибан болон бусад террорист байгууллагуудын эсрэг чиглэсэн)

- НҮБ–ын АЗ–ийн 1373 /2001/ тогтоол (терроризмтой тэмцэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхтэй холбоотой)

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээ:

- НҮБ–ын АЗ–ийн 1718 /2006/ тогтоол болон түүнтэй холбоотой дагалдах бусад тогтоолууд (Энэ тогтоол нь БНАСАУ–ын үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн)
- НҮБ–ын АЗ–ийн 2231 /2015/ тогтоол болон түүнтэй холбоотой дагалдах бусад тогтоолууд (Энэ тогтоол нь Иран Улсын үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн)

Дээрх тогтоол, дагалдах бусад тогтоолын талаар болон тогтоолд тусгагдсан гол үүрэг, хариуцлагын талаар НҮБ–ын <https://www.un.org/securitycouncil/sanctions/information> цахим хуудаснаас дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

### **Хориг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн баримт бичиг, үүрэг хариуцлагын асуудал**

Монгол Улсын “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль”, Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”–ын дагуу Монгол Улсад буй хүн, хуулийн этгээд бүр санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Дээрх хууль, журмын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа аливаа хүн, хуулийн этгээд, эсхүл Монгол Улсын гадна байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээд бүр НҮБ–ын АЗ–өөс гаргасан эсхүл Монгол Улсын эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд хөрөнгө бий болгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, гүйлгээ хийхийг хориглоно. Монгол Улсын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”–д мөн мэдээлэх үүрэгтэй этгээдэд

дээрхтэй холбоотой үүрэг оноосон зохицуулалт бий.

Монгол Улс нь санхүүгийн зорилт хориг арга хэмжээний дэглэмийг дагаж мөрдөхийн тулд Засгийн газар болон НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн жагсаалт, холбогдох мэдээллийг үндэслэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэхүү жагсаалт нь тухай бүр шинэчлэгдэх бөгөөд [www.amlcft.mn](http://www.amlcft.mn); [www.gia.gov.mn](http://www.gia.gov.mn); [www.fiu.mn](http://www.fiu.mn) цахим хуудсанд байрласан.

#### Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үүрэг

Терроризмтой тэмцэх зөвлөл нь хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохицуулах эрх хэмжээтэй, Тагнуулын ерөнхий газар нь Монгол Улсад санхүүгийн зорилт хориг арга хэмжээг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага бол Санхүүгийн мэдээллийн алба нь мэдээлэх үүрэгтэй этгээдийн тайлан мэдээлэл болон хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавьдаг.

Терроризмтой тэмцэх зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн албанаас мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмж, аргачлалыг (гарын авлага) боловсруулж дээрх цахим хуудсанд байршуулсан болно.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1–т заасны дагуу санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг санхүүгийн бүх байгууллагууд, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид хэрэгжүүлнэ. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хууль тогтоомж, холбогдох дүрэм журмаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж тодорхой үйлчлүүлэгч, бүтээгдэхүүн, үйлчилгээнд эрсдэлээс үл хамааран зохих хянан нийцэл /МУТС тухай хуулийг дагаж мөрдөх/–ийн хөтөлбөр, дотоод журмыг бий болгож түүнийг дагаж мөрдөх ёстой.

Тухайлбал, Мэдээлэх үүрэгтэй этгээд нь:

- “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”–ын 5–р зүйлд заасан үүргийг биелүүлдхээ:
  - Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн

шууд болон шууд бус өмчлөл, эсхүл хяналтад байгаа аливаа бүх хөрөнгийг царцаах;

- Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн ашиг сонирхолын өмнөөс эсхүл шууд болон шууд бус, дангаар болон хэсэгчлэн хэлбэрээр хөрөнгө, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглох.
- Дараах асуудлаар мэдээлэх үүрэгтэй:
  - НҮБ–ын АЗ–өөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн нэр тохирсон;
  - НҮБ–ын АЗ–өөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн нэр тохирсон байж болзошгүй;
  - Хөрөнгө царцаасан тухай тус тус мэдээлэх үүрэгтэй.

Дээрхийг мэдээлэхдээ дараах зүйлсийг тусгасан байх шаардлагатай:

- Мэдээлэл нь өөрийн мэдлэг мэдээлэл, сэжиглэсэн гэж үзсэн асуудалд үндэслэсэн байх;
- Тухайн хүн, хуулийн этгээдийн талаар авагдсан, мэдэж байгаа бүхий л мэдээллийг тусгасан байх;
- Тухайн хүнтэй холбоотой хөрөнгийн хэмжээ, хэлбэрийг тусгасан байх;
- Хөрөнгийг царцаасан тохиолдолд тухайн гүйлгээний талаар болон хөрөнгө царцаасантай холбоотой мэдээллийг тусгасан байх шаардлагатай.

“Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгөтэй холбоотой мэдээлэл хүргүүлэх маягт”–ыг “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлал”–д заасан хавсралтын холбогдох маягтыг татаж ашиглана.

Монгол Улсад санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний дэглэмийг зөрчих, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 5.10 болон 11.29–ийн холбогдох заалтын дагуу дагуу торгууль ногдуулахаас гадна Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй

тэмцэх тухай хуулийн дагуу захиргааны арга хэмжээ авна. Үүнд: эрх, тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгох, удирдах албан тушаалтны эрхийг түдгэлзүүлэх, шилжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд зориулсан мэдээлэл

Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд өөрийг нь жагсаалтад оруулсантай холбогдуулан жагсаалтаас хасуулах талаар хүсэлт тавих эрхтэй. Тухайн хүсэлтийг шийдвэрлэх хүртэл хугацаанд хориг арга хэмжээ хүчинтэй үргэлжилнэ. Хэрэв тухайн хүн, хуулийн этгээдийг жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд гэж андуурсан, алдаатай нэр орсоноос үүдэн түүний хөрөнгө царцаагдсан тохиолдолд, нэгдүгээрт, мэдээлэх үүрэгтэй этгээдтэй холбогдож (арилжааны банк г.м) тайлбар гаргуулах эрхтэй. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчид хөрөнгө чөлөөлөхтэй холбоотой хүсэлтийг ТЕГ–т тавих талаар мэдэгдэх ёстой.

НҮБ–ын хориг арга хэмжээний жагсаалт: НҮБ–аас гаргасан хориг арга хэмжээний жагсаалтаас хасуулах тухай хүсэлтийг НҮБ–ын эрх бүхий байгууллагад тавина. НҮБ–ын эрх бүхий байгууллагын талаарх мэдээллийг НҮБ–ын албан ёсны цахим хуудаснаас харах боломжтой. Хэрэв тухайн жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд нь жагсаалтад оруулахад тавигдах шаардлагыг цаашид хангахгүй болсон гэж үзвэл Монгол Улсын Засгийн газраас НҮБ–ын АЗ, холбогдох Хоригийн хороонд жагсаалтаас хасуулах тухай хүсэлт гаргах эрхтэй.

Дотоодын хориг арга хэмжээний жагсаалт: Жагсаалтаас хасуулах тухай хүсэлтийг ТЕГ–т тавьж Монгол Улсын Засгийн газраар шийдвэрлүүлнэ.

Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл авахыг

хүсвэл [www.amlcft.mn](http://www.amlcft.mn); [www.gia.gov.mn](http://www.gia.gov.mn); [www.fiu.mn](http://www.fiu.mn) цахим хуудас болон 92263493, 92263017, 450068 дугаарын утсанд холбогдоно.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 дугаар  
сарын 25–ны өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 464

### ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23.2–т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”–ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журам батлагдсантай холбогдуулан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлал”–ыг боловсруулж батлахыг Тагнуулын ерөнхий газар (Д.Гэрэл)–т зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Тагнуулын ерөнхий газар (Д.Гэрэл)–т даалгаж, Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан нарт зөвлөсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30–ны өдрийн 54 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Сангийн сайд

Ч.ХҮРЭЛБААТАР

## **ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмын зорилго нь терроризм, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон эдгээр гэмт хэргийг санхүүжүүлэхийн эсрэг тэмцэхтэй холбогдуулж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл (цаашид “НҮБ–ын Аюулгүйн Зөвлөл” гэх)–өөс гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хүн, хуулийн этгээдийг террорист этгээдийн жагсаалт (цаашид “жагсаалт” гэх)–д оруулах, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, жагсаалтад оруулснаас үүсэх бусад харилцааг зохицуулах, гуравдагч этгээдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журмыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгоно.

1.3. Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан Монгол Улсад хамааралтай тогтоолд энэ журамд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалт, НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолыг дагаж мөрдөнө.

### **Хоёр. Хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах**

2.1. Энэ журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлалд заасан НҮБ–ын Аюулгүйн Зөвлөл болон түүний хорооноос гаргасан тогтоолын дагуу жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд холбогдох арга хэмжээг шууд хэрэгжүүлнэ.

2.2. Засгийн газар тагнуулын байгууллагын саналыг үндэслэн өөрийн санаачилгаар, эсхүл гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг үндэслэн НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолын зохих шалгуурт нийцсэн гэж үзэх үндэслэлтэй бол хүн, хуулийн этгээдийг даруй жагсаалтад оруулна.

2.3. Энэ журмын дагуу аливаа хүн, хуулийн этгээдтэй холбогдуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн эсэхээс үл хамааран тэдгээрийг жагсаалтад оруулж болно.

2.4. Тагнуулын байгууллага болон Терроризмтой тэмцэх зөвлөл жагсаалтыг холбогдох эрх бүхий байгууллага болон нийтэд шуурхай мэдээлж, албан ёсны цахим хуудсанд даруй байршуулна.

2.5. Уг жагсаалтыг нийтэд мэдээлснээс хойш тагнуулын байгууллага ажлын 15 өдрийн дотор жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд дараахь мэдээллийг хүргүүлнэ:

2.5.1. жагсаалт, түүний болзошгүй үр дагавар;

2.5.2. жагсаалттай танилцах, жагсаалтаас хасахтай холбоотой мэдээлэл;

2.5.3. тухайн хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах болсон баримтын нийтэд мэдээлж болох тодорхой хэсэг;

2.5.4. санхүүгийн үйлчилгээ авах болон хөрөнгийг ашиглах зөвшөөрөл авахтай холбоотой НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолын тухай мэдээлэл;

2.5.5. жагсаалтаас хасуулах тухай гомдлыг хүлээн авах НҮБ–ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооны мэдээлэл.

2.6. Тагнуулын байгууллага нь энэ журмын 2.2–т заасны дагуу хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах санал гаргахдаа эрх бүхий хяналт шалгалтын, хууль сахиулах болон холбогдох бусад байгууллага, ижил төстэй гадаадын байгууллага болон үндэслэл бүхий эх сурвалжийн мэдээ, мэдээллийг ашиглаж болно.

2.7. Тагнуулын байгууллага жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд болон түүний хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоохтой холбоотой аливаа ажиллагааг урьдчилан мэдэгдэлгүйгээр гүйцэтгэнэ.

2.8. Терроризмтой тэмцэх зөвлөл, тагнуулын байгууллага нь Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болон энэ журамд заасан санхүүгийн хориг арга хэмжээг бодлогын түвшинд хэрэгжүүлж, хяналт шалгалт, хууль сахиулах асуудал хариуцсан болон бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.

2.9. Энэ журмын 2.2–т заасны дагуу жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээд нь гадаад улстай холбоотой гэж тагнуулын байгууллага үзвэл шаардлагатай мэдээллийг тухайн улсын ижил төстэй байгууллагад гарган өгч болно.

### **Гурав. Жагсаалтад санал оруулах**

3.1. Тагнуулын байгууллага нь энэ журамд заасан НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол болон холбогдох бусад тогтоолд заасан шалгуурт нийцсэн гэсэн үндэслэлээр хүн, хуулийн этгээдийг шинээр жагсаалтад оруулах хангалттай нотлох баримт бүрдсэн гэж үзвэл энэ тухай саналаа Засгийн газарт танилцуулж, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох хороонд хүргүүлж болно.

3.2. Энэ журмын 3.1–д заасны дагуу жагсаалтад оруулах саналыг дараахь байдлаар боловсруулна:

3.2.1. жагсаалтад оруулахтай холбоотой НҮБ–ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос баталсан журмыг баримтлах;

3.2.2. жагсаалтад шинээр оруулах хүн, хуулийн этгээдийн нэртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл болон тухайн этгээдийг үнэн зөв тодорхойлоход шаардагдах хангалттай бодит мэдээллийг бүрдүүлж, Интерпол, НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлийн тусгай мэдэгдлийн шаардлагыг хангах;

3.2.3. хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах үндэслэл, шалтгаан, шалгуурт нийцсэн тухай дэлгэрэнгүй мэдээлэл, нотлох баримт бичиг болон жагсаалтад оруулахаар санал болгож байгаа хүн, хуулийн этгээд нь жагсаалтад байгаа бусад этгээдтэй холбоо хамааралтай эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий хэргийн танилцуулгыг бэлтгэх.

3.3. Монгол Улсыг жагсаалтад санал оруулж байгаа улс гэдгийг нийтэд мэдэгдэх эсэх асуудлаар тагнуулын байгууллага нь гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөнө.

### **Дөрөв. Жагсаалтаас хасах, хөрөнгө чөлөөлөх**

4.1. Энэ журмын 2.1–д заасны дагуу НҮБ–ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос гаргасан жагсаалттай холбогдуулж, уг жагсаалтаас хасах болон хөрөнгө чөлөөлөхтэй холбоотой дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.1.1. тагнуулын байгууллага жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийг жагсаалтад орох шалгуурт нийцээгүй, эсхүл цаашид нийцэхгүй гэж үзэх үндэслэлтэй бол саналаа Засгийн газарт танилцуулж НҮБ–ын Аюулгүйн Зөвлөл эсхүл түүний хороодод жагсаалтаас хасах тухай хүсэлт тавих;

4.1.2. жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд нь НҮБ–ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хороонд хандан жагсаалтаас хасах тухай гомдол гаргах;

4.1.3. хүн, хуулийн этгээдийн жагсаалтаас хасах тухай гомдлыг тагнуулын байгууллага хүлээн авч, НҮБ–ын Аюулгүйн Зөвлөл болон түүний холбогдох хорооны жагсаалтад орох шалгуурт нийцээгүй эсхүл цаашид нийцэхгүй гэж үзэх үндэслэлтэй бол түүний гомдлыг дэмжих.

4.2. Энэ журмын 2.2–т заасны дагуу жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдийг жагсаалтаас хасах болон түүний хөрөнгийг чөлөөлөхтэй холбоотой дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.2.1. жагсаалтад оруулсныг эс зөвшөөрч байгаа хүн, хуулийн этгээдийн гомдлыг тагнуулын байгууллага хянан шийдвэрлэх;

4.2.2. тагнуулын байгууллага энэ журмын 4.2.1–д заасан гомдлыг хянан шийдвэрлэхдээ шаардлагатай мэдээлэл авах, тодорхой асуултад хариулт авах зорилгоор гомдол гаргагчаас нэмэлт тайлбар авах;

4.2.3. тагнуулын байгууллага энэ журмын 4.2.1–д заасан гомдлыг хянахын зэрэгцээ, өөрийн санаачилгаар жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдийн мэдээллийг жагсаалтад оруулах шалгуурт нийцэх эсэхийг 5 жил тутам хянан баталгаажуулах;

4.2.4. тагнуулын байгууллага энэ журмын 4.2.1, 4.2.3–т заасан ажиллагааны үр дүнд жагсаалтад оруулах шалгуурт нийцээгүй, эсхүл цаашид нийцэхгүй гэж үзвэл уг хүн, хуулийн этгээдийг даруй жагсаалтаас хасах саналаа Засгийн газарт танилцуулах.

4.3. Хүн, хуулийн этгээд Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23.6–д, эсхүл энэ журмын 2.1, 2.2–т заасны дагуу хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээнд үндэслэлгүйгээр өртсөн гэж үзвэл тагнуулын байгууллагад хөрөнгийг чөлөөлөх тухай гомдол гаргана. Гомдлыг ажлын 30 өдрийн дотор хянаж, шийдвэрлэнэ.

4.4. Тагнуулын байгууллага энэ журмын 4.3–т заасны дагуу хүлээн авсан гомдлыг хянаж, гомдол гаргагч нь жагсаалтад ороогүйг нягтлан шалгасны үндсэн дээр хөрөнгийг чөлөөлөх шийдвэр гаргаж болно.

4.5. Энэ журмын 2.1, 2.2–т заасны дагуу жагсаалтад орсон этгээдийн мөнгөн хуримтлал, хөрөнгөөс тэдгээрийн үндсэн хэрэглээний зардал, тодорхой төрлийн төлбөр, нэн шаардлагатай зардал, үйлчилгээний хураамж буюу гэнэтийн зайлшгүй зардал зэргийг төлж барагдуулах шаардлагатай эсэх асуудлыг тагнуулын байгууллага хянаж, шийдвэрлэнэ.

4.6. Энэ журмын 4.5–д заасан шийдвэрийг НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолд заасны дагуу хэрэгжүүлнэ.

4.7. НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлийн болон энэ журамд заасан жагсаалтаас хассан, эсхүл хөрөнгийг чөлөөлсөн тухай шийдвэр гарсан даруй тагнуулын байгууллага нь холбогдох хүн, хуулийн этгээд, санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч бусад этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

4.8. Тагнуулын байгууллага, Терроризмтой тэмцэх зөвлөл нь жагсаалтаас хассан, хөрөнгийг чөлөөлсөн тухай энэ журмын 4.7–д заасан шийдвэрийг даруй хэрэгжүүлж, албан ёсны цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

4.9. Тагнуулын байгууллага энэ журамд заасан үүргээ хэрэгжүүлэх явцад хууль ёсны гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.9.1. энэ журмын 2.1, 2.2–т заасан жагсаалтад оруулсны улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээдийн хөрөнгө чөлөөлүүлэхийг хүссэн гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх;

4.9.2. энэ журмын 4.9.1–д заасан гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор шийдвэрлэж, холбогдох талуудад мэдэгдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд энэ хугацааг 30 хүртэл өдрөөр сунгах.

4.10. Тагнуулын байгууллага энэ журмын 4.9–д заасан гомдлыг хянан шийдвэрлэх зорилгоор нэмэлт мэдээлэл авах, тодорхой асуултад хариулт авахын тулд гомдол гаргагч болон холбогдох бусад этгээдийг дуудан ирүүлэх эрхтэй.

4.11. Энэ журмын дагуу тагнуулын байгууллагын гаргасан аливаа шийдвэрийг хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн этгээд зохих эрх бүхий байгууллагаар хянуулах эрхтэй.

### **Тав. Хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох болон хориглох**

5.1. Хүн, хуулийн этгээд нь хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогын хөдөлгөөнийг тухайн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр нэн даруй зогсоож, тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдэгдэнэ.

5.2. Хүн, хуулийн этгээд нь хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, түүнтэй холбоотой, эсхүл түүнийг төлөөлж байгаа этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

5.3. Хүн, хуулийн этгээдээс энэ журмын 5.1, 5.2–т заасан үүргээ хэрэгжүүлэхдээ дор дурдсан хөрөнгийг адилтган үзэж, хөдөлгөөнийг зогсооно:

5.3.1. зөвхөн тодорхой террорист үйлдэл, хуйвалдаан, заналхийлэлд хамаарах бус, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүх мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;

5.3.2. жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдээс бүхэлд нь буюу хэсэгчлэн, дангаараа буюу хамтран, шууд буюу шууд бусаар эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүх мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;

5.3.3. энэ журмын 5.3.1, 5.3.2–т заасан хөрөнгөөс бий болсон мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө, мөн жагсаалтад орсон хүн, хуулийн

этгээдийн заавраар, тэдгээрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийн мөнгөн хуримтлал буюу бусад хөрөнгө;

5.3.4. НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолоор жагсаалтад оруулсан усан тээврийн хэрэгсэл.

5.4. Хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоосон хүн, хуулийн этгээдийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой төлбөр, хүүгийн болон бусад төлбөрийг мөн адил зогсооно.

5.5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1–д заасан мэдээлэх үүрэгтэй этгээд энэ журмын дагуу хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, түүнтэй холбогдсон бусад арга хэмжээ авсан бол энэ талаар тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албанд энэ журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлалд заасан маягтын дагуу мэдээлнэ.

5.6. Хүн, хуулийн этгээд энэ журмын 5.5–д заасны дагуу тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албаны шаардсан нэмэлт мэдээллийг даруй гаргаж өгөх үүрэгтэй.

5.7. Санхүүгийн мэдээллийн алба энэ журмын 5.6–д заасны дагуу авсан мэдээллийг тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

### **Зургаа. Мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавих шаардлага**

6.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1–д заасан мэдээлэх үүрэгтэй этгээд нь дараахь шаардлагыг мөрдөнө:

6.1.1. жагсаалтад орсон, хасагдсан хүн, хуулийн этгээд болон зогсоосон хөрөнгийг чөлөөлөх мэдээлэлтэй өөрийн харилцагчдын мэдээллийг тулгаж шалгасны үндсэн дээр үйлчилгээ үзүүлэх;

6.1.2. жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хяналтад байгаа, түүний заавраар үйл ажиллагаа явуулдаг эсэхийг тогтоох санхүүгийн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх шалгуурыг бий болгож харилцагчийг таньж мэдэх ажиллагаанд ашиглах;

6.1.3. жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хяналтад байгаа,

түүний заавраар санхүүгийн гүйлгээ хийж байгаа эсэхийг тогтоох санхүүгийн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх шалгуурыг бий болгож гүйлгээний хяналтын ажиллагаанд ашиглах;

6.1.4. өндөр эрсдэлтэй харилцагчид болон түүний харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан ажиллагааг хэрэгжүүлэх;

6.1.5. холбогдох ажилтнуудад санхүүгийн зорилтот арга хэмжээ болон холбогдох хууль, тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах.

6.2. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь үйл ажиллагаандаа ашиглаж байгаа жагсаалтаа НҮБ–ын Аюулгүйн Зөвлөл болон Засгийн газраас баталсан дотоодын жагсаалтад нийцүүлэн тогтмол шинэчилнэ.

Хувийн № 01



МОНГОЛ УЛСЫН  
ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 18 өдөр

дугаар А/34

Улаанбаатар хот

**Аргачлал батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Журам батлах тухай" Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 464 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлал"-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Аргачлалыг хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд танилцуулах, холбогдох заавар, зөвлөмж өгч ажиллахыг Эдийн засгийн тагнуулын газар /Н.Баясгалан/, Терроризмтой тэмцэх зөвлөлийн ажлын алба /Л.Энхбаяр/-нд даалгасугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Э.Эрдэнэд даалгасугай.

ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Д.ГЭРЭЛ

Хуулбар үнэн:  
Ажилтан, дэслэгч



9131701  
ТУС0846

**ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН  
ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ  
АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
АРГАЧЛАЛ**

## **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГАЧЛАЛ**

### **ТОВЧЛОЛ**

### **УДИРТГАЛ**

1. Олон улсад хүлээсэн үүрэг
  - 1.1 Нэгдсэн үндэстний байгууллагын аюулгүйн зөвлөлийн тогтоол
  - 1.2 НҮБАЗ–ийн хориг арга хэмжээний хороод
  - 1.3 ФАТФ–ын стандарт
2. Үүрэг хариуцлага
  - 2.1 Тагнуулын ерөнхий газар
  - 2.2 Гадаад харилцааны яам
  - 2.3 Хяналт шалгалтын байгууллага
  - 2.4 Терроризмтой тэмцэх зөвлөл
3. Жагсаалтад оруулах үйл явц
  - 3.1 Нүбаз–ийн жагсаалт
    - 3.1.1 Нүбаз болон түүний хороодод жагсаалтад оруулахыг санал болгох
  - 3.2 Дотоодын жагсаалт
  - 3.3 Гадаад улс орны засгийн газрын хүсэлт
  - 3.4 Гадаад улс орны засгийн газарт гаргах хүсэлт
    - 3.5.1 Гадаад улс орны засгийн газарт хүсэлт гаргах үйл явц
4. Хянах, жагсаалтаас хасах
  - 4.1 Нүбаз эсхүл түүний хороодод жагсаалтаас хасах хүсэлт хүргүүлэх
    - 4.1.1 ТЕГ–ын хүсэлт
    - 4.1.2 Жагсаалтад буй хүн, хуулийн этгээдийн хүсэлт
  - 4.2 Дотооддоо хянаж жагсаалтаас гаргах
  - 4.3 Жагсаалтын алдаатай нэрсийг нягтлан, залруулах туслалцаа
  - 4.4 Гуравдагч этгээд
5. Жагсаалтад оруулсан, хассан болон хөрөнгө чөлөөлсөн тухай мэдэгдэл
  - 5.1 Хориг арга хэмжээний жагсаалт
  - 5.2 мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдэгдэх
  - 5.3 Жагсаалтад оруулсан хүн эсхүл хуулийн этгээдэд мэдэгдэх
  - 5.4 Мэдэгдэх үйл явц
  - 5.5 Хөрөнгө чөлөөлөх тухай мэдэгдэх
6. Хориглох ба зөвшөөрөх
  - 6.1 Хориглох

- 6.1.1 Хөрөнгө захиран зарцуулахыг хориглох (хөрөнгө царцаах)
- 6.1.2 Хөрөнгө олгохыг хориглох
- 6.1.3 Санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглох
- 6.2 Зөвшөөрөх
  - 6.2.1 Зөвшөөрөх үйл явц
  - 6.2.2 Нүбаз–ийн болон хороодын мэдэгдэл ба зөвшөөрөл
- 7. Тайлагнах
- 8. Хяналт шалгалт ба хэрэгжилт
  - 8.1 Хяналтын эрх мэдэл
    - 8.1.1 Мэдээлэл ба баримт бичиг шаардах
    - 8.1.2 Газар дээрх шалгалт
  - 8.2 Хэрэгжилтийг хангах хувилбар
  - 8.3 Эрсдэлийн үнэлгээ
    - 8.3.1 Терроризмыг санхүүжүүлэх эрсдэл
    - 8.3.2 Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээний эрсдэл
- 9. Хориг арга хэмжээний хэрэгжилтийг хангах
- 10. Нууцлал ба тоон мэдээллийн хамгаалалт
  - 10.1 Нууцлал
  - 10.2 Мэдээлэл хадгалалт
- 11. Мэдээлэл солилцоо
- 12. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Хавсралт 1

Маягт 1

Маягт 2

Маягт 3

Маягт 4

Маягт 5

Маягт 6

Маягт 6

Маягт 7

Маягт 8

Маягт 9

Маягт 10

Хүснэгт а

НББСЗҮҮ–дэд зориулсан МУТС эрсдэлд суурилсан  
аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага

---

## **ТОВЧЛОЛ**

<b>МУТСТ</b>	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
<b>АРГ</b>	Мөнгө угаахын эсрэг Ази, Номхон Далайн Бүлэг
<b>ХТС</b>	Харилцагчаа таних судалгаа
<b>ФАТФ</b>	Олон Улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
<b>СМА</b>	Санхүүгийн мэдээллийн алба
<b>ТЕГ</b>	Тагнуулын ерөнхий газар
<b>ТТЗ</b>	Терроризмтой тэмцэх зөвлөл
<b>ҮОХЗДС</b>	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх
<b>ТС</b>	Терроризмыг санхүүжүүлэх
<b>СЗХАХ</b>	Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ
<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэсний Байгууллага
<b>НҮБАЗ</b>	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл
<b>НҮБАЗТ</b>	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн Тогтоол

## **Удиртгал**

Үйл ажиллагааны энэхүү аргачлалыг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны журамд тусгагдсан санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх орчинг бүрдүүлэхэд дэмжлэг болох зорилгоор боловсруулав. Энэ нь НҮБАЗ–ийн тогтоол болон ФАТФ–ын зөвлөмжийн дагуу тогтоох терроризм, ҮОХЗД–ийн эсрэг авах санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хамаарна.

Үйл ажиллагааны энэхүү аргачлалын хэрэгжилтийг хангахдаа аливаа нэмэлт өөрчлөлт эсхүл шинэчилсэн мэдээллийн талаар СМА зэрэг бусад байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр ТЕГ хэрэгжүүлнэ.

### **1. Олон улсад хүлээсэн үүрэг**

Монгол Улс нь НҮБ–ын гишүүний хувьд НҮБ–ын дүрмийн дагуу санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ зэрэг Аюулгүйн зөвлөлийн аливаа шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй. Түүнчлэн, Монгол Улс нь Евро–Азийн бүлгийн ажиглагч гишүүн, АРГ–ийн гишүүн бөгөөд ФАТФ–тай жиших Европ/Ази, Ази/Номхон далайн бүсийн байгууллагуудын гишүүн орон билээ. 2004 онд АРГ–д гишүүнээр элсэн орсноос хойш Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийг эсрэг тогтолцоогоо тууштай бэхжүүлж ФАТФ–ын стандартын хэрэгжилтийг хангахад үлэмж амжилт гаргасан билээ.

#### **1.1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн тогтоол**

НҮБАЗ–ийн тогтоолд хориг арга хэмжээ авах тухай тогтоол хамрагддаг. Хориг арга хэмжээ гэдэг нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хадгалж хамгаалах зорилгоор Аюулгүйн зөвлөлөөс баталсан арга хэмжээг хэлнэ. Эдгээр арга хэмжээг авахдаа зэвсэгт хүчнийг оролцуулдаггүй. НҮБ–ын дүрмийн VII бүлгийн дагуу Аюулгүйн зөвлөлөөс тодорхой улс гүрэн, хүн, хуулийн этгээдэд эдийн засгийн болон бусад хориг арга хэмжээ ногдуулах зэрэг арга хэмжээ авдаг. Эдгээр хориг арга хэмжээнд хилийн хориг тогтоох, бараа, бүтээгдэхүүний хязгаарлалт болон зэвсгийн хориг зэрэг ордог. Санхүүгийн зорилтот арга хэмжээ гэдэг нь жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдийн хөрөнгө царцаах

зэрэг санхүүгийн хязгаарлалт тавьдаг хориг арга хэмжээний өөр нэг төрөл юм. НҮБАЗ–ийн тогтоолыг НҮБ–ын гишүүн улс орон бүр биелүүлэх үүрэгтэй.

НҮБАЗ–ийн хориг арга хэмжээний тогтоолын бүрэн жагсаалтыг НҮБАЗ–ийн <https://www.un.org/securitycouncil/sanctions/information>. цахим хуудаст байршуулсан болно.

Монгол Улс Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын дагуу терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийн эсрэг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авдаг. Эдгээр хориг арга хэмжээний гурав нь терроризмтой тэмцэхтэй холбоотой, үлдсэн хоёр нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэхтэй холбоотой юм.

### **НҮБАЗТ 1267, 1989 болон 2253**

Эдгээр тогтоолоор (мөн эдгээрийг залгамжилж гарах бусад тогтоолоор) Исламын улс /цаашид “ISIL” гэх/ болон Аль–Каида–тай холбоотой хүн, хуулийн этгээдийн эсрэг хориг арга хэмжээ авна. Хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг ISIL болон Аль–Каида–ийн хориг арга хэмжээний хороо гаргана.

### **НҮБАЗТ 1267 болон 1988**

Эдгээр тогтоолоор (мөн эдгээрийг залгамжилж гарах бусад тогтоолоор) Афганистаны энх тайван, тогтвортой болон аюулгүй байдалд заналхийлэх Талибантай холбоотой хүн, хуулийн этгээдийн эсрэг хориг арга хэмжээ авна. Жагсаалтыг Талибаны хориг арга хэмжээний хороо гаргана.

### **НҮБАЗТ 1718**

НҮБАЗТ 1718 (мөн эдгээрийг залгамжилж гарах бусад тогтоолоор) БНАСАУ–ын цөмийн зэвсгийн хөтөлбөртэй холбогдуулж БНАСАУ–д эдийн засгийн хориг арга хэмжээ авна. Мөн БНАСАУ–ын засгийн газар болон Солонгосын Ажилчны намтай холбоотой хүн, хуулийн этгээдэд БНАСАУ–ын хориг арга хэмжээний хорооноос гаргасан жагсаалтын дагуу санхүүгийн зорилтот арга хэмжээ авдаг. Уг тогтоолыг залгамжилж гарсан НҮБАЗТ 2270–ын 32–ын дагуу санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах бусад хүн, хуулийн этгээдийг тодорхойлж эдгээрийг жагсаалтанд оруулах болсон үндэслэлээ томьёолохыг улс орнуудаас шаарддаг.

### **НҮБАЗТ 1737 болон 2231**

НҮБАЗТ 1737–оор цөмийн зэвсгийн хөтөлбөртэй холбогдуулж Иранд хориг арга хэмжээ ногдуулдаг. НҮБАЗТ 1737–ын дараа батлагдсан НҮБАЗТ 2231–д Хамтарсан иж бүрэн үйл ажиллагааны хөтөлбөрийг батлаж урьд өмнө ногдуулсан зарим хориг арга хэмжээг цуцалсан. НҮБАЗТ 2231–ээр зарим хүн, хуулийн этгээдэд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг ногдуулдаг. Мөн томьёолсон нөхцөл шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд НҮБАЗТ 1737–ын зарим элементийг буцааж хүчин төгөлдөр болгоно гэж заасан байдаг.

## **1.2 НҮБАЗ–ийн Хориг арга хэмжээний хороо**

Хориг арга хэмжээний хэрэгжилтийг хянаж НҮБАЗ болон улс орнуудыг холбогч үүрэг бүхий хориг арга хэмжээний хороодыг байгуулдаг. Хороодын үйл ажиллагааг дэмжиж хориг арга хэмжээний хэрэгжилтийн мониторинг, хяналт шалгалт болон тайланг хариуцах экспертийн болон хяналтын бүлгийг байгуулж ажиллуулдаг.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын дагуу авах хориг арга хэмжээтэй холбоотой дараах Хороод байдаг. Үүнд:

- 1267, 1989 болон 2253 (ISIL болон Аль–Каида) тогтоолын дагуу байгуулагдсан АЗ–ийн Хороо
- 1988 (Талибан) тогтоолын дагуу байгуулагдсан АЗ–ийн Хороо
- 1718 (БНАСАУ) тогтоолын дагуу байгуулагдсан АЗ–ийн Хороо.

Хороодын бүрэн эрх, журам, холбогдох албадууд болон боловсруулан гаргасан удирдамжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягнаас авна уу:

<https://www.un.org/securitycouncil/sanctions/information>

Тогтоол 1373 (уг горимыг Монгол Улс зохицуулах) буюу Ираны (уг горимыг Аюулгүйн зөвлөл зохицуулах) асуудлаарх хориг арга хэмжээний хороо байдаггүй болно.

## **1.3 ФАТФ–ын стандарт**

ФАТФ нь олон улсын санхүүгийн тогтолцооны бүрэн бүтэн, аюулгүй байдалд заналхийлэх мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад аюултай тэмцэхэд чиглэгдсэн хууль эрх зүйн, зохицуулалтын болон үйл ажиллагааны арга хэмжээний үр дүнтэй хэрэгжилтийг хангах стандарт тогтоодог засгийн газар хоорондын байгууллага юм.

ФАТФ–ын стандарт нь санхүүгийн тогтолцооны бүрэн бүтэн байдлыг хамгаалж санхүүгийн гэмт хэргийн эсрэг засгийн газраас арга хэмжээ авах хамгаалалтын арга хэрэгсэл зэрэг олон улсын стандарт хэмээн хүлээн

зөвшөөрөгдсөн 40 зөвлөмжөөс бүрддэг. Мөн Шууд хэрэгжилтын 11 үр дүнгээс бүрдэх үнэлгээний аргачлалыг ФАТФ–аас боловсруулан хэрэгжүүлдэг.

ФАТФ болон АРГ зэрэг түүний бүсийн байгууллагаас өөрийн гишүүн орнууддаа ФАТФ–ын стандартын хэрэгжилтийн түвшинг тогтоох харилцан үнэлгээг байнга хийдэг. Харилцан үнэлгээгээр тухайн орны үр дүнтэй байдал хийгээд ФАТФ–ын стандартын хэрэгжилтийг хянадаг.

Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээтэй холбоотой ФАТФ–ын стандартад дараах орно. Үүнд:

### **Зөвлөмж 6 – терроризм болон терроризмын санхүүжилттэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ**

Терроризм болон терроризмын санхүүжилтээс сэргийлж таслан зогсоохтой холбоотой НҮБАЗ–ийн тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс улс орнууд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авна. Уг тогтоолоор улс орнуудад дараах хүн, хуулийн этгээдийг санхүүгийн болон бусад хөрөнгийг яаралтай царцаах, тэдэнд болон хамаарал бүхий этгээдэд шууд болон шууд бусаар санхүүгийн хөрөнгө эсхүл санхүүгийн үйлчилгээг хүргүүлэхгүй байх. Үүнд: (1) НҮБ–ын дүрмийн Бүлэг VII–ийн дагуу НҮБАЗ–өөс эсхүл АЗ–ийн эрх мэдлийн дагуу 1267, 1988, 1989, 2253 тоот болон эдгээрийг залгамжлан гарах тогтоолоор жагсаалтанд оруулсан; эсхүл (ii) 1373 тоот тогтоолын дагуу тухайн улс орны дотоодын жагсаалтанд орсон.

### **Зөвлөмж 7 – үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхээс сэргийлэх, таслан зогсоохтой холбоотой НҮБАЗ тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор улс орнууд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авна. Уг тогтоолоор улс орнуудад дараах хүн, хуулийн этгээдийг санхүүгийн болон бусад хөрөнгийг яаралтай царцаах, тэдэнд болон хамаарал бүхий этгээдэд шууд болон шууд бусаар санхүүгийн хөрөнгө эсхүл санхүүгийн үйлчилгээг хүргүүлэхгүй байх. Үүнд: (1) НҮБ–ын дүрмийн Бүлэг VII–ийн дагуу НҮБАЗ–өөс эсхүл АЗ–ийн эрх мэдлийн дагуу 1718 (БНАСАУ) болон 2231 (Иран) тоот болон эдгээрийг залгамжлан гарах тогтоолоор жагсаалтанд оруулсан

### **Шууд хэрэгжилтийн үр дүн 10**

ҮОХЗДБТТХ–ийн 3.1.5 Террорист этгээд, тэдгээрийг санхүүжүүлэгчид хөрөнгө босгох, шилжүүлэх, ашиглах болон ашгийн бус байгууллагаар дамжин уг үйл ажиллагааг явуулахаас урьдчилан сэргийлэх.

### **Шууд хэрэгжилтийн үр дүн 11**

НҮБАЗ–ийн холбогдох тогтоолын дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой хүн, хуулийн этгээдийн хөрөнгө босгох, шилжүүлэх болон ашиглахаас урьдчилан сэргийлэх.

## **2. Үүрэг хариуцлага**

### **2.1. Тагнуулын ерөнхий газар**

Тагнуулын ерөнхий газар нь /цаашид “ТЕГ” гэх/ Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн дагуу хориг арга хэмжээг авах эрх бүхий байгууллага болно. Санхүүгийн хориг арга хэмжээтэй холбоотой асуудлыг ТЕГ–ын Эдийн засгийн тагнуулын газрын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хэлтэс, Терроризмтой тэмцэх зөвлөлийн /цаашид “ТТЗ” гэх/ Ажлын албаны Хориг арга хэмжээ хариуцсан тасгийн холбогдох албан тушаалтан хариуцна. Хориг арга хэмжээний асуудал хариуцсан албан тушаалтантай [amlcft@gia.gov.mn](mailto:amlcft@gia.gov.mn); [tfs@nctc.gov.mn](mailto:tfs@nctc.gov.mn) хаягаар харилцана. ТЕГ, ТТЗ нь хориг арга хэмжээтэй холбоотой болон хариуцах албан тушаалтантай холбоо барих мэдээлэл бүхий [www.gia.gov.mn](http://www.gia.gov.mn); [www.nctc.gov.mn](http://www.nctc.gov.mn) цахим хуудастай байна. ТЕГ нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- НҮБАЗ–ийн 1373 тоот тогтоолын дагуу хүн, хуулийн этгээдийн дотоодын жагсаалт гаргах;
- НҮБАЗ–ын хороод болон гадаад улс орны засгийн газарт жагсаалтанд хамруулах хүсэлт гаргах;
- Хүн, хуулийн этгээдийг жагсаалтанд оруулах гадаад улс орны хүсэлтэд хариу өгөх;
- НҮБ–ын болон дотоодын жагсаалтад оруулсан болон жагсаалтаас хассан тухай мэдээлэх;
- Хориг арга хэмжээний талаарх мэдээллийг олон нийтэд хүргүүлэх;
- Дотоодын жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдийг маргааныг шийдвэрлэх;
- Маргааныг хэлэлцэж шаардлагатай бол НҮБАЗ–д жагсаалтаас хасах саналыг дэмжиж хүргүүлэх;
- Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний үр дүнд царцаагдсан хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн ашиг сонирхлын асуудлыг шийдвэрлэх;
- Хөрөнгө эсхүл санхүүгийн үйлчилгээ авах хүсэлтийг шийдвэрлэх;
- Жагсаалтад буй алдаатай нэрсийн асуудлыг шийдвэрлэж хөрөнгө чөлөөлөх захирамж гаргах.

## **2.2. Гадаад харилцааны яам**

Гадаад харилцааны яам нь гадаад улс орны засгийн газар болон НҮБАЗ–ийн хороодтой хориг арга хэмжээний талаар албан ёсоор мэдээлэл солилцох үүрэгтэй байна.

Мэдээлэл солилцооны албан бус суваг (цагдаагийн байгууллага хоорондын, тагнуулын байгууллага хоорондын хамтын ажиллагаа) болон олон улсын эрх зүйн хамтын ажиллагаа (эрүүгийн гэмт хэрэг болон хорих ял шийтгүүлсэн хүн шилжүүлэх асуудлаарх эрх зүйн харилцан туслалцаа) нь Гадаад харилцааны яаманд хамаарахгүй ба бусад хүчин төгөлдөр зохицуулалт, хэлэлцээрээр зохицуулагдана.

Гадаад харилцааны яам нь дараах мэдээллийг өөрийн албан сувгаар дамжуулан солилцоно. Үүнд:

- НҮБ–ын жагсаалт болон жагсаалтаас хассан мэдээллийг хүлээн авах;
- НҮБ–ын хороодод жагсаалтад оруулах тухай Монгол улсын Засгийн газрын саналыг хүргүүлэх;
- НҮБ–ын холбогдох хороодод НҮБ–ын жагсаалттай холбоотой маргаантай асуудлыг хүргүүлэх;
- НҮБ–ын жагсаалттай холбогдуулж НҮБ–ын холбогдох хороодод хөрөнгө болон санхүүгийн үйлчилгээ авах хүсэлт эсхүл мэдэгдлийг хүргүүлэх;
- Гадаад улс орноос жагсаалтанд оруулах хүсэлтийг хүлээн авах;
- Жагсаалтанд оруулах тухай Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийг гадаад улс орны засгийн газарт хүргүүлэх.

Мэдээлэл солилцох дээрх үйл ажиллагааг явуулахдаа ТЕГ, ТТЗ–д мэдэгдэх, мэдээлэл солилцох дээрх үйл ажиллагааг ТЕГ, ТТЗ–өөс дипломат бус сувгаар нэгэн зэрэг явуулж болно. Ингэснээр НҮБАЗ–ийн тогтоолын дагуу хориг арга хэмжээг шуурхай авах боломжийг олгоно.

### **2.3. Хяналт шалгалтын байгууллага**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиар зохицуулагдах санхүүгийн болон бусад салбарт санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний хэрэгжилтийг хянаж хангах үүрэг бүхий хяналт шалгалтын байгууллагад дараах байгууллагууд орно. Үүнд:

- Банкны бизнес эрхлэгч санхүүгийн байгууллагын хувьд Монгол Банк;
- Банк бус санхүүгийн байгууллага, даатгалын компани болон аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компани, үнэт цаасны зах зээлийн аж ахуйн нэгж, хадгаламж зээлийн хоршоо болон үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, үл хөдлөх хөрөнгө худалдан авч борлуулах хэлцэлд оролцогч бизнес эрхлэгчдийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо;
- Хуулийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээдийн хувьд Монголын хуульчдын холбоо;
- Нотариатчдын хувьд Монголын нотариачдын танхим;
- Нягтлан бодогчдын хувьд Мэргэшсэн нягтлан бодогчдын институт;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар зохицуулагдах бусад бүх хүн, хуулийн этгээдийн хувьд Санхүүгийн мэдээллийн алба байна.

Дээр дурдсан санхүүгийн болон холбогдох бусад салбараас гадна бусад салбар, олон нийтийн хувьд хориг арга хэмжээний талаарх мэдээлэл сурталчилгаа, мониторинг болон хэрэгжилтийг ТТЗ хариуцна. Хяналт шалгалтын уялдааг ТТЗ–өөс хангана.

#### **2.3.1. Хяналт шалгалтын уялдаа холбоог хангах**

Мөнгө угаах болон терроризмын санхүүжилттэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөл нь хориг арга хэмжээний хяналт шалгалт, хэрэгжилтийг хангах хяналт шалгалтын байгууллагуудын үйл ажиллагааны түвшний

зохицуулалтыг хэрэгжүүлнэ. Мөнгө угаах болон терроризмын санхүүжилттэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөл нь тухай бүр ХАЗ–ийн даргын шийдвэрээр хуралдана. Хориг арга хэмжээний хяналт шалгалтын асуудал ХАЗ болон ТТЗ–ийн хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад байна.

Мөнгө угаах болон терроризмын санхүүжилттэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2–т заасан байгууллагын төлөөлөл оролцоно.

#### **2.4. Терроризмтой тэмцэх зөвлөл**

ТТЗ нь Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6–д зааснаар “хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохицуулах” эрх хэмжээтэй байхаар хуульчилсан. Иймд ТТЗ нь санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнийг хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй байна.

ТТЗ–ийн Ажлын алба нь Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх тасагтай бөгөөд тус тасгаас хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд төр болон хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог хариуцан ажиллана.

Хориг арга хэмжээний асуудал хариуцсан албан тушаалтантай [tfs@nctc.gov.mn](mailto:tfs@nctc.gov.mn) хаягаар харилцана. ТТЗ, ТЕГ нь хориг арга хэмжээтэй холбоотой болон хариуцах албан тушаалтантай холбоо барих мэдээлэл бүхий [www.gia.gov.mn](http://www.gia.gov.mn); [www.nctc.gov.mn](http://www.nctc.gov.mn) цахим хуудастай байна.

### **3. Жагсаалтанд оруулах үйл явц**

#### **3.1. НҮБАЗ–ийн жагсаалт**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг болон 23.6 дахь хэсэг, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын 2.1–т заасны дагуу НҮБАЗ эсхүл түүний аль нэг хорооноос гаргасан жагсаалт нэн даруй Монгол Улсад хүчин төгөлдөр болно. НҮБАЗ эсхүл түүний хороодоос цуцлагдах хүртэл жагсаалт хүчин төгөлдөр хэвээр байна.

### **3.1.1. НҮБАЗ болон түүний хороодод жагсаалтад оруулахыг санал болгох**

Терроризм (НҮБАЗТ 1373–оос бусад) болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээний дагуу НҮБ болон түүний хороод хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулна.

Терроризм (НҮБАЗТ 1373–оос бусад) болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой НҮБАЗ тогтоолын шалгуурт нийцэж буй талаар итгэл үнэмшилтэй байх хангалттай үндэслэл байна гэж ТЕГ үзвэл НҮБАЗ эсхүл холбогдох хороонд жагсаалтад оруулах санал хүргүүлж болно.

Жагсаалтад оруулах шалгуурт нийцэж буйг нотлох хангалттай нотолгоо байгаад итгэлтэй нөхцөлд л ТЕГ санал хүргүүлнэ. Саналыг Гадаад харилцааны ямаар дамжуулан НҮБАЗ эсхүл хороодод хүргүүлнэ. Жагсаалтад оруулахыг санаачлагч Монгол Улсын статусыг олон нийтэд зарлах эсэхийг ТЕГ нь Гадаад харилцааны яамтай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Жагсаалтад оруулах санал боловсруулахдаа ТЕГ **Хэргийн талаарх мэдэгдэл (Маягт 1)** бүрдүүлнэ. Уг мэдэгдэлд жагсаалтад оруулахтай холбоотой бүхий л мэдээлэл болох холбогдох этгээдийн талаарх мэдээлэл, жагсаалтад оруулах үндэслэл болон үндэслэл болгож буй мэдээ, мэдээлэл зэрэг орно. Мэдэгдэлд нотолгоо болох баримт бичгийг хавсаргана. Энэхүү мэдээлэл нь Интерпол–НҮБАЗ–ийн тусгай мэдэгдэл гаргах шаардлагыг хангасан эсэхийг ТЕГ баталгаажуулна.

Жагсаалтад оруулах журамтай холбоотой болон жагсаалтад оруулах хүсэлтэд тусгах тодорхой мэдээллийн талаар ТТЗ, ТЕГ–аас НҮБАЗ–ийн холбогдох цахим хуудсан хандана.

### **3.2. Дотоодын жагсаалт**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын 2.2–ын дагуу хүн, хуулийн этгээдийг ТЕГ–ын саналыг үндэслэн Засгийн газар дотоодын жагсаалтад оруулна. Ингэхдээ, ТЕГ өөрийн итгэл үнэмшлийн дагуу эсхүл гадаадын ижил төстэй байгууллагын хүсэлтийг үндэслэж тухайн хүн, хуулийн этгээд НҮБАЗ–ийн тогтоолын шалгуурт нийцсэн тухай хангалттай үндэслэл байгаа тохиолдолд жагсаалтад оруулж болно. Хориг арга хэмжээний

асуудал хариуцсан албан тушаалтны саналаар ТЕГ–ын холбогдох нэгжээс хэргийн талаарх мэдэгдэл боловсруулж ТЕГ–ын даргаар батлуулна.

### **НҮБАЗ–ийн тогтоолын шалгуур**

#### **Терроризмтой холбоотой жагсаалтад оруулах (НҮБАЗ–ийн 1373**

##### **тоот тогтоол, хэсэг 1(с) )**

Дараах үндэслэлээр хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулна. Үүнд: Террорист үйлдэл хийсэн эсхүл завдсан, эсхүл террорист үйлдэл хийхэд оролцсон эсхүл дэмжлэг үзүүлсэн хүн; эсхүл

(а) хэсэгт дурдагдсан хүний шууд эсхүл шууд бусаар өмчилдөг эсхүл хяналтад байдаг хуулийн этгээд; эсхүл

(а) эсхүл (б) хэсэгт дурдагдсан хүн эсхүл хуулийн этгээдийн өмнөөс эсхүл удирдамжаар үйл ажиллагаа явуулдаг хүн эсхүл хуулийн этгээд.

#### **БНАСАУ–тай холбоотой жагсаалтад оруулах (НҮБАЗ–ийн 2270 тоот тогтоол хэсэг 32)**

Дараах үндэслэлээр хүн, хуулийн этгээдийг жагсаалтанд оруулна. Үүнд: БНАСАУ–ын засгийн газар эсхүл тус улсын Ажилчны намын өмчилдөг эсхүл хяналтанд байдаг;

БНАСАУ–ын засгийн газар эсхүл тус улсын Ажилчны намын өмнөөс эсхүл удирдамжаар үйл ажиллагаа явуулдаг эсхүл тэдгээрийн өмчилдөг эсхүл хяналтанд байдаг хүн, хуулийн этгээд;

БНАСАУ–ын цөмийн эсхүл баллистик пуужингийн хөтөлбөртэй холбоотой хүн, хуулийн этгээд эсхүл 1718, 1874, 2087, 2094, 2270 тоот тогтоолууд эсхүл эдгээрийн залгамжлагч тогтоолоор хориглосон бусад үйл ажиллагаа.

Алхам 1	Тагнуулын ажиллагаа болон мэдээлэл цуглуулах
Алхам 2	ТЕГ Хэргийн талаарх мэдэгдлийг боловсруулах (Маягт 1)
Алхам 3	Жагсаалтанд оруулах үндэслэл байгааг тогтоох зорилгоор Хэргийн талаарх мэдэгдлийн талаар зөвлөлдөх/хянах
Алхам 4	Хувь хүн, хуулийн этгээдийг (Маягт 2) жагсаалтанд оруулах [уг шийдвэрийг хэн гаргах] – хориг нэн даруй үйлчлэх
Алхам 5	ТЕГ–аас цахим хуудсан дахь жагсаалтад шинэ мэдээллийг оруулж мэдээлэгч үүрэгтэй байгууллагуудад энэ тухай мэдэгдэх
Алхам 6	ТЕГ–аас жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэх

### 3.3 . Гадаадын засгийн газрын хүсэлт

Монгол Улсын дотоодын жагсаалтад оруулах үйл явцын дагуу хүн, хуулийн этгээдийг жагсаалтанд оруулах хүсэлтийг гадаад улсын засгийн газар Гадаад харилцааны яамаар дамжуулан ТЕГ–ын Хориг арга хэмжээний асуудал хариуцсан албан тушаалтан, ТТЗ–ийн Ажлын албанд [amlcft@gia.gov.mn](mailto:amlcft@gia.gov.mn); [tfs@nctc.gov.mn](mailto:tfs@nctc.gov.mn) хаягаар хүсэлт гаргаж болно. Жагсаалтад оруулах хүсэлт гаргахдаа гадаад улс орны засгийн газар **Маягт 3–ыг** ашиглана. Хүсэлтийг хүлээн авч судалсны дараа дотоодын жагсаалтад оруулах асуудлыг шийдвэрлэнэ.

ТЕГ–аас гадаад улс орны засгийн газарт дотоодын жагсаалтад оруулсан эсхүл оруулаагүй тухай мэдээлнэ. ТЕГ–аас жагсаалтад оруулахгүй шийдвэр гаргасан нөхцөлд гадаад улс орны засгийн газарт уг шийдвэрийн үндэслэлийг мэдэгдэнэ.

Улс орнуудын хамтын ажиллагааг дэмжиж гадаад улс орны жагсаалтад оруулах үйл явцыг эрчимжүүлэх үүднээс ТТЗ, ТЕГ–аас өөрийн цахим хуудсандаа гадаад улсын засгийн газар жагсаалтад оруулах хүсэлт хэрхэн гаргах, хүсэлтийг биелүүлэхэд шаардлагатай мэдээлэл зэргийг байршуулна.

Алхам 1	Гадаад улс орны засгийн газар жагсаалтанд оруулах хүсэлтээ Гадаад харилцааны яаманд (Маягт 3) болон ТЕГ нэгэн зэрэг хүргүүлнэ
Алхам 2	Дотоодын жагсаалтанд оруулах стандарт үйл явц өрнөнө.
Алхам 3	ТЕГ–аас гадаад улс орны засгийн газарт үр дүнгийн талаар мэдэгдэнэ

### **3.4. Гадаадын засгийн газарт хүсэлт гаргах**

Гадаад орны засгийн газарт дотоодын жагсаалтад оруулах өөрийн журмын дагуу хүн, хуулийн этгээдийг тухайн улс орны жагсаалтад оруулах хүсэлтийг Монгол Улс гаргаж болно.

Хүн, хуулийн этгээд, тэдгээрийн өмчилдөг эсхүл тэдгээрийн өмнөөс эсхүл заавраар үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, хуулийн этгээд, эсхүл хүн, хуулийн этгээдийн хөрөнгө бусад улс оронд байгаа талаар үндэслэл бүхий мэдээ мэдээлэл байвал бусад улс орны дотоодын жагсаалтад оруулах үндэслэл болох хангалттай мэдээллийг тухайн улс оронд ТТЗ, ТЕГ–аас хүргүүлнэ.

#### **3.4.1. Гадаадын засгийн газарт хүсэлт гаргах үйл явц**

Алхам 1	Жагсаалтад оруулах этгээдийг ТЕГ–аас гадаад улс оронд тодорхойлно
Алхам 2	ТЕГ–аас хэргийн талаарх мэдэгдэл боловсруулж (Маягт 1) батлах үйл явцыг өрнүүлнэ
Алхам 3	Жагсаалтад оруулах үйл явцын талаарх мэдээллийг ТЕГ гадаад улс орноос хүснэ (жагсаалтанд оруулах мэдэгдлээ урьдчилан хүргүүлсэн)
Алхам 4	Гадаад улс орны шаардлагад нийцүүлж ТЕГ хүсэлтээ боловсруулна
Алхам 5	Хамтын ажиллагааны тогтоосон сувгаар хүсэлтээ гадаад улс оронд хүргүүлнэ
Алхам 6	Дипломат сувгаар гадаад улс оронд хүргүүлэх зорилгоор уг хүсэлтээ нэгэн зэрэг Гадаад харилцааны яаманд хүргүүлнэ.

## **4. Хянах, жагсаалтаас хасах**

### **4.1. НҮБАЗ эсхүл түүний хороодод жагсаалтаас хасах хүсэлт хүргүүлэх**

#### **4.1.1. ТЕГ–ын хүсэлт**

НҮБАЗ эсхүл түүний хороодоос жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдийг жагсаалтаас гаргах хүсэлтийг Монгол Улс хүссэн үедээ НҮБАЗ эсхүл түүний хороодод тавьж болно. Жагсаалтад байлгах шалгуурт нийцээгүй, эсхүл нийцэхээ больсон тухай үндэслэл бүхий мэдээ, мэдээллийг үндэслэн жагсаалтаас гаргах хүсэлт гаргаж болно. Уг хүсэлтийг ТТЗ болон ТЕГ

боловсруулж НҮБАЗ эсхүл холбогдох хороонд шууд болон дипломат сувгаар хүргүүлнэ.

#### **Жагсаалтаас гаргах хүсэлтэй холбоотой нэмэлт мэдээлэл**

Хүсэлтэд тусгах мэдээлэл болон Хороодын журмын талаарх мэдээллийг НҮБАЗ–ийн хоригийн хорооны дараах цахим хуудаснаас авна уу: <https://www.un.org/securitycouncil/sanctions/information>

1718 тоот тогтоолын хоригийн хорооны (БНАСАУ) жагсаалтаас хасах журам: <https://www.un.org/securitycouncil/sanctions/1718/materials/procedures-delisting>

1267 тоот хоригийн хорооны (ISIL (Da'esh) & Ал–Каида) жагсаалтаас хасах журам: [https://www.un.org/securitycouncil/sanctions/1267/aq\\_sanctions\\_list/procedures-for-delisting](https://www.un.org/securitycouncil/sanctions/1267/aq_sanctions_list/procedures-for-delisting)

1988 тоот хоригийн хорооны (Taliban) жагсаалтаас хасах журам: [https://www.un.org/securitycouncil/sanctions/1988/materials/procedures\\_delisting](https://www.un.org/securitycouncil/sanctions/1988/materials/procedures_delisting)

#### **4.1.2. Жагсаалтад буй хүн, хуулийн этгээдийн хүсэлт**

Жагсаалтад буй хүн, хуулийн этгээд нь ТЕГ эсхүл шууд НҮБАЗ–ийн Асуудал хариуцсан албан тушаалтанд жагсаалтаас хасагдах хүсэлтээ гаргаж болно. Асуудал хариуцсан албан тушаалтан Исламын Улс ISIL (Da'esh) болон Аль–Каида–аас бусад Хоригийн жагсаалттай холбоотой хүсэлтийг хүлээн авч судлана. ISIL (Da'esh) болон Аль–Каида–ийн хоригийн жагсаалтаас хасагдахтай холбоотой хүсэлтийг Омбудсманы<sup>1</sup> албанд хүргүүлнэ.

НҮБАЗ–ийн Асуудал хариуцсан албан тушаалтанд жагсаалтаас хасагдах хүсэлт гаргах холбогдох журмын талаарх нэмэлт мэдээллийг НҮБАЗ–ийн Асуудал хариуцсан албан тушаалтнаас жагсаалтаас хасах дараах цахим хуудаснаас авч болно: <https://www.un.org/securitycouncil/sanctions/delisting>

1 Гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлэхээр тусгайлан томилогдсон, асуудал хариуцсан хүн

Хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах анхдагч саналыг Монгол Улс гаргасан бол НҮБАЗ–ийн Асуудал хариуцсан албан тушаалтан нь жагсаалтаас хасагдах өргөдлийн хувийг Монгол Улсад эсхүл тухайн хүн, хуулийн этгээдийн харьяалах эсхүл оршин суух улс оронд хүргүүлнэ. Ингэсэн тохиолдолд гурван сарын (3) сарын дотор Монгол Улс жагсаалтаас хасагдах уг хүсэлтийг судлаж хариу мэдэгдэнэ.

НҮБАЗ–ийн журмаар зөвшөөрсөн нөхцөлд жагсаалтад буй хүн, хуулийн этгээдийн жагсаалтаас хасагдах хүсэлтийг ТЕГ–аас дэмжиж болно. Жагсаалтад байлгах шалгуурт нийцээгүй, эсхүл тийм үндэслэл байхгүй болсон тохиолдолд жагсаалтаас гаргах уг хүсэлтийг ТЕГ дэмжиж болно. Өргөдөл гаргагч нь жагсаалтаас хасагдах тухай ТЕГ–аас дэмжлэг хүссэн бол ТЕГ нь жагсаалтад буй хүн, хуулийн этгээдэд эсхүл жагсаалтаас хасах өргөдөл гаргасан хүн, хуулийн этгээдэд жагсаалтаас хасагдах уг хүсэлтийг дэмжиж эсхүл эс дэмжиж буйгаа яаралтай мэдэгдэнэ.

#### **4.2. Дотооддоо хянаж жагсаалтаас гаргах**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам /цаашид “хориг арга хэмжээний журам” гэх/–ын 2.2–т заасны дагуу ТЕГ–ын саналын дагуу жагсаалтад оруулсан хүн эсхүл хуулийн этгээд гомдол гаргах эрхтэй. Жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээд гомдлоо ТЕГ–т ирүүлсэн нөхцөлд ТЕГ асуудлыг *нэн даруй* хянаж гомдол гаргагчийг жагсаалтад үлдээх эсхүл хасах шийдвэрийг гаргана.

Гомдол гаргагч гомдлоо бичгээр, албан захидал хэлбэрээр Тагнуулын ерөнхий газрын нэр дээр хаяглан, өөрийн хувийн дэлгэрэнгүй мэдээлэл болон жагсаалтад оруулсныг эсэргүүцэж буй үндэслэлийн хамт хүргүүлнэ. Холбогдох баримт бичгийг хавсаргаж болно.

Шийдвэр гаргахад нэмэлт баримт бичиг эсхүл мэдээлэл шаардлагатай гэж үзвэл ТЕГ уг мэдээллийг цуглуулж гомдол гаргагчийг дуудаж асуулт тавих эрхтэй байна.

Гомдол гаргагч нь жагсаалтанд оруулах шалгуурт нийцээгүй, эсхүл цаашид нийцэхгүй гэж үзвэл гомдол гаргагчийг ТЕГ *нэн даруй* жагсаалтаас

хасна. Жагсаалтаас хасах шийдвэр гарсан нөхцөлд “хориг арга хэмжээний журам”-ын 4.7, 4.8–д заасны дагуу ТЕГ, ТТЗ–өөс хүн, хуулийн этгээд, санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нарт болон олон нийтэд мэдээлнэ.

Мөн журмын 4.2.3–т заасны дагуу тагнуулын байгууллага нь гомдлыг хянахын зэрэгцээ өөрийн санаачилгаар жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдийн мэдээллийг жагсаалтад оруулах шалгуурт нийцэх эсэхийг 5 жил тутам хянан баталгаажуулна.

#### **4.3. Жагсаалтын алдаатай нэрсийг нягтлан, залруулах туслалцаа**

Түгээмэл нэрс эсхүл шалгалтын үр дүнд буруу нь нотлогдох хоёрдмол утгатай хувийн мэдээллийн улмаас хүн, хуулийн этгээдийг жагсаалтад алдаагаар оруулдаг. Зарим тохиолдолд алдаагаар жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг царцаадаг.

Алдаагаар хөрөнгө нь царцаагдсан этгээд “Хориг арга хэмжээний журам”–ын 4.3–т заасны дагуу хөрөнгө чөлөөлүүлэх хүсэлтээ ТЕГ–т гаргаж болно. Ажлын 30 хоногийн дотор өргөдөл гаргагч тухайн хүний хөрөнгийг алдаагаар царцаасан асуудлыг хянаж шийдвэрлэнэ. Өргөдөл гаргагчид ТЕГ–ын шийдвэрийг мэдэгдэнэ.

Хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулсан эсэхийг тогтоох зорилгоор хүн, хуулийн этгээд уг асуудлыг нягтлуулах туслалцаа хүсч болно. Асуудлыг нягтлах явцад хөрөнгийг царцаасан хэвээр байна. Нягтлах туслалцаа хүссэн хүсэлтийг “мэдээллийг хянах маягт” **Маягт 6–ын** дагуу гаргана.

#### **4.4. Гуравдагч этгээд**

“Хориг арга хэмжээний журам”–ын 4.9–д тагнуулын байгууллага журамд заасан үүргээ хэрэгжүүлэх явцад гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах зохицуулалтыг тусгасан. ТЕГ нь хөрөнгө чөлөөлөх тухай гуравдагч этгээдийн гаргасан гомдлыг хянаж шийдвэрлэх үүрэгтэй ба ажлын 30 хоногийн дотор шийдвэрлэж энэ талаар холбогдох талуудад мэдэгдэнэ. ТЕГ–ын шийдвэрийг гомдол гаргагч зөвшөөрөөгүй тохиолдолд зохих эрх бүхий байгууллагаар хянуулах эрхтэй.

## **5. Жагсаалтад оруулсан, хассан болон хөрөнгө чөлөөлсөн тухай мэдэгдэл**

НҮБАЗ эсхүл түүний хороод, эсхүл ТЕГ–ын саналын дагуу жагсаалтад оруулсан тохиолдолд хүн, хуулийн этгээд нь “хориг арга хэмжээний журам”–ын 5.1–т заасны дагуу хөрөнгийн хөдөлгөөнийг зогсооно. ТЕГ, ТТЗ нь хяналт шалгалтын байгууллагуудтай хамтран мэдээлэх үүрэгтэй этгээдэд хөрөнгийг нэн даруй царцаах тухай мэдэгдэнэ. “Мэдээлэх үүрэгтэй этгээд” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар зохицуулах санхүүгийн болон санхүүгийн бус байгууллага, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нарыг хэлнэ.

Жагсаалтад оруулсан болон хассан тухай мэдэгдэл хүргүүлэх нь хуулиар ногдуулсан үүрэг биш. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиар НҮБ болон ТЕГ–ын саналаар жагсаалтад оруулсан, хассан үйл ажиллагаа нэн даруй хэрэгжинэ. Энэ тухай мэдэгдэл хүргүүлж буй нь хүн, хуулийн этгээд, олон нийтэд хуулийг хэрэгжүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд тус дөхөм болох зорилготой юм. Уг мэдэгдлийг хүргүүлээгүй нь жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг царцааж санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс таггалзах хуулиар тогтоосон үүрэг, хариуцлагаас хүн, хуулийн этгээдийг чөлөөлөхгүй.

### **5.1. Хориг арга хэмжээний жагсаалт**

НҮБАЗ–ийн хориг арга хэмжээний нэгдсэн жагсаалтын доорх холбоосыг ТЕГ, ТТЗ өөрийн цахим хуудсандаа байршуулна:

<https://www.un.org/securitycouncil/content/un-sc-consolidated-list>

НҮБАЗ–ийн нэгдсэн жагсаалт нь терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зэрэгтэй холбоотой НҮБ–ын бүхий л хориг арга хэмжээний хүрээнд жагсаалтад буй хүн, хуулийн этгээдийн нэрс болон бусад холбогдох мэдээллийг агуулна. Нэгдсэн жагсаалтад өөрчлөлт орсон тухай мэдээллийг нэн даруй авах зорилгоор ТТЗ, ТЕГ нь НҮБАЗ–ийн нэгдсэн жагсаалттай цахим шуудангийн хаягаар холбогдох хаягийн жагсаалттай байна. Нэгдсэн жагсаалтын өөрчлөлтөд жагсаалтад шинээр оруулсан, жагсаалтаас хассан тухай шийдвэр болон жагсаалтын нэрсэд орсон нэмэлт өөрчлөлтийн тухай мэдээлэл багтана.

ТЕГ нь дотоодын жагсаалтыг **Маягт А**-д заасан хүснэгтийн дагуу бүртгэнэ. Дотоодын хоригийн жагсаалтад орсон аливаа өөрчлөлтийг ТЕГ-ын цахим хуудсаар 2 цагийн дотор гэсэн дохиогоор мэдэгдэнэ. Дотоодын хоригийн жагсаалтад орох өөрчлөлтөд шинээр нэмэгдсэн нэрс, жагсаалтаас хасах шийдвэр болон жагсаалтад орох нэмэлт өөрчлөлт зэрэг орно.

Хяналт шалгалтын байгууллагууд өөрийн цахим хуудсаараа НҮБАЗ-ийн нэгдсэн жагсаалт болон ТЕГ-ын дотоодын жагсаалтад холбогдох холбоос үүсгэж ТЕГ-ын дохио мэдээллийн зарчмыг нэвтрүүлж болно.

### **5.2. Мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдэгдэх**

Хориг арга хэмжээний жагсаалтыг шинэчлэхийн зэрэгцээ ТТЗ, ТЕГ нь (шууд эсхүл хяналт шалгалтын байгууллагаар дамжуулж) жагсаалтанд шинээр оруулсан нэрс, жагсаалтаас хассан эсхүл нэмэлт өөрчлөлтийн талаар нэг эсхүл түүнээс дээш мэдээлэх үүрэгтэй байгууллагад тусгай мэдэгдэл хүргүүлж болно. Ийнхүү тусгай мэдэгдлийг хориг арга хэмжээний жагсаалтыг шинэчлэхээс өмнө эсхүл дараа нь хүргүүлнэ. Хөрөнгө нэн даруй царцаах зорилгоор дээрх арга хэмжээг авна.

### **5.3. Хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулсан, хассан болон хөрөнгө чөлөөлсөн тухай мэдэгдэл**

“Хориг арга хэмжээний журам”-ын 2.5–д заасны дагуу жагсаалтыг тагнуулын байгууллага ажлын 15 өдрийн дотор жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд дараах мэдээллийг хүргүүлнэ:

1. Жагсаалт, түүний болзошгүй үр дагавар;
2. Жагсаалттай танилцах, жагсаалтаас хасахтай холбоотой мэдээлэл;
3. Тухайн хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах болсон баримтын нийтэд мэдээлж болох тодорхой хэсэг;
4. Санхүүгийн үйлчилгээ авах болон хөрөнгийг ашиглах зөвшөөрөл авахтай холбоотой НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолын тухай мэдээлэл;
5. Жагсаалтаас хасуулах тухай гомдлыг хүлээн авах НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооны мэдээлэл.

Царцаахаас өмнө хөрөнгийг хөдөлгөөнд оруулахаас сэрэмжилж хүн, хуулийн этгээдэд хамгийн сүүлд жагсаалтанд оруулсан тухай мэдэгдэнэ.

Мөн жагсаалтаас хасагдсан хүн, хуулийн этгээдэд ТЕГ нэн даруй мэдэгдэнэ. Жагсаалтаас хассан тухай мэдэгдлийг жагсаалтыг шинэчлэх эсхүл мэдээлэх үүрэгтэй байгууллагуудад мэдэгдэхтэй зэрэг хүргүүлнэ. Жагсаалтаас хассан тухай мэдэгдлийн хувьд 15 хоногийн хугацаа үйлчлэхгүй.

#### **5.4. Мэдэгдэх үйл явц**

Алхам 1	НҮБАЗ эсхүл түүний хороод эсхүл ТЕГ–аас хүн эсхүл хуулийн этгээдийг хориг арга хэмжээний жагсаалтанд оруулна
Алхам 2	ТЕГ нь 2 цагийн дотор Нэгдсэн жагсаалт эсхүл дотоодын жагсаалтыг шинэчилж энэ тухай тусгай дохио мэдээлэл гаргана
Алхам 3	Мэдээлэх үүрэг тэй байгууллагуудад жагсаалтын талаар тусгай мэдэгдэл хүргүүлэх чиглэлээр ТЕГ нь хяналт шалгалтын байгууллагуудтай хамтран ажиллаж болно
Алхам 4	Алхам 2–ын дагуу жагсаалтын талаарх мэдэгдэл хүргүүлнээс хойш 15 хоногийн дотор ТЕГ–аас жагсаалтанд оруулсан хүн эсхүл хуулийн этгээдэд мэдэгдэнэ.

#### **5.5. Хөрөнгийг чөлөөлөх тухай мэдэгдэх**

“Хориг арга хэмжээ авах журам”–ын 4.7–д заасны дагуу жагсаалтаас хассан, эсхүл хөрөнгийг чөлөөлсөн тухай шийдвэр гарсан даруй тагнуулын байгууллага нь холбогдох хүн, хуулийн этгээд, санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч бусад этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

### **6. Хориглох ба зөвшөөрөх**

#### **6.1 Хориглох**

Хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулсан даруйд Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болон “Хориг арга хэмжээ авах журам”–ын хориглолтын заалтууд үйлчилнэ. Уг хориглолт нь хүн, хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна. Уг хууль болон хориг арга хэмжээний журмын дагуу хүн, хуулийн этгээдийн авсан арга хэмжээтэй холбогдуулж Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн

25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэгт заасны дагуу хариуцлагад татахаас чөлөөлж хамгаална.

### **6.1.1 Хөрөнгө захиран зарцуулахыг хориглох (хөрөнгө царцаах)**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 24 дүгээр зүйл болон хориг арга хэмжээ авах журмын 5.1, 5.3–д заасны дагуу хүн, хуулийн этгээдэд жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бусаар өмчилдөг эсхүл хянадаг, эсхүл тэдгээрийн өмнөөс эсхүл заавраар үйл ажиллагаа явуулдаг хүн эсхүл хуулийн этгээдийн бүхий л хөрөнгийг яаралтай, урьдчилж мэдэгдэлгүйгээр царцаах шаардлага тавигдана. Царцаах хөрөнгөнд дараах хамаарна:

- Дээр дурдсан хөрөнгөөс эх сурвалж бүхий хөрөнгө;
- БНАСАУ–тай холбоотойгоор НҮБАЗ–ийн тогтоолоор жагсаалтад оруулсан хөлөг онгоц;
- Тодорхой үйлдэл, завдал эсхүл заналхийлэлтэй холбоотой эсэхийг үл харгалзан дээр дурдсан тайлбарт хамрагдах хөрөнгө.

### **6.1.2 Хөрөнгө олгохыг хориглох**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 14.2, хориг арга хэмжээ авах журмын 5.2, 5.3–т заасны дагуу хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бусаар өмчилдөг эсхүл хянадаг, эсхүл тэдгээрийн өмнөөс эсхүл заавраар үйл ажиллагаа явуулдаг хүн эсхүл хуулийн этгээдэд хөрөнгө, эдийн засгийн эх үүсвэр олгохыг хориглоно.

### **6.1.3 Санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглох**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 14.2, хориг арга хэмжээ авах журмын 5.2, 5.3–т заасны дагуу хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бусаар өмчилдөг эсхүл хянадаг, эсхүл тэдгээрийн өмнөөс эсхүл заавраар үйл ажиллагаа явуулдаг хүн эсхүл хуулийн этгээдэд санхүүгийн болон бусад бүх төрлийн үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг хориглоно.

## 6.2 Зөвшөөрөх

Энэхүү журмаар тогтоосон хориглолт нь жагсаалтад оруулсан этгээд эсхүл түүний гэр бүлийн гишүүдийн хүний суурь эрхийн эсрэг хүндрэл учруулах зорилгыг агуулаагүй болно. НҮБАЗ–ийн тогтоолуудад хөрөнгийг захиран зарцуулахыг зөвшөөрөх хэд хэдэн үндэслэлийг дурдсан. Иймээс тодорхой нөхцөл байдалд жагсаалтад оруулсан хүн эсхүл хуулийн этгээдийг хөрөнгө захиран зарцуулахыг зөвшөөрсөн механизмыг хориг арга хэмжээ авах журмын 4.5, 4.6–д тус тус тусгасан.

### 6.2.1 Зөвшөөрөх үйл явц

Алхам 1	Жагсаалтад оруулсан зөвшөөрөл хүсч буй хүн эсхүл хуулийн этгээд Жагсаалтад оруулсан хүн эсхүл хуулийн этгээдийн хөрөнгө захиран зарцуулах өргөдөл (Маягт 7) бөглөж шуудангаар эсхүл цахим шуудангаар ТЕГ–т хүргүүлнэ.
Алхам 2	ТЕГ өргөдлийг хянаж зөвшөөрөх үнэслэлийг хүлээн зөвшөөрөх итгэл үнэмшилтэй эсэхээ нягтална.
Алхам 3	НҮБАЗ эсхүл түүний хороодоос зөвшөөрөл хүсч шаардлагатай мэдэгдлийг хүргүүлнэ. НҮБАЗ эсхүл түүний хороодоос зөвшөөрөл хүсч шаардлагатай мэдэгдлийг хүргүүлнэ
Алхам 4	ТЕГ шийдвэрээ гаргаж энэ тухай өргөдөл гаргагчид мэдээлж шаардлагатай бол мэдээлэх үүрэгтэй байгууллагуудад мэдээлнэ

### 6.2.2 НҮБАЗ–ийн болон хороодын мэдэгдэл ба зөвшөөрөл

Жагсаалтад оруулсан хүн эсхүл хуулийн этгээдэд хөрөнгө олгохыг зөвшөөрөхөөс өмнө энэ тухайгаа НҮБАЗ эсхүл түүний хороодоос шаардлагатай зөвшөөрөл хүсч шаардлагатай мэдэгдэл хүргүүлнэ.

ТЕГ мэдэгдэл эсхүл зөвшөөрлийн хүсэлтийг боловсруулж холбогдох хороонд хүргүүлнэ. Ингэхдээ ТЕГ хороонд шууд хандаж болох ба Гадаад харилцааны ямаар нэгэн зэрэг албан хүсэлт уламжилна.

Холбогдох хороо эсрэг шийдвэр гаргасан нөхцөлд ТЕГ зөвшөөрөл олгохгүй.

НҮБАЗ эсхүл түүний холбогдох хороодод хүргүүлэх зөвшөөрлийн хүсэлт, мэдэгдэл хүргүүлэхэд шаардагдах нарийвчилсан мэдээллийн талаар НҮБАЗ–ийн цахим хуудаснаас авна уу.

**1718 (2006) тоот тогтоол БНАСАУ**

Зөвшөөрөл	НҮБАЗ–ийн зөвшөөрөл ба холбогдох хороо	Шаардлагатай мэдэгдэл эсхүл баталгаажуулалт	Хугацаа
<p><b>Суурь зардал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– Хоол, хүнс</li> <li>– Түрээс эсхүл орон сууцны зээл</li> <li>– Эм, эмнэлгийн үйлчилгээ</li> <li>– Татвар, даатгалын хураамж, нийтийн аж ахуйн төлбөр</li> <li>– Мэргэжлийн үйлчилгээний төлбөр, эрх зүйн үйлчилгээний хураамжийн нөхөн төлбөр</li> <li>– Дотоодын хуулийн дагуу царцаасан хөрөнгө, санхүүгийн хөрөнгө болон эдийн засгийн нөөцийн үйлчилгээний хураамж, төлбөр</li> </ul>	<p>Дараахийг үндэслэн НҮБАЗ мэдэгдэл шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>– 1718 тоот тогтоол (2006) 9(а) хэсэг</li> <li>– Хорооны удирдамжийн Хэсэг 11</li> </ul> <p>Холбогдох хороо: 1718 (2006) (БНАСАУ) тоот тогтоолын дагуу байгуулагдсан НҮБАЗ–ийн хороо (2006) (DPRK)</p>	<p>Суурь зардлыг зөвшөөрөх тухай мэдэгдлээ Монгол Улс Хоригийн хорооны даргад хүргүүлэх</p> <p>Мэдэгдэл дараах мэдээллийг агуулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>– Хүлээн авагч (нэр болон хаяг)</li> <li>– Хүлээн авагчийн банкны мэдээлэл</li> <li>– Төлбөрийн зориулалт ба үндэслэл</li> <li>– Төлбөрийн үнийн дүн</li> <li>– Хэдэн удаагийн төлбөр хийгдэх</li> <li>– Банкны шилжүүлгээр эсхүл шууд дебит гүйлгээ</li> <li>– Хүү</li> <li>– Царцаасан тусгай хөрөнгө</li> <li>– Бусад холбогдох мэдээлэл</li> </ul>	<p>Суурь зардлын хүсэлтийг хүлээн авснаа хороо нэн даруй мэдэгдэнэ</p> <p>Мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор эсрэг хариу Монгол Улсад ирүүлээгүй бол зөвшөөрөл олгогдсонд тооцох</p>

<p><b>Онцгой зардал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– Суурь зардлаас бусад төлбөр эсхүл ТЕГ–аас дараах үндэслэлээр зөвшөөрөх гэрээгээр хүлээсэн үүрэг болох:</li> <li>– Шаардлагатай;</li> <li>– НҮБАЗ–ийн холбогдох тогтоолд харшлахгүй</li> </ul>	<p>Дараах үндэслэлээр-НҮБАЗ мэдэгдэл болон зөвшөөрөл шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>– 1718 (2006) тоот тогтоол 9(b) хэсэг</li> <li>– Хорооны удирдамжийн Хэсэг 11</li> </ul> <p>Холбогдох хороо: 1718 (2006) (БНАСАУ) тоот тогтоолын дагуу байгуулагдсан НҮБАЗ–ийн хороо</p>	<p>Монгол Улс хоригийн хороонд мэдэгдэж нягтлуулна</p> <p>“Суурь зардлын мэдэгдэлд” тусгасан мэдээллийг мэдэгдэлд тусгана</p>	<p>Хорооны зөвшөөрөл шаардлагатай. Хорооноос шийдвэр гаргах хугацааг томъёолоогүй</p>
<p><b>Шүүхийн, захиргааны эсхүл арбитрын маргаан эсхүл дүгнэлтийн асуудал (2006 оны 10 дугаар сарын 14–өөс өмнөх)</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– маргаан эсхүл дүгнэлттэй холбоотой зарцуулах санхүүгийн хөрөнгө эсхүл эдийн засгийн нөөц (2016 оны 10 сарын 14–ий өдрөөс өмнөх );</li> <li>– жагсаалтад оруулсан хувь хүн ба/эсхүл хуулийн этгээдийн ашиг тусын тулд бус</li> </ul>	<p>Дараахийг үндэслэж хорооны мэдэгдэл шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>– 1718 (2006) тоот тогтоол 9(b) хэсэг</li> <li>– Хорооны удирдамжийн Хэсэг 11</li> </ul> <p>Холбогдох хороо: 1718 (2006) (БНАСАУ) тоот тогтоолын дагуу байгуулагдсан НҮБАЗ–ийн хороо</p>	<p>Монгол Улс мэдэгдэл хүргүүлж маргаан эсхүл дүгнэлттэй холбоотой зарцуулах хөрөнгө эсхүл нөөцийн талаарх мэдээллийг хавсаргана</p>	<p>Хорооны шийдвэр шаардлагагүй</p>

**2231 (2015) тоот тогтоол (Иран)**

Зөвшөөрөл	НҮБАЗ–ийн зөвшөөрөл ба холбогдох хороо	Шаардлагатай мэдэгдэл эсхүл баталгаажуулалт	Хугацаа
<p><b>Суурь зардал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– Хоол, хүнс</li> <li>– Түрээс эсхүл орон сууцны зээл</li> <li>– Эм, эмнэлгийн үйлчилгээ</li> <li>– Татвар, даатгалын хураамж, нийтийн аж ахуйн төлбөр</li> <li>– Мэргэжлийн үйлчилгээний төлбөр, эрх зүйн үйлчилгээний хураамжийн нөхөн төлбөр</li> </ul> <p>Царцаасан хөрөнгө, санхүүгийн хөрөнгө болон эдийн засгийн нөөцийн үйлчилгээний хураамж, төлбөр</p>	<p>Хавсралт В: Мэдэгдэл –ийн 6(d)(i) –тай холбогдуулж АЗ–ийн мэдэгдэл болон зөвшөөрөл шаардлагатай</p>	<p>Монгол Улс зөвшөөрөл олгох тухайгаа АЗ–д мэдэгдэнэ</p>	<p>Мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор АЗ–өөс эсрэг шийдвэр гараагүй бол зөвшөөрсөнд олгогдсонд тооцох</p>
<p><b>Онцгой зардал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– Суурь зардлаас бусад төлбөр эсхүл ТЕГ–аас дараах үндэслэлээр зөвшөөрөх гэрээгээр хүлээсэн үүрэг болох: Шаардлагатай;             <ul style="list-style-type: none"> <li>– НҮБАЗ–ийн холбогдох тогтоолд харшлахгүй</li> </ul> </li> </ul>	<p>Хавсралт В: Мэдэгдэл –ийн 6(d)(ii) –тай холбогдуулж АЗ–ийн мэдэгдэл болон зөвшөөрөл шаардлагатай</p>	<p>Монгол Улс зөвшөөрөл олгох тухайгаа АЗ–д мэдэгдэнэ.</p>	<p>Аюулгүйн зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай. Хорооноос шийдвэр гаргах хугацааг томъёолоогүй</p>

<p><b>Гэрээгээр хүлээсэн үүрэг</b></p> <p>Дараахтай холбоотойгоор тухайн хүн, хуулийн этгээдийг жагсаалтанд оруулахаас өмнө байгуулсан гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ биелүүлэхэд шаардлагатай хөрөнгө.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>– Тогтоолоор хориглосон аливаа эд зүйлстэй гэрээ холбоогүй байх</li> <li>– Төлбөрийг жагсаалтад оруулсан хувь хүн, хуулийн этгээд шууд болон шууд бусаар хүлээн авахгүй байх</li> </ul>	<p>Төлбөрийг зөвшөөрөхөөс ажлын арав хоногийн өмнө Аюулгүйн зөвлөлд мэдэгдэл хүргүүлж зөвшөөрөл авна.</p>	<p>Төлбөрийг зөвшөөрөхөөс ажлын арав хоногийн өмнө Аюулгүйн зөвлөлд мэдэгдэл хүргүүлж зөвшөөрөл авна. Аюулгүйн зөвлөлөөс эсрэг хариу ирээгүй нөхцөлд Монгол Улс зөвшөөрөл олгож болно.</p>	<p>Төлбөрийг зөвшөөрөхөөс ажлын арав хоногийн өмнө Аюулгүйн зөвлөлд мэдэгдэл хүргүүлж зөвшөөрөл авна. Аюулгүйн зөвлөлөөс эсрэг хариу ирээгүй нөхцөлд Монгол Улс зөвшөөрөл олгож болно.</p>
<p><b>Шүүхийн, захиргааны эсхүл арбитрын маргаан эсхүл дүгнэлтийн асуудал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– АЗ–ийн 1737 (2006) тоот тогтоол гарахаас өмнөх маргаан эсхүл дүгнэлттэй холбоотой зарцуулах санхүүгийн хөрөнгө эсхүл эдийн засгийн нөөц;</li> </ul> <p>жагсаалтанд оруулсан хүн ба/эсхүл хуулийн этгээдийн ашиг тусын тулд бус</p>	<p>Хавсралт В: Мэдэгдэл –ийн 6(d)(iv) –тай холбогдуулж АЗ–ийн мэдэгдэл болон зөвшөөрөл шаардлагатай</p>	<p>Монгол Улс АЗ–д мэдэгдэнэ.</p>	<p>АЗ–ийн зөвшөөрөл шаардлагагүй</p>

**ISIL (Da'esh) болон Аль–Каида–ийн хориг арга хэмжээний хороо, 1988 тоот  
тогтоолын хориг арга хэмжээний хороо (Талибан)**

Зөвшөөрөл	НҮБАЭ–ийн зөвшөөрөл ба холбогдох хороо	Шаардлагатай мэдэгдэл эсхүл баталгаажуулалт	Хугацаа
<p><b>Суурь зардал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– Хоол, хүнс</li> <li>– Түрээс эсхүл орон сууцны зээл</li> <li>– Эм, эмчилгээ</li> <li>– Татвар, даатгалын хураамж, нийтийн аж ахуйн төлбөр</li> <li>– Мэргэжлийн үйлчилгээний төлбөр, эрхзүйн үйлчилгээ, эсхүл царцаасан хөрөнгө эсхүл санхүүгийн хөрөнгө эсхүл эдийн засгийн нөөц олгохтой холбоотой зардлын нөхөн төлбөр</li> </ul>	<p>Дараахийг үндэслэж хорооны мэдэгдэл болон зөвшөөрөл шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>– <b>(ISIL болон Аль–Каида) хорооны</b> удирдамжийн 11(d) хэсэг</li> <li>– <b>(Taliban) хорооны</b> удирдамжийн 12(d) хэсэг</li> </ul>	<p>Суурь зардлыг зөвшөөрөх тухай мэдэгдлээ Монгол Улс Хорооны даргад хүргүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>– Мэдэгдэл дараах мэдээллийг агуулна:</li> <li>– Хүлээн авагч (нэр болон хаяг)</li> <li>– Хоригийн жагсаалт дахь хүлээн авагчийн дугаар</li> <li>– Хүлээн авагчийн банкны мэдээлэл</li> <li>– Төлбөрийн зориулалт ба үндэслэл</li> <li>– Нэг удаагийн төлбөрийн үнийн дүн</li> <li>– Хэдэн удаагийн төлбөр хийгдэх</li> <li>– Төлбөр хийгдэж эхлэх огноо</li> <li>– Банкны шилжүүлгээр эсхүл шууд дебит гүйлгээ</li> <li>– Хүү</li> <li>– Царцаасан тусгай хөрөнгө</li> <li>– Бусад холбогдох мэдээлэл</li> </ul>	<p>Суурь зардлын хүсэлтийг хүлээх авсан тухай хороо нэн даруй мэдэгдэх</p> <p>Мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 3 хоногийн дотор эсрэг хариу Монгол Улсад ирүүлээгүй бол зөвшөөрөл олгогдсонд тооцох</p>

<p><b>Онцгой зардал</b></p>	<p>Дараахийг үндэслэж хорооны мэдэгдэл болон зөвшөөрөл шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>– 1452 (2002) тоот тогтоолын 1(b) хэсэг</li> <li>– <b>(ISIL болон Аль–Каида) хорооны</b> удирдамжийн 11(d) хэсэг</li> <li>– <b>(Taliban)</b> хорооны удирдамжийн 12(d) хэсэг</li> </ul> <p>Холбогдох хороо: 1267 (1999) тоот тогтоолтой холбоотой байгуулагдсан АЗ–ийн хороо</p>	<p>Зөвшөөрөл олгох тухайгаа Монгол Улс АЗ–д мэдэгдэх. Холбогдох хорооноос ажлын тав хоногийн дараа Монгол Улсад шийдвэрээ мэдээлнэ.</p> <p>Суурь зардлын шаардлагыг хангах мэдээлэлтэй ижил мэдээллийг уг мэдэгдэлд тусгах (дээр дурдсан).</p>	<p>Холбогдох хорооноос ажлын тав хоногийн дараа Монгол Улсад шийдвэрээ мэдээлнэ.</p>
-----------------------------	--	--	--

**НҮБАЗ–ийн 1373 тоот тогтоолын дагуух Монгол Улсын дотоодын жагсаалт**

<b>Зөвшөөрлийн үндэслэл</b>	<b>Шаардлагатай зөвшөөрөл</b>	<b>Зөвшөөрөлд шаардлагатай мэдээлэл</b>	<b>Хугацаа</b>
<p><b>Суурь зардал</b> Хоол, хүнс Түрээс эсхүл орон сууцны зээл Эм, эмчилгээ Татвар, даатгалын хураамж, нийтийн аж ахуйн төлбөр Мэргэжлийн үйлчилгээний төлбөр, эрхзүйн үйлчилгээ, царцаасан хөрөнгө эсхүл санхүүгийн хөрөнгө эсхүл эдийн засгийн нөөц олгохтой холбоотой зардлын нөхөн төлбөр</p>	<p>ТЕГ–ын (Даргын) зөвшөөрөл шаардлагатай НҮБАЗ–ийн мэдэгдэл болон зөвшөөрөл шаардлагагүй</p>	<p>Зөвшөөрөл хүссэн өргөдөлд дараах мэдээллийг тусгана. Үүнд: Хүлээн авагч (нэр, хаяг) Хориг арга хэмжээний жагсаалтан дах хүлээн авагчийн дугаар Хүлээн авагчийн банкны мэдээлэл Төлбөрийн зорилго болон үндэслэл Нэг удаа хийх төлбөрийг дүн Төлбөрийг хэдэн удаа хийх Төлбөр хийж эхлэх огноо Банкны шилжүүлэг эсхүл дебит гүйлгээ Хүү Царцаах тодорхой хөрөнгө Бусад холбогдох мэдээлэл</p>	<p>Суурь зардлын хүсэлтийг нэн даруй шийдвэрлэж тогтооно.</p>

Онцгой зардал	ТЕГ–ын (Даргын) зөвшөөрөл шаардлагатай НҮБАЗ–ийн мэдэгдэл болон зөвшөөрөл шаардлагагүй	Зөвшөөрөл хүссэн өргөдөлд дараах мэдээллийг тусгана. Үүнд: Хүлээн авагч (нэр, хаяг) Хориг арга хэмжээний жагсаалтан дах хүлээн авагчийн дугаар Хүлээн авагчийн банкны мэдээлэл Төлбөрийн зорилго болон үндэслэл Нэг удаа хийх төлбөрийг дүн Төлбөрийг хэдэн удаа хийх Төлбөр хийж эхлэх огноо Банкны шилжүүлэг эсхүл дебит гүйлгээ Хүү Царцаах тодорхой хөрөнгө Бусад холбогдох мэдээлэл	<b>Зөвшөөрөл олгох хугацааг тодорхойлохгүй</b>
---------------	--	---	--

## 7. Тайлагнах

Хөрөнгө царцаасан, эсхүл царцаасан хөрөнгийг захиран зарцуулахыг завдсан үйлдлийг тогтоосон мэдээлэх үүрэгтэй этгээд СМА болон ТЕГ–ын хориг арга хэмжээний асуудал хариуцсан албан тушаалтанд нэгэн зэрэг мэдээлэхийг хориг арга хэмжээ авах журам буюу "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын 5.5–д заасны дагуу шаарддаг.

Хөрөнгийн талаарх мэдээллийг **Маягт 5–д** заасны дагуу бөглөнө. Уг мэдээллийг шаардлагатай маягтаар [fiu@mongolbank.mn](mailto:fiu@mongolbank.mn), [amlcft@gia.gov.mn](mailto:amlcft@gia.gov.mn); [ffs@nctc.gov.mn](mailto:ffs@nctc.gov.mn) хаягаар 24 цагийн дотор хүргүүлнэ.

Мэдээлэх үүрэг хүлээгээгүй хүн, хуулийн этгээдийн хувьд **Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийн тайлан** мэдээний маягт боловсруулж (Маягт 5) 24 цагийн дотор цахим шуудангаар ТТЗ–ийн ажлын алба болон ТЕГ–ын хориг арга хэмжээний асуудал хариуцсан албан тушаалтанд [amlcft@gia.gov.mn](mailto:amlcft@gia.gov.mn); [fs@nctc.gov.mn](mailto:fs@nctc.gov.mn) хаягаар хүргүүлнэ.

Хориг арга хэмжээ авах журмын 5.6–ын дагуу тагнуулын байгууллага, санхүүгийн мэдээллийн алба нь тайлан, мэдээлэлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг шаардах эрхтэй. Шаардсан мэдээллийг мэдээлэгч хүн, хуулийн этгээд нэн даруй хүргүүлэх үүрэгтэй байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүргүүлэх сэжигтэй гүйлгээний тайлан мэдээллийг мэдээлэх үүрэгтэй байгууллагууд ТЕГ, СМА–д хүргүүлнэ. Нэг маягтаар мэдээлэл хүргүүлэх нь мэдээлэх үүрэгтэй байгууллагуудыг нөгөө маягтаар мэдээлэх үүргээс чөлөөлөхгүй.

Алхам 1	Царцаасан хөрөнгийг өөрийн мэдэлдээ эсхүл хяналтандаа байлгаж буй хүн, хуулийн этгээд цахим шуудангаар СМА, ТЕГ–т 24 цагийн дотор тайлан мэдээ хүргүүлнэ. Гүйлгээ хийхийг завдсан тохиолдлын талаар ч мөн мэдээлнэ.
Алхам 2	СМА–аас тайлан мэдээнд дүн шинжилгээ хийсэн мэдээллийг ТЕГ–т давхар хүргүүлнэ [дараагийн ажлын өдөр эхлэхээс өмнө] Тайлан мэдээ хүргүүлэгч хүн, хуулийн этгээдээс ТЕГ, СМА дэлгэрэнгүй мэдээллийг шаардаж болн Тайлан мэдээ хүргүүлэгч хүн, хуулийн этгээдээс ТЕГ, СМА дэлгэрэнгүй мэдээллийг шаардаж болно
Алхам 3	Хориг арга хэмжээний хэрэгжилттэй холбогдуулж ТЕГ (бусад хөрөнгө болон сүлжээг тодорхойлох зорилгоор) эсхүл тайлан мэдээтэй холбоотой эрүүгийн гэмт хэргийг илрүүлэх мөрдөн шалгах ажиллагаагаа үргэлжлүүлнэ. Гадаадын болон дотоодын хууль сахиулах болон тагнуулын байгууллагуудтай ТЕГ хамтран ажиллаж болно
Алхам 4	Тайлан мэдээний чанар, цаг хугацааны талаар СМА нь ТЕГ–тай зөвлөлдсөний үндсэн дээр саналаа хүргүүлнэ. Саналыг салбар хамарсан ерөнхий байдлаар эсхүл тодорхой хуулийн этгээдийн тухайд хүргүүлнэ. Тайлан мэдээ болгоноор санал хүргүүлэх албагүй.

## **8. Хяналт шалгалт ба хэрэгжилт**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар зохицуулагдах санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нарт санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн зүйл 23.7–д заасны дагуу дараах байгууллагыг хянан шалгах эрх бүхий байгууллага гэнэ. Үүнд:

- Банкны бизнес эрхлэгч санхүүгийн байгууллагын хувьд Монгол Банк;
- Банк бус санхүүгийн байгууллага, даатгалын компани болон аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компани, үнэт цаасны зах зээлийн аж ахуйн нэгж, хадгаламж зээлийн хоршоо болон үнэт цаасны зах зээлийн аж ахуйн нэгж, хадгаламж зээлийн хоршоо болон үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, үл хөдлөх хөрөнгө худалдан авч борлуулах хэлцэлд оролцогч бизнес эрхэлэгчдийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо;
- Хуульчдын хувьд Монголын хуульчдын холбоо;
- Нотариатчдын хувьд нотариатчдын танхим;
- Нягтлан бодогчдын хувьд Мэргэшсэн нягтлан бодогчдын институт;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар зохицуулагдах бусад бүх аж ахуйн нэгжийн хувьд Санхүүгийн мэдээллийн алба байна.

Дээр дурдсан санхүүгийн болон холбогдох бусад салбараас гадна бусад салбар, олон нийтийн хувьд хориг арга хэмжээний талаарх мэдээлэл сурталчилгаа, мониторинг болон хэрэгжилтийг ТТЗ хариуцна. Хяналт шалгалтын уялдааг ТТЗ–өөс хангана.

## **8.1 Хяналтын эрх мэдэл**

Хориг арга хэмжээний хэрэгжилтийг хянаж хангахад хяналт шалгалтын байгууллагууд бусад хуулиар олгогдсон эрх мэдлээ хэрэгжүүлэх зохицуулалтыг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7–д тусгасан.

Хэрэгжилтийг хангах зорилгоор хяналт шалгалтын байгууллага бүр (хяналт шалгалтын эрх мэдэл бүхий салбарын холбоодоос бусад нь) хуулиар олгогдсон дараах эрх хэмжээг хэрэгжүүлнэ:

- Эрх бүхий байгууллагад хүргүүлэх мэдээлэл, баримт бичгийг шаардах
- Үйл ажиллагаа, бизнесийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх.

### **8.1.1 Мэдээлэл ба баримт бичиг шаардах**

Хуулиар олгогдсон эрх мэдлийнхээ хүрээнд хяналт шалгалтын байгууллага нь хориг арга хэмжээний үүргийн биелэлтийг хянах зорилгоор аливаа хүн, хуулийн этгээдээс албан бичгээр мэдээлэл эсхүл баримт бичиг шаардаж болно.

Уг албан бичигт мэдээлэл болон баримт бичгийг ямар хугацаанд хүргүүлэх тухай тодорхой дурдана. Мөн нөхцөл байдал өөрчлөгдсөн тухай бүрт эсхүл тогтмол хугацаанд хяналт шалгалтын эрх бүхий байгууллагад мэдээлж байхыг хүн, хуулийн этгээдээс шаардаж болно.

Хүн, хуулийн этгээд нь аливаа хууль эсхүл гэрээний нөхцөлөөс үл хамааран (эрх зүйн мэргэжлийн эрх дархаас бусад) хяналт шалгалтын байгууллагын шаардлагыг биелүүлнэ.

Ирүүлсэн мэдээлэл болон баримт бичгийг хяналт шалгалтын байгууллага хянаж нягтлаад тухайн хүн, хуулийн этгээд хориг арга хэмжээний үүргээ хэрхэн биелүүлж буй талаар дүгнэлт гаргана. Хориг арга хэмжээний үүргийн биелэлт хангалтгүй, сул эсхүл дутагдалтай гэж дүгнэсэн нөхцөлд хяналт шалгалтын байгууллага газар дээр нь шалгалт явуулах, удирдамж зааварчилгаа хүргүүлэх эсхүл арга хэмжээ авах эсэхийг шийднэ.

Терроризмыг санхүүжүүлсэн эсхүл үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлсэн зэрэг гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж сэжиглэвэл хяналт шалгалтын байгууллага уг асуудлыг шалгуулахаар ТЕГ–ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хэлтэст хандана.

### **8.1.2 Газар дээрх шалгалт**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд хяналт шалгалтын байгууллага шалгаж буй хүн, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаа, орон байранд газар дээрх шалгалт явуулж болно. Уг шалгалтын хүрээнд хяналт шалгалтын байгууллага нь шалгаж буй хүн, хуулийн этгээдийн аливаа ажилтан, албан хаагч эсхүл төлөөний этгээдээс холбогдох мэдээлэл, баримт бичгийн талаар асуулт асууж шалгалтад шаардлагатай бусад мэдээллийг шаардаж болно.

Хориг арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор газар дээрх хяналт шалгалтыг тусгайлан эсхүл МУТСТ хуулийн хэрэгжилтийг хангах эсхүл зохистой харьцааг хангах зэрэг бусад хяналт шалгалттай хослуулж болно.

Газар дээрх хяналт шалгалтыг явуулах бусад журам тогтоогүй бол хяналт шалгалтын байгууллага дараах дарааллаар ажиллана. Үүнд:

Хяналт шалгалтын байгууллага нь газар дээрх хяналт шалгалтын журмыг мөдлөг болгоно.

Хориг арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой дутагдал, сул тал, хангалтгүй байдал тогтоогдсон нөхцөлд хяналт шалгалтын байгууллагаас цаашдын удирдамж заавраар хангах, ажил сайжруулах төлөвлөгөөг харилцан тохиролцох, эсхүл хэрэгжилтийг хангах, гаргасан зөрчилд хариуцлага тооцох арга хэмжээ авах тухай шийдвэр гаргана. Харин терроризмыг санхүүжүүлсэн эсхүл үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлсэн зэрэг гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж сэжиглэвэл хяналт шалгалтын байгууллага уг асуудлыг шалгуулахаар ТЕГ–ын холбогдох чиг үүрэг бүхий нэгжид хандана.

1	Хяналт шалгалтын байгууллагын газар дээрх шалгалт хийх тухай болон шалгалтын үйл явц, тавигдах шаардлагын талаарх мэдэгдлийг хүн, хуулийн этгээдэд хүргүүлнэ
2	Газар дээр хүрэлцэн очихоос өмнө бэлэн болгох материалын жагсаалтыг хүргүүлэх
3	Хяналт шалгалтын бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор этгээдэд газар дээрх шалгалтын хөтөлбөр хүргүүлэх
4	Удирдлага болон ажилтнуудтай уулзалт зохион байгуулах
5	Баримт бичгийн жишиг, ажилтнуудтай хийсэн ярилцлага болон газар дээрх шалгалтын өмнөх баримт бичиг, удирдлагын уулзалт
6	Шалгалтын дараах уулзалт зохион байгуулж дүгнэлтийг танилцуулах
7	Газар дээр шалгалтын дараах тайлан боловсруулж холбогдох арга хэмжээ авах зорилгоор хүргүүлэх. Шаардлагатай бол ажил сайжруулах төлөвлөгөөг харилцан тохиролцох
8	Хяналт шалгалтын дараах үйл ажиллагаа явуулах

## 8.2 Хэрэгжилтийг хангах хувилбар

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7–д заасны дагуу хориг арга хэмжээний хэрэгжилтийг хангаагүй хүн, хуулийн этгээдэд өөрийн хяналт шалгалтын эрх мэдлийн хүрээнд сахилгын арга хэмжээ авч болно.

- Зөрчлийн тухай хуулийн 5.10.2, 5.10.4. болон 5.10.5. –т *Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд тусгасан* үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн тохиолдолд хувь хүнийг 20000 нэгжээр, хуулийн этгээдийг 200000 нэгжээр торгохоор тусгасан.
- Зөрчлийн тухай хуулийн 11.29.9–т *Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд тусгагдсан санхүүгийн зорилтот хориг арга хэмжээтэй холбоотой шаардлага*, үүрэг хариуцлага зөрчсөн хувь хүнийг 20000 нэгжээр, хуулийн этгээдийг 200000 нэгжээр торгож гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хөрөнгийг хураахаар тусгасан.

“Нэг нэгж” гэж Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг ойлгоно.

Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо Зөрчлийн тухай хуулийн дагуу өөрийн хянаж шалгадаг байгууллагад шийтгэл ногдуулж болно. Нотариатчдын танхим, Монголын хуульчдын холбоо, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт зэрэг байгууллагын хяналт шалгалтанд хамрагддаг салбар болон хяналт шалгалтанд хамрагддаггүй хувь хүн, хуулийн этгээдэд Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн харьяаллын дагуу СМА, ТЕГ–аас шийтгэл ногдуулна. Зөрчлийн хуулийн дагуу авч буй арга хэмжээтэй холбоотой маргааныг иргэний хуулиар шийдвэрлэнэ.

Түүнчлэн гаргасан зөрчил нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл болох нь тогтоогдсон тохиолдолд Эрүүгийн хуулийн 29.10.2–т заасан хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг ТЕГ–т хандаж холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулна. Хориг арга хэмжээний хэрэгжилтийг хангах бүхий л арга хэмжээний талаар ТТЗ, ТЕГ–г улирал тутамд мэдээлнэ. ТТЗ–ийн ажлын алба, ТЕГ–ын холбогдох албан тушаалтан хориг арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн арга хэмжээний нэгдсэн бүртгэлийг хөтлөж улирал тутамд ТТЗ болон МУТСТ ХАЗ–д мэдээлнэ.

### **8.3 Эрсдлийн үнэлгээ**

ТТЗ–ийн ажлын алба, ТЕГ–ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хэлтсээс терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийн эсрэг хориг арга хэмжээний эрсдэлийн үнэлгээг СМА зэрэг байгууллагын хамтаар хийнэ. Эрсдэлийн үнэлгээ нь терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ, салбарын эрсдэлийн үнэлгээ болон хуулийн этгээдийн түвшний эрсдэлийн үнэлгээ зэргээс бүрдэнэ. Эрсдэлийн үнэлгээнд терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэл болон терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийн эсрэг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэхээс зайлсхийх эрсдэлийг мөн тооцно.

### **8.3.1 Терроризмыг санхүүжүүлэх эрсдэл**

Терроризмыг санхүүжүүлэх эрсдэл Монгол Улсад харьцангуй бага, олон улсын террорист байгууллага болох Аль–Каида, Талибан эсхүл Исламын Улс–ISIL–ын үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа, гэмт хэрэг бүртгэгдээгүй. Түүнчлэн Монгол Улс нь гадаад террорист дайчдын гол үүр гэж тогтоогдоогүй, терроризмтой холбоотой гэмт хэрэг, террорист халдлага, үйл ажиллагаа гараагүй байна. Хэдий тийм боловч ашгийн бус байгууллагаар дамжин терроризм үйлдэгдэх эрсдэлтэйгээс гадна түүнд тавих хяналт шалгалт сул, банкнаас бусад салбарын санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний хэрэгжилт, хяналт шалгалт сул байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй байна.

### **8.3.2 Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээний эрсдэл**

БНАСАУ–ын хөдөлмөр эрхлэгчид, аж ахуйн нэгж, хуулийн этгээд Монгол Улсад үйл ажиллагаа явуулах, хувь эзэмшилтэй байх зэрэг нь манай улсыг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээнээс зайлсхийх эрсдэл байж болзошгүйг харуулж байна. Хэдийгээр Монгол Улс нь Иран болон БНАСАУ–тай хийх худалдааны эргэлт хязгаарлагдмал авч БНАСАУ–тай түүхэн уламжлалт харилцаатайгаас гадна газарзүйн байрлалын хувьд ойр байгаа зэрэг нь хориг арга хэмжээг хэрэгжүүлэхээс зайлсхийх эрсдэлтэй хэмээн ФАТФ–аас үзэж байгаа.

## **9. Хориг арга хэмжээний хэрэгжилтийг хангах**

Санхүүгийн хориг арга хэмжээ авах журам буюу Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын 6–д зааснаар МУТС тухай хуулийн 4.1–т заасан мэдээлэх үүрэгтэй этгээд буюу санхүүгийн байгууллага, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нарт дараах арга хэмжээ авах үүргийг ногдуулсан. Үүнд:

- Өөрийн харилцагчдын мэдээллийг жагсаалтад орсон, хасагдсан хүн, хуулийн этгээд болон царцаасан хөрөнгийг чөлөөлөх мэдээлэлтэй тулгаж шалгасны үндсэн дээр үйлчилгээ үзүүлэх;

- Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хяналтад байгаа болон түүний заавраар үйл ажиллагаа явуулдаг эсэхийг тогтоох зорилгоор санхүүгийн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх шалгуурыг бий болгож харилцагчийг таньж мэдэх ажиллагаанд ашиглах;
- Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хяналтад байгаа болон түүний заавраар санхүүгийн гүйлгээ хийж буй эсэхийг тогтоох зорилгоор санхүүгийн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх шалгуурыг бий болгож гүйлгээний хяналтын ажиллагаанд ашиглах;
- Өндөр эрсдэлтэй харилцагчид болон түүний харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан ажиллагааг хэрэгжүүлэх;
- Холбогдох ажилтнуудад санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ болон холбогдох хууль, тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах;
- Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа жагсаалтыг НҮБ–ын Аюулгүйн Зөвлөл болон тагнуулын байгууллагаас гаргасан жагсаалтад нийцүүлэн тогтмол шинэчилнэ.

Уг арга хэмжээг тухайн биснесийн онцлог болон цар хүрээтэй уялдуулж авна. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нь ямар ч нөхцөлд терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийн эсрэг хориг арга хэмжээний эрсдэлийн үнэлгээг хийх ёстой. Өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон нөхцөлд иж бүрэн арга хэмжээ авах шаардлагатай.

## **10. Нууцлал ба тоон мэдээллийн хамгаалалт**

### **10.1 Нууцлал**

Гэмт хэргийн талаарх мэдэгдэл, нэмэлт баримт материал, мэдээлэл болон гадаад улс орны засгийн газартай харьцсан мэдээллийн нууцлалыг хангана.

### **10.2 Мэдээллийн хадгалалт**

Нууцлагдах мэдээллийг найдвартай хадгалах, хамгаалах журмыг боловсруулж батална.

## **11. Мэдээлэл солилцоо**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 10.1.4–д заасны дагуу ТЕГ нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг бүхий болон төрийн захиргааны төв байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах журмыг батлуулан ажиллана.

Хориг арга хэмжээ авах журмын 2.6–д заасны дагуу ТЕГ нь хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах санал гаргахдаа эрх бүхий хяналт шалгалтын, хууль сахиулах болон холбогдох бусад байгууллага, ижил төстэй гадаадын байгууллага болон үндэслэл бүхий эх сурвалжийн мэдээ, мэдээллийг ашиглах, тус мэдээллийг шаардаж, хянах эрхтэй байна.

Энэхүү журмын 2.8–д заасны дагуу ТТЗ, ТЕГ нь Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болон тус журамд заасан санхүүгийн хориг арга хэмжээг бодлогын түвшинд хэрэгжүүлж, хяналт шалгалт, хууль сахиулах асуудал хариуцсан болон бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах эрхтэй байна.

Дээрх журамд заасны дагуу ТТЗ, ТЕГ нь НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн холбогдох хороодтой албан шугамаар харилцахдаа Гадаад харилцааны яамтай хориг арга хэмжээний жагсаалттай холбоотой асуудлаар мэдээлэл солилцох эрхтэй байна.

## **12. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх төлөвлөгөө**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмыг санхүүжүүлсэн хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааг дараах төлөвлөгөөний дагуу явуулна. Уг төлөвлөгөөнд хориг арга хэмжээний хэрэгжилт болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмыг санхүүжүүлэх эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааны хоорондын уялдааг хангана. Үүнд:

- Мэдээллийн эх сурвалж
- Хориг арга хэмжээний тайлан (Хориг арга хэмжээ авах журмын 5 дугаар зүйл)
- Сэжигтэй гүйлгээний мэдээ (МУТСТ тухай хуулийн 7 дугаар бүлэг )
- Дотоодын хуулийн хэрэгжилт болон гүйцэтгэх ажил
- Гадаад улс орны мэдээллийн эх сурвалж (цагдаа, тагнуул, дипломат)
- НҮБ–ын хоригийн жагсаалт эсхүл экспертийн бүлгийн дүгнэлт тайлан

ТЕГ–ын МУТС тэмцэх хэлтэс

Хөрөнгө царцаах болон хязгаарлах (ТЕГ нь СМА–тай хамтран хөрөнгө тодорхойлох; ТЕГ нь хөрөнгө царцаах талаар прокурорын байгууллагатай хамтран ажиллах )

ТЕГ нь хориг арга хэмжээний жагсаалтанд оруулах асуудлыг шийдвэрлэнэ (Хориг арга хэмжээний журмын 2 дугаар зүйл)

Эрүүгийн хэрэг үүсгэх (Зүйл 29.11 зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэрэг, 29.10 терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг)

Хориг арга хэмжээний дагуу хөрөнгө царцаах мэдэгдлийг ТЕГ–аас хүргүүлж шаардлагатай бол хяналт шалгалтын байгууллагатай хамтран хэрэгжилтийг хангах арга хэмжээ авах

## **Хавсралт 1**

**Шалгах журам: Терроризмыг санхүүжүүлэх (ТС), үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ (ҮОХЗДСЗХАХ) ба өндөр эрсдэл бүхий улс орны арга хэмжээ**

### **Удиртгал**

Мэдээлэх үүрэгтэй байгууллага нь дараах бодлого, журам болон хяналтын тогтолцоотой байна. Үүнд:

- Терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг тодорхойлж царцаах ба энэ тухай СМА, ТЕГ–т мэдэгдэх;
- Өндөр эрсдэл бүхий улс орны тухайд шаардлагатай бол сөрөг арга хэмжээ авах, энэ талаар СМА, ТЕГ–т мэдэгдэх.

Мэдээлэх үүрэгтэй байгууллага нь эдгээр шаардлагыг биелүүлэх үр дүнтэй журам боловсруулж нэвтрүүлсэн эсэхийг хяналт шалгалтын байгууллага хянана.

### **Шалгалтын зорилго**

1. Хориг арга хэмжээний жагсаалтад буй хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг царцаах зорилгоор харилцагчыг таньж мэдэх, гүйлгээг хянах болон хориг арга хэмжээний жагсаалтад буй хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг царцаах тухайд мэдээлэх үүрэгтэй байгууллагаас баримтлах бодлого болон журмыг хянаж дүгнэлт гаргах.
2. Хориг арга хэмжээнээс зайлсхийх өндөр эрсдэлтэй бол харилцагчийн холбоо харилцаа болон гүйлгээг нягтлан судлах талаар мэдээлэх үүрэгтэй байгууллагаас баримтлах бодлого болон журмыг хянаж дүгнэлт гаргах.
3. Хууль журмын шаардлагыг хэрхэн хангаж байгаа талаар дүгнэлт гаргах.

## **Шалгалтын журам**

### **Терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дотоод хяналтын асуулга**

1. Дараахтай холбогдуулж захирлуудын зөвлөлөөс хориг арга хэмжээний бодлого, журам боловсруулж нэвтрүүлсэн эсэх:
  - Терроризм ба терроризмыг санхүүжүүлэх;
  - Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх ба түүнийг санхүүжүүлэх;
  - Өндөр эрсдэл бүхий улс орны хувьд сөрөг арга хэмжээ авах;
2. Хориг арга хэмжээний жагсаалтад буй хүн, хуулийн этгээдийг тодорхойлох журам байгаа эсэх ба эдгээр журмаар тухайн харилцагчдыг дээр дурдсан харилцаанд орж байхад явцын дунд тодорхойлох боломжтой юу?
3. Эрх бүхий байгууллагын удирдамжийн дагуу найдвартай хяналтанд байлгах мэдээлэх үүрэгтэй байгууллагын мэдэлд буй хөрөнгийг эдгээр журмаар яаралтай царцаах боломжтой юу?
4. Хөрөнгийг захиран зарцуулахыг завдсан харилцагчийн эсхүл бусад талуудын зүгээс гаргасныг эдгээр журмаар хянан тогтоох боломжтой юу?
5. Эрх бүхий байгууллагын удирдамжаар барьцаалсан буюу царцаасан хөрөнгөд нэвтрэх боломжийг эдгээр журмаар олгодог уу?
6. Эдгээр журмаар эрх бүхий байгууллагын удирдамжаар хөрөнгө чөлөөлөх боломжтой юу?
7. Жагсаалтанд буй хүн, хуулийн этгээдийн хөрөнгөд нэвтрэх оролдлого болон бусад аливаа үйлдлийг заагдсан хугацаанд СМА, ТЕГ–т мэдэгдэх мэдэгдлийн төрлийг эдгээр журамд дурдсан уу?

### **Өндөр эрсдэлтэй улсын хувьд авах хариу арга хэмжээ**

8. Эрх бүхий байгууллагаас өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон улс нь харилцагчийн тогтоосон харилцаа болон гүйлгээг тодорхойлох зорилгыг эдгээр журам агуулсан уу?
9. Мэдээлэх үүрэгтэй байгууллагад эрх бүхий байгууллагын удирдамжийг үр дүнтэй хэрэгжүүлж буйг хариуцах хүнийг уг бодлого болон журмаар тодорхойлсон уу? Эдгээр бодлого болон журамд дараахыг тусгана. Үүнд:

- a) Харилцагчийн талаарх нэмэлт мэдээлэл, гүйлгээний зорилго, харилцагчийн бизнесийн чиглэл болон мөнгөн бусад хөрөнгийн эх үүсвэр зэргийг тодорхойлох иж бүрэн суурь судалгаа бий эсэх;
  - b) Харилцааг цааш үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн удирдлагын зөвшөөрөл;
  - c) Гүйлгээний нарийн хяналт;
  - d) Корресподент банкны харилцааг хянах, өөрчлөх, цуцлах асуудал.
10. Өндөр эрсдэл бүхий улстай холбоотой тайлан мэдээг заагдсан хугацаанд засгийн газрын холбогдох байгууллагад хүргүүлэх тайлан мэдээний төрлийг эдгээр журамд дурдсан уу?

#### **Гүйлгээний туршилт**

- Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, улсын талаарх холбогдох мэдээлэл, жагсаалт тухайн байгууллагад бий эсэхийг тодорхойлох.
- Сүүлийн шалгалтаас хойш хугацаанд нээсэн дансны гүйлгээг нягтлан шалгах замаар тус дансны гүйлгээ болон харилцааг жагсаалттай харьцуулж (эрх бүхий байгууллагын удирдамжаар) тухайн мэдээлэл нь харилцагчийг таньж мэдэх бодлого, журам болон дотоод хяналттай нийцсэн эсэхийг тогтоох.
- Харилцагчийг хориг арга хэмжээний жагсаалтанд байгаа хүн, хуулийн этгээд хэмээн тодорхойлсон бол тухайн байгууллагын ажилтан түүний хэрэгжилтийг хангах албан тушаалтанд энэ тухай мэдээлж байгааг тогтоох.
- Данс болон хөрөнгийг яаралтай царцаах, царцаасан данс болон хөрөнгийг хянах, дотоод тайлан мэдээллийн зохицуулалттай холбоотой үйл явцыг тогтоож үнэлэх.
- Тайлан, мэдээг ТЕГ, СМА–д хүргүүлэхэд түүний хэрэгжилтийг хангах албан тушаалтны гүйцэтгэх үүрэг, оролцоог тодорхойлох.
- Өндөр эрсдэлтэй улсын эсрэг арга хэмжээ авч Засгийн газрын холбогдох байгууллагад энэ тухай мэдээ хүргүүлэх үүргийг уг албан тушаалтан хүлээнэ.

## **Маягт 1**

### **Хэргийн талаарх мэдэгдэл болон хавтаст хэрэг**

#### **Удиртгал**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 2.2–д заасны дагуу (бусад улсын засгийн газраас ирүүлсэн хүсэлт) хориг арга хэмжээний жагсаалтанд оруулах эсэхтэй холбоотой шийдвэрийг мэдээлэх зорилгоор ТЕГ–аас тайланг боловсруулав. Мөн энэхүү журмын 3.1–ийн дагуу НҮБАЗ–д жагсаалтанд оруулах санал гаргахад уг тайланг ашиглаж болно.

#### **Суурь мэдээлэл**

[Тухайн хүн, хуулийн этгээдийг жагсаалтанд оруулах саналын учир шалтгааны талаарх мэдээлэл]

Хэргийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт А болон бусад хавсралтад тусгав.

#### **Товч дүгнэлт**

[Хүн, хуулийн этгээдийг жагсаалтанд оруулах болон давтан оруулахтай холбоотой товч дүгнэлт]

#### **Зөвлөмж**

[Жагсаалтанд оруулах болон давтан оруулах зөвлөмж]

#### **Баталсан**

Тайланд гарын үсэг зурсан огноо: \_\_\_\_\_

Тайланг боловсруулсан: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

[Байгууллага]

Зөвшөөрсөн: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

[Албан тушаал]

\_\_\_\_\_

[Байгууллага]

НББСЗҮҮ–дэд зориулсан МУТС эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага

<b>А хэсэг – Тодорхойлох үндсэн мэдээлэл</b>	
<b>Овог, нэр</b> (хүний нэр)	
<b>Тайлбар</b> (товчилсон болон бусад нэр)	

<b>Төрсөн огноо</b>	Газар(гудамж, хот, муж/дүүрэг, улс орон): Өдөр: Сар: Он: Календарь:
---------------------	--

<b>Яс, үндэс, иргэний харьяалал</b> (Өмнөх, шинэ харьяаллыг олгосон, хассан, цуцалсан огноо, мэдэж байгаа бол)	Одоогийн: Хугацаа:
	16465270108
Оршин суугаа улс	Өмнөх: Хугацаа:
<b>Хаяг</b> ( хаягт оршин суусан хугацаа)	Одоогийн (гудамж, хот, муж/дүүрэг, улс орон): Хугацаа:
	Өмнөх (гудамж, хот, муж/дүүрэг, улс орон): Хугацаа:
<b>Байршил</b> (Хаягаас өөр үйл ажиллагааны тогтмол байршлыг дурдах)	Одоогийн (гудамж, хот, муж/дүүрэг, улс орон): Хугацаа:
	Өмнөх (гудамж, хот, муж/дүүрэг, улс орон): Хугацаа:

В хэсэг – Хувийн мэдээлэл болон гадаад паспортны мэдээлэл  
Мэдээлэл байхгүй хэсгүүдийг хоосон үлдээх. Баримт бичгийн хувийг хавсаргах.  
А хэсэгт дурьдсан нэрээр баримт бичиг үйлдсэн болон дараагийн хуудсан дахь  
С хэсэгт дурьдсан нэрээр үйлдсэн эсэхийг дурдах. Тодорхой баримт бичгийн нэр болон төрсөн огноо болон газруудын хоорондын хамаарлыг тусгах.  
Мөн баримт бичиг үйлдээгүй нийгмийн даатгалын дугаар, эсхүл регистрын дугаарыг дурьдах.

<b>Баримт бичгийн төрөл</b> (гадаад паспорт, төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, оршин суух зөвшөөрлийн үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтэр, жолооны үнэмлэх)	
<b>Баримт бичгийн дугаар</b>	
<b>Олгосон байгууллага</b>	
Олгосон (гудамж, хот, муж/дүүрэг, улс)	
<b>Олгосон өдөр</b>	Өдөр: Сар: Он: Календарь:
Хүчинтэй хугацаа	Өдөр: Сар: Он: Календарь:
<b>Олгосон</b> (Нэр ,баримт бичигт бичсэн үсгээр. Үсгийг хаалтанд тодорхойлох.)	
Баримтанд тусгагдсан төрсөн газар, огноо	Газар((гудамж, хот, муж/дүүрэг, улс орон) Өдөр: Сар: Он: Календарь:
Баримтанд тусгагдсан яс, үндэс	
Нэмэлт мэдээлэл, санал	

<b>Хэсэг С – Бусад мэдээлэл</b>	
<b>Цол хэргэм</b> (мэргэшлийн болон эрдмийн, цол хэргэм)	
<b>Ажил эрхлэлт/албан тушаал</b> (ажил эрхэлтийн хугацаа болон албан тушаал)	
<b>Гэрлэлтийн байдал</b>	

НББСЗҮҮ–дэд зориулсан МУТС эрсдэлд суурилсан  
аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага

<b>Статус</b>	Эрэн сурвалжилж буй эсэх/ баривчлагдаж байсан эсэх/ ял авсан эсэх	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Тийм бол тайлбарлах:
	<b>Саатуулагдсан</b> (хүн саатуулагдсан, батлан даалтад байгаа болон хоригдсон болохыг тодорхойлох. Саатуулагдсан огноо, байршил болон нөхцөл байдал, суллагдсах огноох тусгах)	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Тийм бол тайлбарлах:
	<b>Яллагдсан / Ял авсан</b> (тухайн хүн яллагдсан/ял авсан болон эрх зүйн ямар статустай байгааг дурьдах. Мөн ялын тухай мэдээлэл, гэмт хэргийн төрөл, ялласан/ял авсан огноо, суллах огноо, албадан гаргах болон ялтан солилцох зэрэг болзошгүй арга хэмжээтэй холбоотой мэдээллийг тусгах)	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Тийм бол тайлбарлах:
	<b>Бусад</b> (урьд нь эрхээ хасуулсан, албадан гаргасан, шоронгоос суллагдсан, оргон зайлсан зэрэг тухайн хувь хүнтэй холбоотой хуулийн арга хэмжээ авсныг дурьдах)	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Тийм бол тайлбарлах:
<b>Интерполын мэдээ</b> (эрх бүхий байгууллагын хүсэлтээр тухайн хувь хүний талаар Интерполоос ирүүлсэн мэдээ, мэдээллийг тусгах)	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Тийм бол тайлбарлах:  Уг мэдээллийг олон нийтэд мэдээллэх эсхүл Гишүүд орны хүсэлтээр хүргүүлдэг эсэх? Үгүй Олон нийтэд тарааж болно Гишүүн улсын хүсэлтээр хүргүүлнэ	
<b>Холбогдох бусад мэдээлэл</b>		
<b>Эцэх, эхийн овог, нэр</b>	Эцгийн нэр	
	Эхийн нэр	

<b>Хэсэг D – Биеийн мэдээлэл</b>			
<b>Өндөр</b> (см)		<b>Нүдний өнгө</b>	
<b>Жин</b> (kg)		<b>Үсний өнгө</b>	
<b>Онцлог</b> (Жишээ нь хүнд жингийн)		<b>Гадаад төрөх</b>	
<b>Эрэгтэй/эмэгтэй</b>			
<b>Зураг, ам зураг, компьютерийн зураг–ыг хавсаргасан эсэх?</b> (зургийг Интерпол–НҮБАЗ–ийн тусгай мэдэгдэлд хавсаргаж болно)		Тийм Үгүй Тийм бол, зургийн төрөл:	
<b>Биеийн бусад мэдээллийг хавсаргасан эсэх?</b> (жишээ нь, хурууны хээ, ДНК код, царайны цахим дүрс зэргийг Интерпол–НҮБАЗ–ийн тусгай мэдэгдэлд ашиглаж болно)		Тийм Үгүй Тийм бол, зургийн төрөл:	
<b>Содон шинж тэмдэг, биеийн бусад шинж тэмдэг</b> (жишээ нь, сорви, шивээс, дутуу хуруу)			
<b>Овог/Бүлэг/Гарал үүслийн талаарх мэдээлэл</b>			
<b>Хэлний мэдээлэл</b> (тухайн хүний ярьдаг хэл–төрөлх, унаган эсхүл бага зэрэг эзэмшсэн болохыг тусгах)			

**Хэсэг Е – Дээр дурдагдаагүй бусад мэдээлэл**

--

**Хэсэг F –Хориг арга хэмжээний жагсаалтанд оруулах үндэслэл**

Тухайн хүн, хуулийн этгээдийг жагсаалтан оруулах болсон үндэслэлийг доорх нэг болон түүнээс дээш зайд тусгах. Доор дурьдсан нэг ба түүнээс олон шалгуурт нийцсэн этгээд итгэл үнэмшилтэй байх үндэслэлийг харуулах зорилгоор Хэсэг G–д тусгасан хэргийн талаарх мэдэгдэлд нотолгоо бүхий мэдээллийг хавсаргах.

1373 тоот тогтоолын 1(с) хэсэгт тухайн хүн, хуулийн этгээдийг дурьдсан.

2270 тоот тогтоолын хэсэг 32–т тухайн хүн, хуулийн этгээдийг дурьдсан.

1718 тоот тогтоолоор эсхүл түүнийг залгамжлан гарах тогтоолоор хориглосон үйл ажиллагаатай тухайн хүн, хуулийн этгээд холбоотой.

Тухайн хүн, хуулийн этгээд НҮБАЗ–ийн дараах тогтоолоор хориглосон үйл ажиллагаатай холбоотой хүн, хуулийн этгээд холбоотой: 1267 (1999) 1989 (2011) болон 2253 (2015) тоот ISIL (Da'esh) болон Ал–Кайда–ийн тогтоол; 1988 (2011) тоот Талибаны тогтоол.

**Хэсэг G – Хэргийн талаарх мэдэгдэл**

Хэргийн талаарх мэдэгдэлийн жагсаалтанд оруулах үндэслэл, мэдээллийг дэлгэрэнгүй тусгана. Үүнд: (i) Тухайн хүн дээр дурдсан шалгуурт нийцэж байгааг нотлох тодорхой мэдээлэл; (ii) мэдээллийн эх сурвалж, жишээ нь, тагнуул, хууль сахиулах байгууллага, шүүх, хэвлэл болон сэдэвчилсэн; (iii) гадаад улс болон НҮБАЗ эсхүл түүний хороодоос хүргүүлсэн мэдээлэл; ба (iv) хүргүүлсэн бусад холбогдох мэдээлэл эсхүл баримт бичиг. Хэргийн талаарх мэдэгдэлд жагсаалтанд оруулахаар санал болгож хувь хүн болон жагсаалтанд буй хүн, хуулийн этгээдтэй холбоотой тухай мэдээллийг мөн тусгана.

## Маягт 2

### Тагнуулын ерөнхий газар

***Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 2.2–ын дагуу хориг арга хэмжээний жагсаалтанд оруулах***

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмаар НҮБАЗ–ийн тогтоолоор хориглосон үйлдэлтэй холбоотой тухай итгэл үнэмшилтэй бол хүн, хуулийн этгээдийг хориг арга хэмжээний жагсаалтанд оруулна. Хүн, хуулийн этгээдийн хориг арга хэмжээний жагсаалтанд оруулснаар тухайн хүн, хуулийн этгээдэд санхүүгийн хэлцэл хийхийг хориглоно.

Журмын 2.2–ын дагуу ТЕГ нь хүн, хуулийн этгээдийг НҮБАЗ–ийн тогтоолын шалгуурыг хангаж байгаад итгэл, үнэмшилтэй байхыг үндэслэн өөрийн саналаар эсхүл гадаад улсын хүсэлтээр тухайн хүн, хуулийн этгээдийг нэн даруй хориг арга хэмжээний жагсаалтанд оруулна.

*Хориг арга хэмжээний жагсаалтанд оруулах шийдвэр [хүн/хуулийн этгээд]*

ТЕГ–ын ажилтан \_\_\_\_\_ миний бие нь \_\_\_\_\_–холбогдулан энэхүү журмын 2.2–ын дагуу хориг арга хэмжээний жагсаалтанд оруулах шалгуур хангасан тухай өөрийн итгэл үнэмшилд үндэслэн \_\_\_\_\_–ийг \_\_\_\_\_ өдрөөс эхлэн хориг арга хэмжээний жагсаалтанд үүгээр оруулсан болно.

ТЕГ–аас хориг арга хэмжээний жагсаалтыг цуцлах хүртэл энэхүү шийдвэр хүчин төгөлдөр байна.

Мэдэгдсэн

[Гарын үсэг]

[Нэр]

[Огноо]

### **Маягт 3**

**Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 2.2–д заасны дагуу хориг арга хэмжээний жагсаалтанд хүн, хуулийн этгээдийг оруулах тухай гадаад улсын засгийн газрын хүсэлт**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 2.2–д заасны дагуу хүн, хуулийн этгээдийг хориг арга хэмжээний жагсаалтанд оруулах хүсэлтийг судлан, хянах зорилгоор Монгол Улсын засгийн газарт дараах мэдээлэл шаардагдана. Нэмэлт мэдээлэл болон баримт бичгийг маягтад хавсаргаж болно. Хүсэлтийг ТЕГ–т шууд болон дипломат шугамаар хүргүүлнэ.

### **Хэсэг А – Гадаад улсын засгийн газрын мэдээлэл**

Хориг арга хэмжээний жагсаалтанд оруулахыг санал болгож буй улс орны нэр

Гадаад улсын эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал

Эрх бүхий этгээдийн шуудангийн хаяг:

Эрх бүхий этгээдийн хаяг:

Утасны дугаар:

Факс No:

Цахим шуудангийн хаяг:

Гар утасны дугаар:

Санал болгож буй этгээдийн төрөл:

Аль нэгийг сонгох:

Хүн ( В хэсгийг бөглөх)

Хуулийн этгээд) ( С хэсгийг бөглөх)

**Хэсэг В – Санал болгож буй этгээд (Хүн)**

**Хувийн мэдээлэл**

Санал болгож буй этгээдийн анхдагч нэр:

\_\_\_\_\_

Хүйс:  Эмэгтэй

Санал болгож буй этгээдийн хамаарал:

\_\_\_\_\_

Санал болгож буй этгээдийг хүсэлт гаргагч улс орон жагсаалтанд оруулсан эсэх?

Аль нэгийг:  Тийм

Үгүй

Тийм бол жагсаалтын талаарх мэдээлэл,

Үгүй бол тайлбарлах :

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Төрсөн огноо: \_\_\_\_\_ Үндэс: \_\_\_\_\_

Овог/Угсаа гарлын талаарх мэдээлэл:

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Оршин суух улс орон: \_\_\_\_\_

Бүртгэгдсэн хаяг: \_\_\_\_\_

Паспортны мэдээлэл: \_\_\_\_\_

Төрсний гэрчилгээний мэдээлэл: \_\_\_\_\_

Иргэний үнэмлэхний мэдээлэл: \_\_\_\_\_

Жолооны үнэмлэхний мэдээлэл: \_\_\_\_\_

Мэргэжил:

---

Гэр бүлийн байдал:

---

Биеийн тодорхойлолт:

---

---

Онцгойлох тэмдэг/Биеийн бусад тодорхойлолт:

---

Гэмт хэрэгт ногдуулсан ял болон шоронд хорих хугацаатай холбоотой  
мэдээлэл:

---

---

---

Террорист байгууллага болон хориг арга хэмжээнд хамрагдсан үй  
олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэгч этгээдтэй хамааралтай байдал:

---

---

Нэмэлт мэдээлэл:

---

Хориг арга хэмжээний жагсаалтанд оруулах үндэслэл:

---

---

---

---

---

Нарийвчилсан мэдээлэл:

---

---

---

---

---

---

---

Нэмэлт мэдээлэл:

---

---

---

---

---

---

---

### **Хуулийн этгээдийн талаарх мэдээлэл**

Хуулийн этгээдийн бүртгэгдсэн нэр:

---

Хуулийн этгээдийн хамаарал:

---

---

Санал болгож буй этгээдийг санал хүргүүлэгч улсын хориг арга  
хэмжээний жагсаалтанд оруулсан уу?

Аль нэгийг сонгох:  Тийм

Үгүй

Тийм бол жагсаалтын талаарх мэдээлэл,

Үгүй бол тайлбарлах:

---

Хуулийн этгээдийн төрөл/үйл ажиллагаа:

---

Бүртгэлийн дугаар:

---

Бүртгэсэн байгууллага:

---

Бүртгэгдсэн хаяг:

---



**Хэсэг С – Санал болгож буй этгээд (Хуулийн этгээд)**

Цахим хуудасны хаяг:

---

---

Өмчлөгч/Захирлын нэр:

---

---

Үйл ажиллагааны чиглэл:

---

---

Хамаарал бүхий болон Харьяалах бүлэг/ Хуулийн этгээд/ Үйл  
ажиллагаа:

---

---

Санхүүгийн эх үүсвэр:

---

Хориг арга хэмжээний жагсаалтанд оруулах этгээдийн холбогдох гэмт  
хэрэгт ногдуулсан хүү, торгуулийн талаарх мэдээлэл :

---

Нэмэлт мэдээлэл:

---

---

Хориг арга хэмжээний жагсаалтанд оруулах үндэслэл:

---

---

---

---

---

---

---

---

Нарийвчилсан мэдээлэл:

---

---

---

---

---

Нэмэлт мэдээлэл:

---

---

---

---

---

**Хэсэг D – Гадаад улсын засгийн газрын эрх бүхий төлөөлөгчийн мэдэгдэл**

Энэхүү хүсэлтээр хүргүүлсэн мэдээлэл үнэн зөв болохыг үүгээр баталж байна.

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Нэр

Албан тушаал

Гарын үсэг

Огноо

Хүлээн авсан огноо:

Хүсэлтийн дугаар:

Хүсэлтийг хянан боловсруулах мэргэжилтэн:

Ажилтны дугаар:

**Албан хэрэгцээнд**

#### Маягт 4

##### Тагнуулын ерөнхий газар

[Хаяг]

[Огноо]

#### **Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 2.5 дахь хэсгийг үндэслэн хүн, хуулийн этгээдийг хориг арга хэмжээний жагсаалтанд оруулсан мэдэгдэл**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын [ 2.1 эсхүл 2.2 заалтыг] заалтыг үндэслэн ТЕГ–аас [таныг/ танай байгууллагыг] “хориг арга хэмжээний жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээд”–ийн жагсаалтанд оруулсаныг уг журмын 2.5 заалтын дагуу [огноо]–ий өдөр үүгээр мэдэгдэж байна.

Таныг/танай байгууллагыг жагсаалтанд дараах үндэслэлээр оруулав.

ТЕГ–аас таныг/танай байгууллагыг хориг арга хэмжээний жагсаалтанд оруулахдаа дараах үндэслэлийг харгалзав. Үүнд::

- a) [үндэслэл]
- b) [үндэслэл]
- c) [үндэсний аюулгүй байдлын улмаас]

Жагсаалтанд байх хугацаа

[Та/ танай байгууллага]–ын хориг арга хэмжээний жагсаалт цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр байна.

Хөрөнгө царцаах үүрэг

Хориг арга хэмжээний жагсаалтанд оруулсантай холбогдуулж жагсаалтад оруулсан хүн эсхүл хуулийн этгээдийн шууд болон шууд бусаар өмчлөх, хянах, тэдгээрийн заавраар үйл ажиллагаа явуулах, хөрөнгийг захиран зарцуулдаг, хянадаг бүхий л хүн, хуулийн этгээд.

Хориг арга хэмжээний жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдэд хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглох

Хориг арга хэмжээний жагсаалтанд оруулсантай холбогдуулж НҮБАЗ–ийн тогтоол түүнийг залгамжлах гарах бусад тогтоолоор, ТЕГ–аас жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдэд шууд болон шууд бусаар, дангаараа болон хамтран, ашгийн төлөө хүн, хуулийн этгээдэд хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

Жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдийн өмчлөх, хянах тэдгээрийн өмнөөс, заавраар үйл ажиллагаа явуулах хүн, хуулийн этгээдэд хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

Жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдэд хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх хоригыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд *Зөрчлийн тухай хуулийн* дагуу сахилгын арга хэмжээ авах, торгууль ногдуулах, эрүүгийн гэмт хэргийг шалгах ажлыг явуулна.

Хориг арга хэмжээний жагсаалтанд хүн, хуулийн этгээдийг оруулсныг хянах

*Тагнуулын ерөнхий газарт гомдол гаргах (ТЕГ)*

Уг журмын 4.2.3–ын дагуу ТЕГ–аас жагсаалтанд оруулах шалгуур хангаж байгааг тодорхойлох зорилгоор жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдийг 5 жил тутамд хянана.

Жагсаалтанд оруулсан асуудлаар ТЕГ–г гомдол гаргах эрхтэй. Жагсаалтанд оруулсан тухай хүн, хуулийн этгээдээс өргөдөл хүлээн авч, журмын 4.2.1 заалтыг үндэслэн ТЕГ өргөдлийг даруй хянаж шийдвэр гаргана. ТЕГ нь өргөдөл гаргагчаас тодруулга авч болно, шийдвэр гаргахад шаардлагатай нэмэлт мэдээлэл, баримт бичгийг гаргуулж авах бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

4.2.1 болон 4.2.3 заалтыг үндэслэн жагсаалтанд оруулах шалгуурыг хангаагүй эсхүл хангахаа больсон гэдгийг ТЕГ тогтоовол 4.2.3 заалтыг үндэслэн ТЕГ тухайн хүн, хуулийн этгээдийг жагсаалтаас нэн даруй хасна.

*Хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүхээр хянуулж болно.*

Жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдэд хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрөх

Журмын 4.6 заалтыг үндэслэн ТЕГ нь НҮБАЗ–ийн тогтоолыг үндэслэн дараах зардал, санхүүгийн үйлчилгээтэй холбодуулан хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрч болно. Үүнд:

- a) Суурь зардал
- b) Зарим төрлийн төлбөр, хураамж, зардал, үйлчилгээний төлбөр
- c) Гэрээгээр хүлээсэн үүрэг
- d) Онцгой төрлийн зардал
- e) Зөвшөөрч болох бусад зардал

[Та/танай байгууллага] бусад асуудлаар зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаж болно. Өргөдлийг бичгээр, ТЕГ–ын цахим хуудсан буй маягт 7–ийн дагуу үйлдэж ТЕГ–т дараах байдлаар хүргүүлнэ. Үүнд:

a) шуудангаар:

[хаяг]

b) цахим шуудангаар:

[цахим шуудангийн хаяг]

Жагсаалтаас гарах өргөдөл

*[2.1 заалтын дагуу жагсаалтанд оруулсан]*

[Та/танай байгууллага] жагсаалтаас нэрээ хасуулах хүсэлтээ НҮБАЗ түүний холбогдох хориг арга хэмжээний хороонд уламжилж болно. Жагсаалтаас нэрээ хасуулах хүсэлт гаргах нь хүн, хуулийн этгээдийн нь холбогдох журамтай НҮБАЗ–ийн :[www.un.org/securitycouncil/sanctions/information](http://www.un.org/securitycouncil/sanctions/information) цахим хуудаснаас танилцана уу.

*[2.2 заалтын дагуу жагсаалтанд оруулсан]*

[Та/танай байгууллага] жагсаалтаас гарах өргөдлөө ТЕГ–ын цахим хуудсанд буй маягтын дагуу ТЕГ–т гаргаж болно. Шаардлагатай гэж үзвэл ТЕГ нь уг журмын 4.2.2 заалтыг үндэслэн [Та/танай байгууллага] –ыг тодруулга авч болно, шийдвэр гаргахад шаардлагатай нэмэлт мэдээлэл, баримт бичиг гаргуулан авч болно.

Тохиолдлоор өртсөн хүн, хуулийн этгээд

Хэрэв [Та/танай байгууллага] нь тохиолдлоор хөрөнгө царцаах арга хэмжээнд өртсөн хүн, хуулийн этгээд бол хөрөнгө чөлөөлөх өргөдлөө гаргаж болно.

[ТЕГ] танай өргөдлийг хянаж өргөдөл гаргаснаас хойш ажлын 30 хоногийн дотор [Та/танай байгууллага]–д шийдвэрээ мэдээлнэ.

Холбогдох маягтын ТЕГ–ын цахим хуудаснаас авч бөглөн дараах байдлаар хүргүүлнэ. Үүнд:

а) шуудангаар:

[хаяг]

б) цахим шуудангаар:

[цахим шуудангийн хаяг]

Нэмэлт мэдээлэл

Монгол Улсын Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний орчны талаарх нэмэлт мэдээллийг цахим хэлбэрээр [цахим хуудасны холбоосыг дурдах]–аас авч болно.

[Гарын үсэг]

[Нэр]

[ТЕГ]

## **Маягт 5**

### **Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийн тайлан**

Монгол Улсад байнга болон түр хугацаагаар оршин сууж буй хүн, хуулийн этгээд болон гадаад улсад оршин сууж буй Монгол Улсын иргэн, хуулийн этгээд нь жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдийн тэдгээрийн өмнөөс заавраар үйл ажиллагаа явуулдаг хүн, хуулийн этгээдийн өмчлөл, хяналтанд байгаа хөрөнгөтэй харьцах, тэдэнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх болон хөрөнгө олгож болохгүй.

Царцаасан хөрөнгөтэй холбоотой авсан арга хэмжээний талаар Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 5.5 заалтын дагуу хүн, хуулийн этгээд мэдээлнэ. Гүйлгээ хийх аливаа оролдлогын талаар ч мэдээлэх үүрэгтэй.

Бөглөсөн маягтыг дараах хаягаар 24 цагийн дотор хүргүүлнэ. Үүнд

Санхүүгийн мэдээллийн алба болон ТЕГ–т (мэдээлэх үүрэгтэй байгууллагын хувьд): [fiu@mongolbank.mn](mailto:fiu@mongolbank.mn); [amlcft@gia.gov.mn](mailto:amlcft@gia.gov.mn); хаягаар илгээнэ.

Тагнуулын ерөнхий газар, Терроризмтой тэмцэх зөвлөлд (бусад бүх байгууллага): [amlcft@gia.gov.mn](mailto:amlcft@gia.gov.mn); [tfs@nctc.gov.mn](mailto:tfs@nctc.gov.mn) хаягаар илгээнэ.

**Мэдээлэл хүргүүлж буй хүний талаарх мэдээлэл**

Мэдээлэгч хүн/байгууллагын нэр:

Салбар/нэгж (шаардлагатай бол):

Шуудангийн хаяг:

Гудамжны хаяг (өөр хаяг бол):

Холбоо барих хүн:

Утасны дугаар:

Цахим шуудангийн хаяг:

**Хөрөнгийн талаарх мэдээлэл**

Захиран зарцуулж буй, эзэмших эсхүл хянах хөрөнгийн тайлбар:

Хөрөнгийн царцаасан эсэх: Тийм  Үгүй

Хөрөнгө царцаасан огноо:

**Сэжиглэгдэж буй хөрөнгийн өмчлөгч, хянаж байгаа хүн (жагсаалтанд оруулсан хүн эсхүл хуулийн этгээдийн өмнөөс эсхүл заавраар үйл ажиллагаа явуулах хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг оролцуулах).**

Нэр:

Шуудангийн хаяг:

Гудамжны хаяг (өөр бол):

Утасны дугаар (мэдэж байгаа бол):

Иргэний үнэмлэхний мэдээлэл (мэдэж байгаа бол):

Хувийн баримт бичгийн хуулбарыг хавсаргасан: Тийм  Үгүй

Хөрөнгө царцаах үндэслэл:

**Гүйлгээ хийх орлогын талаарх мэдээлэл**

Шилжүүлэгч этгээдийн нэр:

Шилжүүлэгч этгээдийн шуудангийн хаяг:

Шилжүүлэгч этгээдийн гудамжны хаяг (өөр бол):

Шилжүүлэгч этгээдтэй холбоотой бусад мэдээлэл:

Санхүүгийн эх үүсвэр:

Хүлээн авагчийн нэр:

Хүлээн авагчийн шуудангийн хаяг:

Хүлээн авагчийн хаяг:

Улс:

Муж/дүүрэг/хот:

Хүлээн авагчийн талаарх бусад мэдээлэл:

Гүйлгээ хийхийг завдсан огноо ба байршил

Хийхээр завдсан гүйлгээний зориулалт:

Хүсэлт гаргасан санхүүгийн үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

**Дэлгэрэнгүй бусад мэдээлэл**

## **Маягт 6**

### **Тагнуулын ерөнхий газар**

#### **Мэдээллийг хянах маягт**

Монгол Улсад байнга болон түр хугацаагаар оршин суугаа хүн, хуулийн этгээд, гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн хүн, бүртгэлтэй хуулийн этгээд нь жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдийн болон тэдгээрийн өмнөөс, заавраар үйл ажиллагаа явуулдаг хүн, хуулийн этгээдийн өмчлөл, хяналтанд байгаа хөрөнгөтэй харьцах, тэдэнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө олгож болохгүй.

Царцаасан хөрөнгөтэй холбоотой хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 5.5 заалтын дагуу хүн, хуулийн этгээд мэдээлнэ. Гүйлгээ хийх аливаа оролдлогын талаар мэдээлэх үүрэгтэй болно.

Тухайн хүн, хуулийн этгээд нь жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээд мөн эсэхэд эргэлзсэн тохиолдолд дараах маягтаар мэдээллийг хянуулах хүсэлт гаргана.

Мэдээллийг хянах үйл ажиллагаа явагдаж байх хугацаанд санхүүгийн зорилтод арга хэмжээний хүрээнд сэжиглэгдэж байгаа хөрөнгийг царцаасан байх ба хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

Бөглөсөн маягтыг дараах байгууллагад хүргүүлнэ. Үүнд

Тагнуулын ерөнхий газар: [amlcft@gia.gov.mn](mailto:amlcft@gia.gov.mn) хаягаар илгээнэ.

Терроризмтой тэмцэх зөвлөл: [ifs@nctc.gov.mn](mailto:ifs@nctc.gov.mn) хаягаар илгээнэ.

**Мэдээллийг хянах хүсэлт гаргасан хүний талаарх мэдээлэл**

Хүсэлт гаргагч хүн/байгууллагын нэр: Шуудангийн хаяг: Гудамжны хаяг (өөр хаяг бол): Холбоо барих хүн: Утасны дугаар:	
Цахим шуудангийн хаяг:	
Шалгуурт нийцсэн эсэх мэдээлэл	
Банкны харилцагч <input type="checkbox"/>	Төлбөрийн хайлт <input type="checkbox"/>
Банкны харилцагч бус <input type="checkbox"/>	Мэдээллийн сангийн <input type="checkbox"/>
Харилцагчийн овог, нэр: Харилцагчийн хаяг: Харилцагчийн төрсөн он, сар, өдөр: Холбогдох данс: Шалгуурт нийцэж буй хөрөнгийн талаарх нарийвчилсан мэдээлэл: Этгээдийн баримт бичгийн талаарх нарийвчилсан мэдээлэл: Этгээдийн баримт бичгийн хувийг хавсаргасан эсэх: Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тайлбар: Монгол Улсын жагсаалтын дугаар: НҮБАЗ–ийн нэгдсэн жагсаалтын дугаар: Хүн, хуулийн этгээдийн нэр: Төлбөрийн талаарх мэдээлэл (шаардлагатай бол)	
Шилжүүлэгч этгээдийн нэр: Шилжүүлэгч этгээдийн шуудангийн хаяг: Шилжүүлэгч этгээдийн гудамжны хаяг (өөр бол): Шилжүүлэгч этгээдтэй холбоотой бусад мэдээлэл: Санхүүгийн эх үүсвэр: Хүлээн авагчийн нэр: Хүлээн авагчийн шуудангийн хаяг: Хүлээн авагчийн хаяг: Улс: дүүрэг/хот: Хүлээн авагчийн бусад мэдээлэл (Банкин дахь дансны мэдээлэл): Гүйлгээ хийгдсэн огноо ба байршил	

НББСЗҮҮ–дэд зориулсан МУТС эрсдэлд суурилсан  
аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага

Хийгдсэн гүйлгээний зориулалт:

Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээ хүргүүлсэн эсэх: Тийм  Үгүй

Тийм бол хүргүүлсэн огноо:

Мэдээний дугаар:

Бусад мэдээлэл

### ТЕГ бөглөнө

Мэдээ хүлээн авсан огноо:

Хүлээн авсан хэлбэр:

Факс:  Цахим шуудан:  Утсаар:

### ТЕГ–тай холбогдох мэдээлэл:

Албан тушаал:

Утас:

Факсны дугаар:

Цахим шуудангийн хаяг:

### ТЕГ–аас хариу хүргүүлсэн талаарх мэдээлэл

Хариу хүргүүлсэн огноо:

Цахим шуудангаар хүргүүлсэн:

### Хариу

Тухайн хүн, хуулийн этгээд нь жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээд байх магадлалтай

Тухайн хүн хуулийн этгээд нь жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээд байх магадлал үгүй

Тухайн хүн, хуулийн этгээд нь жагсаалтанд оруулсан хүн хуулийн этгээд мөн эсэх нь тодорхойгүй


**Нэмэлт мэдээлэл (шаардлагатай бол)**

**Маягт 7**

**Тагнуулын ерөнхий газар**

**Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 4.5 заалтыг үндэслэн жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд хөрөнгө, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл хүсэх тухай**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмыг хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ авах таны хүсэлтийг шийдвэрлэхэд дараах мэдээлэл шаардагдана. Үүнд: **Өргөдөл гаргагчийн талаарх мэдээлэл**

### Өргөдөл гаргагчийн мэдэгдэл

Өргөдөл гаргагч хүн/ хуулийн этгээдийн нэр:

Өргөдөл гаргагчийн байнгын хаяг:

Өргөдөл гаргагчийн шуудангийн хаяг: (өөр бол):

Холбоо барих хүний нэр:

Утасны дугаар:

Факсны дугаар:

Цахим шуудангийн хаяг:

Гар утасны дугаар.:

Өргөдөл гаргагч жагсаалтанд оруулсан хүнтэй хэрхэн хамааралтай болох тухай  
(өөрөө жагсаалтанд оруулсан хүн биш бол):

### Царцаасан хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

Хүсэмжилж буй царцаасан хөрөнгө, санхүүгийн үйлчилгээний талаарх мэдээлэл:

Жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдийг тодорхойлох:

Журмын 4.5 заалтын дагуу зөвшөөрөх үндэслэл (зохих хэсгийг тэмдэглэх):

Суурь зардал

Зарим төлбөр хураамж, зардал болон үйлчилгээний төлбөр

Гэрээгээр хүлээсэн үүрэг

Онцгой зардал

Зөвшөөрөгдөх бусад зардал

Хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зориулалт:

Хөрөнгө, санхүүгийн үйлчилгээ хүлээн авагч:

### Өргөдөл гаргагчийн мэдэгдэл

Өргөдөлд тусгасан мэдээлэл үнэн зөв болохыг баталж байна.

Нэр

Мэргэжил

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Гарын үсэг

Огноо

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Гэрчийн нэр

Гэрчийн мэргэжил

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Гэрчийн гарын үсэг

Огноо

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

### Тэмдэглэл

**Албан хэрэгцээнд**

Хүлээн авсан огноо:

Өргөдлийн дугаар:

Шаардлагатай хэсэг:

Бөглөх шаардлагатай хэсэг:

Асуудал шийдвэрлэх албан тушаалтан:

Албан тушаалтны хувийн дугаар:

## Маягт 8

### Тагнуулын ерөнхий газар

**Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилгод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 4.6 заалтыг үндэслэн жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээдэд хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрөх**

ТЕГ–ын ажилтан \_\_\_\_\_ би хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хүссэн өргөдлийг хянаж Хавсралт А–д тусгагдсан хөрөнгө, санхүүгийн үйлчилгээ нь \_\_\_\_\_ зориулалтаар ашиглагдах нь үнэн тогтоосон тул НҮБАЗ–ийн холбогдох тогтоолын дагуу [өргөдөл гаргагчийн нэрийг дурдах] –т Хүснэгт А–д дурьдсан нөхцлийн дагуу \_\_\_\_\_ хөрөнгө олгохыг зөвшөөрөв.

Мэдэгдсэн

[Гарын үсэг]

[ТЕГ]

[Огноо]

**I. Хөрөнгө, санхүүгийн үйлчилгээний талаарх мэдээлэл**  
[тайлбар]

**Хавсралт А**

**II. Үндсэн шалгуурт нийцсэн зардал, гэрээгээр хүлээсэн үүрэг:**

a. [Суурь зардлыг дурьдах, хоол хүнс зэрэг]

b. [гэрээгээр хүлээсэн үүргийг дурьдах, хувь хүн/хуулийн этгээдийг  
жагсаалтанд оруулахаас өмнө үүссэн гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүрэг]

c. [онцгой зардлыг дурьдах]

d. Бусад зөвшөөрөгдөх үндэслэлийн тайлбар

**III. Хэсэг I –т дурьдсан хөрөнгө олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг  
зөвшөөрөх нөхцөл:**

a. [нөхцөл]

b. [нөхцөл]

c. [нөхцөл].

## Маягт 9

### Тагнуулын ерөнхий газар

**Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 4.2–д заасны дагуу хориг арга хэмжээний жагсаалтаас хасач**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмаар НҮБАЗ–ийн тогтоолоор хориглосон үйл ажиллагаатай холбоотой нь сэжиглэх хангалттай үндэслэлтэй хүн, хуулийн этгээдийг хориг арга хэмжээний жагсаалтанд оруулахыг зохицуулсан.

*Хориг арга хэмжээний жагсаалтанд оруулсныг цуцлах шийдвэр [хувь хүн/ хуулийн этгээдийн нэр]*

ТЕГ–ыг төлөөлж [эрх бүхий албан тушаалтны нэр] миний бие [хүн/хуулийн этгээдийн нэрийг дурдах]–г хориг арга хэмжээний жагсаалтанд оруулсаныг хянаж журмын 2.2–д заасныг үндэслэн шалгуур үзүүлэлтийг цаашид хангахгүй байгаа нөхцөл тогтоогдож байгаа тул [хүн/хуулийн этгээдийн нэрийг дурдах]–г хориг арга хэмжээний жагсаалтаас өнөөдрөөс эхлэн хассаныг үүгээр мэдэгдэж байна.

Энэхүү шийдвэр гарсан даруйд хүчин төгөлдөр болж хориг цуцлагдаж байгаа болно.

[Гарын үсэг]

[ТЕГ]

[Огноо]

## Маягт 10

### Тагнуулын ерөнхий газар

[Хаяг]

[Огноо]

**Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилгод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 4.7 заалтыг үндэслэн хүн, хуулийн этгээдийг хориг арга хэмжээний жагсаалтаас хассан тухай мэдэгдэл**

Он, сар, өдөр

ТЕГ–аас Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилгод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 2.2–д заасныг үндэслэн [хүн/хуулийн этгээдийн нэрийг дурдах]–г хориг арга хэмжээний жагсаалтанд оруулсан тухай танд мэдэгдсэн байна. Уг хориг арга хэмжээ \_\_\_\_\_–ийн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Журмын 4.7 заалтыг үндэслэн ТЕГ–аас [жагсаалтаас хассан огноог дурдах] өдөр журмын 4.2–д заасны дагуу хориг арга хэмжээний жагсаалтанд оруулсныг цуцлав. Хориг арга хэмжээг цуцласан шийдвэр [жагсаалтаас хассан огноог дурдах ] өдрөөс хүчин төгөлдөр болох ба уг журмаар [хүн/хуулийн этгээдийн нэрийг дурдах]–д тогтоосон бүхий л хоригийг цуцлаж байгаа болно.

*Нэмэлт мэдээлэл*

Монгол Улсын санхүүгийн зорилгот хориг арга хэмжээний орчны тухай нэмэлт мэдээллийг [цахим хуудасны холбоосыг дурдах] цахимаар авч болно

[Албан тушаалтны нэр]

[ТЕГ]

## Маягт 11

### Тагнуулын ерөнхий газар

**Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 4.4 заалтыг үндэслэн хамааралтай байж болзошгүй нөхцөл байдлын улмаас хөрөнгө царцсан хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг чөлөөлөх захирамж**

[Огноог дурдах] өдөр [хүн/хуулийн этгээдийн нэрийг дурьдах]–ийн хөрөнгийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 2.1 дэх заалт, НҮБАЗ–ийн тогтоолын хэрэгжүүлэх журмын 2.2 заалтын дагуу хориг арга хэмжээний жагсаалтанд оруулсны улмаас хөрөнгө нь царцсан байна.

ТЕГ–ыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтны дүгнэлтээр хамааралтай байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсоны улмаас хөрөнгийг нь царцаасан хүн, хуулийн этгээдийн хөрөнгө чөлөөлөх өргөдлийг хянаж [хүн/хуулийн этгээдийг дурдах] нь жагсаалтанд оруулсан хүн, хуулийн этгээд биш болохыг хянаж үзсэний үндсэн дээр уг журмын 4.4 заалтын дагуу [хүн/хуулийн этгээдийг дурьдах]–ийн хөрөнгийг нэн даруй чөлөөлөхийг үүгээр үүрэг болгож байна.

[Гарын үсэг]

[Эрх бүхий албан тушаалтны нэр]

[ТЕГ]

[Огноо]

**Хүснэгт А**

**Дотоодын хориг арга хэмжээний жагсаалт**

**Хувь хүн**

Дугаар	Нэр	Хүйс	Жагсаалт	Төрсөн огноо	Төрсөн газар	Шаардлага хангах шинж тэмдэг	Шаардлага хангахгүй шинж тэмдэг	Үндэс	Паспортын дугаар	Иргэний үнэмлэх	Хааг	Жагсаалтанд оруулсан огноо	Бусад мэдээлэл

**Хуулийн этгээд**

Дугаар	Нэр	Албан бус нэршил	Албан нэршил	Хааг	Жагсаалтанд оруулсан огноо	Бусад мэдээлэл



## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны 10 дугаар сарын  
10–ны өдөр

Улаанбаатар хот

### **ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ**

**/Шинэчилсэн найруулга/**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино.

#### **2 дугаар зүйл.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хууль тогтоомж**

2.1.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“терроризм” гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төрийн байгуулал, нийгэм, эсхүл түүний тодорхой хэсэгт нөлөөлөн айдасг автуулахаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг;

3.1.2.“олон улсын терроризм” гэж олон улсын харилцаа, улс орнуудын төрийн хяналт, удирдлагад нөлөөлөх зорилго бүхий улс дамжсан терроризмыг;

3.1.3.“террорист үйл ажиллагаа” гэдэгт доор дурдсан үйлдлийг ойлгоно:

3.1.3.а.террорист үйлдлийг төлөвлөх, бэлтгэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх;

3.1.3.б.террорист үйлдэлд оролцох, террорист байгууллага, аливаа бүлэгт элсэх, сургалт, бэлтгэлд хамрагдах;

3.1.3.в.терроризмд хүн, хуулийн этгээдийг татан оролцуулах, элсүүлэх, ашиглах, сургах, зэвсэглэх;

3.1.3.г.террорист үйлдэлд бэлтгэхээр аливаа бүлэг, байгууллага байгуулах;

3.1.3.д.терроризмыг олон нийтэд зөвтгөх, дэлгэрүүлэх, суртал ухуулга явуулах;

3.1.3.е.террорист үйлдэлд хүн, хуулийн этгээдийг уриалах, өдөөн хатгах, турхирах, албадах;

3.1.3.ё.терроризмыг санхүүжүүлэх, шууд болон шууд бусаар аливаа туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

3.1.3.ж.террорист үйлдэлд зориулан аливаа юмс, зэвсэг, хэрэгсэл, технологийг зохион бүтээх, үйлдвэрлэх, тараах, эзэмших, ашиглах, өмчлөх, хадгалах, хянах.

3.1.4. “террорист үйлдэл” гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төр, олон улсын байгууллагаас хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардаж хүн амыг айдаст автуулах, хүнийг алах, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахыг;

3.1.5. “террорист этгээд” гэж террорист, террорист байгууллагыг;

3.1.6. “террорист” гэж өөрийн хүсэл зоригоор, сайн дураар, санаатайгаар террорист үйл ажиллагааг шууд болон шууд бусаар үйлдэх, түүнд оролцож байгаа хүнийг;

3.1.7. “террорист байгууллага” гэж террорист үйл ажиллагааг шууд болон шууд бусаар үйлдэх, эсхүл түүнд оролцохоор өөрийн хүсэл зоригоор, сайн дураар, санаатайгаар нэгдсэн террористуудын аливаа бүлэг, нэгдлийг;

3.1.8. “терроризмтой тэмцэх” гэж терроризмын суурь нөхцөл бүрдэх, террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хохирол, хор уршгийг арилгахаар авч хэрэгжүүлж байгаа улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгдлийг;

3.1.9. “терроризмын суурь нөхцөл” гэж тухайн нутаг дэвсгэр, түүний тодорхой хэсэг, барилга байгууламж, объект, террорист үйл ажиллагаанд өртөж болзошгүй хүчин зүйл, нөхцөл байдлыг;

3.1.10. “террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа” гэж террорист үйлдлийг таслан зогсоох, террорист этгээдийг аюулгүй болгох, баривчлах, хүн, хуулийн этгээдийн аюулгүй байдлыг хангах, хор уршгийг багасгах зорилгоор цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон төрийн цэргийн байгууллагын томилгоот хүч хэрэгслээр нэгдмэл бодлого, төлөвлөгөө, удирдлагаар гүйцэтгэх цогц ажиллагааг;

3.1.11. “террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны хүч хэрэгсэл” гэж террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд томилогдсон удирдлагын, хангалтын, тусгай ажиллагааны бүлэг, түүнд дэмжлэг үзүүлэх хэсгийн нэгдэл, тэдгээрийн ашиглах зэвсэглэл, техник хэрэгслийг;

3.1.12. “террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүс” гэж террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулахаар энэ хуульд заасны дагуу тогтоосон нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг, барилга байгууламж, объект, эдгээртэй залгаа орших байршлыг;

3.1.13. “террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүсийн дэглэм” гэж террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүсэд хуульд заасны дагуу террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны Шуурхай штаб /цаашид “Шуурхай штаб” гэх/-аас тогтоосон онцгой нөхцөлийг;

3.1.14. “террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны Нэгдсэн удирдлагын төв /цаашид “Нэгдсэн удирдлагын төв” гэх/” гэж террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг удирдан зохион байгуулах, явуулах, үр дүнг Терроризмтой тэмцэх зөвлөлд танилцуулах үүрэг бүхий тусгайлан томилогдсон алба хаагчийн нэгдлийг;

3.1.15. “Шуурхай штаб” гэж террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүсэд сөрөг тусгай ажиллагаа явуулах томилгоот хүч хэрэгслийн нэгдлийг;

3.1.16. “хориг арга хэмжээ” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолын дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой хориг арга хэмжээг;

3.1.17. “хориг арга хэмжээний жагсаалт” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолын дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой баталсан хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг;

3.1.18. “дотоодын жагсаалт” гэж үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотойгоор терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас баталсан хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг;

3.1.19. “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх /цаашид “зэвсэг дэлгэрүүлэх” гэх/” гэж Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглосон цөмийн, химийн, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах, ашиглах аливаа үйл ажиллагааг;

3.1.20. “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглосон цөмийн, химийн, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах, ашиглахад бүрэн, эсхүл хэсэгчилсэн санхүүгийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхийг;

3.1.21. “хөрөнгө царцаах” гэж аливаа хөрөнгө, мөнгөн хөрөнгийн хөдөлгөөнийг эрх бүхий этгээдийн шийдвэрээр албадан битүүмжлэх, хураан авах хүртэл хугацаанд захиран зарцуулах, шилжүүлэх, удирдах эрхийг хязгаарлахыг.

3.2. Зэвсэгт мөргөлдөөн болон террорист үйл ажиллагаанд оролцох зорилгоор өөрийн төрөлх, эсхүл оршин суугаа улсаас өөр улсад зорчсон хүнийг энэ хуулийн 3.1.6–д заасан террорист гэж үзнэ.

#### **4 дүгээр зүйл.Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагааны зарчим**

4.1.Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараах зарчмыг удирдлага болгоно:

4.1.1.тогтвортой, цогц, уялдаа холбоотой, шуурхай, тасралтгүй байх;

4.1.2.терроризмын аюулд өртсөн хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болох хохирол, хор уршгийг багасгах;

4.1.3.терроризмтой тэмцэх арга, техник хэрэгсэл, оролцогчдын нууцлал, аюулгүй байдлыг хангах;

4.1.4.терроризмтой тэмцэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны удирдлага нэгдмэл, төвлөрсөн, тогтвортой байх;

4.1.5.судалгаа, шинжилгээнд суурилсан, шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, шинэ мэдлэгт үндэслэсэн байх;

4.1.6.төрөөс хүн, хуулийн этгээд, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх.

#### **5 дугаар зүйл.Олон улсын хамтын ажиллагаа**

5.1.Төр, нийгэм, хүний аюулгүй байдлыг хангахын тулд Монгол Улсын олон улсын гэрээний дагуу гадаад улс, олон улсын байгууллагатай зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлээр хамтран ажиллана.

#### **6 дугаар зүйл.Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх арга хэмжээний үндсэн чиглэл**

6.1.Төрөөс зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

6.1.1.терроризмын нөхцөл байдал, түүний суурь нөхцөлийг үнэлэх;

6.1.2.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

6.1.3.терроризмын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх үйл

ажиллагааг хэрэгжүүлж, терроризмоос ангид байх үзлийг төлөвшүүлэх;

6.1.4.терроризм үл нутагших, террорист этгээд нэвтрэхгүй, орогнохгүй байх орчин нөхцөлийг бүрдүүлэх;

6.1.5.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бэлэн байдлыг хангах;

6.1.6.хүн, хуулийн этгээд, улсын онц чухал объект, хүн ам олноор төвлөрсөн газрыг террорист үйлдлээс сэргийлэн хамгаалах;

6.1.7.террорист үйлдэлд өртөх эрсдэлийг бууруулах, түүнээс үүсэх хохирол, хор уршгийг багасгахад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

6.1.8.зэвсэг, бодис, хэрэгсэл, юмсыг террорист үйлдэлд ашиглахаас сэргийлэх;

6.1.9.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлээр олон улсын болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах;

6.1.10.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхэд хүн, хуулийн этгээд, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагын оролцоог нэмэгдүүлэх.

6.2.Энэ хуулийн 6.1.1–д заасан терроризмын нөхцөл байдлыг үнэлэхдээ бүс нутаг, улс оронд үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй терроризм, түүний чиг хандлага, арга хэлбэр, аюул занал, эрсдэлд дүн шинжилгээ хийж, олон улсын байгууллагын зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх бодлого, үйл ажиллагааг харгалзан дүгнэлт гаргана.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХ**

### **7 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

7.1. Улсын Их Хурал зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх төрийн бодлого, хууль тогтоомжийг батлах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.2. зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгаж батлах.

### **8 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх**

8.1. Монгол Улсын Ерөнхийлөгч зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч–Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь бүрэн эрхийн хүрээнд зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагын тайлан, мэдээллийг сонсох, Засгийн газарт чиглэл өгөх;

8.1.2. террорист үйлдлийн улмаас онц байдал тогтоосон үед цэрэг хөдөлгөх захирамж гаргах;

8.1.3. зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар хуульд заасны дагуу холбогдох дүрмийг батлах.

### **9 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

9.1. Засгийн газар зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжид нийцүүлэн үндэсний хөтөлбөр, баримт бичгийг батлах, хэрэгжүүлэх;

9.1.2.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хууль тогтоомжийн биелэлтийг хангах, энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар, чиглэл өгөх;

9.1.3.хуульд өөрөөр заагаагүй бол зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр байгуулах;

9.1.4.терроризмтой тэмцэх үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын томилгоот бүлгийг оролцуулах саналыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчид тавих;

9.1.5.террорист үйлдлийн улмаас онц байдал тогтоох нөхцөл байдал үүссэн тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомжийн дагуу онц байдал тогтоох асуудлыг тавьж шийдвэрлүүлэх;

9.1.6.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн хориг арга хэмжээний тогтоолыг даруй хэрэгжүүлэх;

9.1.7.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлд хүн, хуулийн этгээдийг хориг арга хэмжээний жагсаалтад оруулах, хасах тухай хүсэлт гаргах;

9.1.8.терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг үндэслэн дотоодын жагсаалтыг батлах;

9.1.9.хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүний жагсаалт батлах.

## **10 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын бүрэн эрх**

10.1.Тагнуулын байгууллага зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.терроризмтой тэмцэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;

10.1.2.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох тухай саналаа Засгийн газарт хүргүүлэх;

10.1.3.хуульд заасны дагуу хүн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас шаардлагатай мэдээллийг гаргуулан авах, мэдээллийн

нэгдсэн сан үүсгэх;

10.1.4.үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн захиргааны төв байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах журмыг холбогдох байгууллагын саналыг үндэслэн батлах;

10.1.5.Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглосон цөмийн, химийн, биологийн болон үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, тоног төхөөрөмж, техник, технологи, тэсэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх хорт бодис, зэвсэг, цахим сүлжээ бусад техник хэрэгсэл, эд зүйл, юмсыг террорист үйлдэлд ашиглахаас, терроризм болон зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүн, хуулийн этгээдэд шаардлага хүргүүлэх, биелэлтийг хангуулах;

10.1.6.Нэгдсэн удирдлагын төв, Шуурхай штабыг удирдлага, зохион байгуулалтаар хангах.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮНДЭС**

### **11 дүгээр зүйл.Терроризмтой тэмцэх зөвлөл**

11.1.Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага, холбогдох төрийн байгууллагын зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий орон тооны бус Терроризмтой тэмцэх зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийг Тагнуулын ерөнхий газрын даргаар ахлуулан байгуулна.

11.2.Зөвлөл нь хуульд заасан эрх хэмжээгээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын албатай байх бөгөөд түүний албан хаагчийг Тагнуулын ерөнхий газрын дарга томилж, чөлөөлнө.

11.3.Ажлын албаны албан хаагч нь тагнуулын байгууллагын албан хаагч байна.

11.4.Зөвлөлийн ажиллах журам, ажлын албаны бүтэц, орон тоог Засгийн газар, Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд Тагнуулын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн батална.

11.5.Зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

11.6.Зөвлөл, түүний ажлын албаны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

11.7.Аймаг, нийслэл дэх Зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөл /цаашид “салбар зөвлөл” гэх/-ийг аймаг, нийслэлийн Засаг дарга даргална.

11.8.Зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, бэлгэдэл, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

## **12 дугаар зүйл.Зөвлөлийн эрх хэмжээ**

12.1.Зөвлөл дараах эрх хэмжээг хэрэгжүүлнэ:

12.1.1.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үндэсний хөтөлбөр, төсөл, нэгдсэн төлөвлөгөө, тайлан, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж Ерөнхий сайдад танилцуулах;

12.1.2.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

12.1.3.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлээр төрийн байгууллага, иргэн, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;

12.1.4.энэ хуулийн 6.2–т заасан үнэлгээг хийж, дүгнэлтийг Ерөнхий сайд болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бусад гишүүнд танилцуулах, терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагыг шуурхай мэдээллээр хангах;

12.1.5.энэ хуулийн 6.1.3–т заасан чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

12.1.6.хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохицуулах;

12.1.7.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах, хамтарсан сургууль, нэгдсэн дадлагыг улсын хэмжээнд зохион байгуулах;

12.1.8.Нэгдсэн удирдлагын төвийг байгуулах;

12.1.9.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлээр салбар зөвлөл, холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үүрэг, даалгавар, заавар, зөвлөмж, чиглэл өгөх, түүний хэрэгжилтэд хяналт тавих.

12.2.Салбар зөвлөл энэ хуулийн 12.1.3, 12.1.5–д заасан эрх хэмжээг хэрэгжүүлж, харьяа нутаг дэвсгэртээ зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос урьдчилан сэргийлэх, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

### **13 дугаар зүйл.Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар төрийн байгууллага, албан тушаалтны үүрэг**

13.1.Төрийн байгууллага, албан тушаалтан зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

13.1.1.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн төлөвлөх, хэрэгжүүлэх;

13.1.2.Зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх, хэрэгжилтийг тайлагнах;

13.1.3.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах, хохирол, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

13.1.4.терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагатай мэдээлэл солилцох, судалгаа болон эрсдэлийн үнэлгээ хийх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

13.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнд багтдаг байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 13.1–д зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:

13.2.1.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үндэсний хөтөлбөр, нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, үр дүнг Зөвлөлд тайлагнах;

13.2.2.энэ хуулийн 12.1.4–т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг Зөвлөлд тухай бүр гаргаж өгөх;

13.2.3.Зөвлөлтэй үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээлэл солилцох, дэмжлэг үзүүлэх, мэргэшсэн албан хаагчийг ажиллуулах.

#### **14 дүгээр зүйл.Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос урьдчилан сэргийлэх талаар хүн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг**

14.1.Хүн, хуулийн этгээд зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

14.1.1.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой холбоотой мэдээ, мэдээллийг төрийн байгууллагад даруй өгөх;

14.1.2.террорист үйлдэл, үйл ажиллагаанд өдөөн хатгасан аливаа явуулга, суртал ухуулга, үзэл санаанд автахгүй байх;

14.1.3.терроризмыг сурталчлах, олон нийтэд уриалах, нийтийн өмнө зөвтгөх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх;

14.1.4.терроризмоос сэргийлэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг явуулах, хохирол, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

14.2.Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүү, бусад бүх төрлийн үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг хориглоно.

#### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТЕРРОРИСТ ҮЙЛДЛИЙН СӨРӨГ ТУСГАЙ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС**

##### **15 дугаар зүйл.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа**

15.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дараах ажиллагаа хамаарна:

15.1.1.террорист үйлдлийг илрүүлэх, хүн, хуулийн этгээдийг хамгаалах;

15.1.2.террорист үйлдэлд өртсөн хүн, эд хөрөнгийг аврах;

15.1.3.террорист үйлдлийн шалтгаан нөхцөлийг арилгах;

15.1.4.террорист үйлдлийг таслан зогсоох арга хэмжээг авах;

15.1.5.террорист этгээдийг баривчлах, аюулгүй болгох;

15.1.6.террорист үйлдэлд ашиглаж байгаа болон ашиглахад зориулсан эд хөрөнгө, эд зүйл, юмс, мөнгөн хөрөнгө, террорист үйл ажиллагаа, үйлдлээс олсон хөрөнгө, орлогыг илрүүлэх, хураах;

15.1.7.тухайн нөхцөл байдлаас шалтгаалан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр бэлтгэн явуулах хууль тогтоомжид заасан бусад тусгай ажиллагаа.

## **16 дугаар зүйл.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны хүч хэрэгсэл**

16.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд доор дурдсан байгууллагын хүч хэрэгсэл оролцоно:

16.1.1.тагнуулын төв байгууллага, түүний төв болон орон нутаг дахь салбар, нэгж;

16.1.2.цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан байгууллага;

16.1.3.улсын хил хамгаалах байгууллага;

16.1.4.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;

16.1.5.онцгой байдлын байгууллага;

16.1.6.дотоодын цэргийн штаб, анги, салбар;

16.1.7.терроризмтой тэмцэх Зөвлөлийн бусад бүрэлдэхүүн байгууллага;

16.1.8.зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн захирамжаар томилогдсон зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар.

16.2.Энэ хуулийн 16.1–д заасан байгууллагын мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн томилгоот хэсэг нь террорист үйлдлийн үед тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хими, биологийн бодис болон хүчтэй үйлчлэх хорт бодис илрүүлэх, аюулгүй болгох ажиллагааг гүйцэтгэнэ.

16.3.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд гадаадын цэрэг, тусгай хүчний салбар, нэгжийг Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуульд заасны дагуу оролцуулж болно.

16.4.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, газар уснаа явагч зэрэг тусгай тоноглогдсон тээврийн хэрэгсэл, зэвсэг, галт хэрэглэл, албаны нохой болон бусад тусгай техник хэрэгсэл ашиглана.

#### **17 дугаар зүйл.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг удирдах**

17.1.Зөвлөл террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны зорилго, агуулга, цар хүрээнд нийцүүлэн Нэгдсэн удирдлагын төвийг байгуулна.

17.2.Хойшлуулшгүй тохиолдолд Зөвлөлийн даргын шийдвэрээр холбогдох байгууллагын хүч хэрэгслийг шууд томилон ажиллуулна.

17.3.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг Нэгдсэн удирдлагын төв удирдаж, Зөвлөлийн шийдвэрийг террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүсэд Шуурхай штаб хэрэгжүүлнэ.

17.4.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцож байгаа хүч хэрэгсэл тусгай ажиллагаа үргэлжлэх хугацаанд Шуурхай штабын даргад шууд захирагдана.

17.5.Шуурхай штабын хүсэлт, шаардлагыг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хүн, хуулийн этгээд нэн даруй биелүүлж, түүнд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэг хүлээнэ.

#### **18 дугаар зүйл.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах журам**

18.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хууль болон холбогдох бусад хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврын дагуу явуулна.

18.2.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрмийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

18.3.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах журам, зааврыг Зөвлөлийн дарга батална.

18.4.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлсэн хүнд Засгийн газраас тогтоосон журмын дагуу урамшуулал олгоно.

18.5.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрэм, журам, зааврын нууцын зэрэглэлийг Төрийн болон албаны нууцын тухай хуульд нийцүүлэн тогтооно.

## **19 дүгээр зүйл.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүсийн дэглэм**

19.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүс, түүний дэглэмийг Шуурхай штабын дарга тогтоож, Цагдаагийн албаны тухай хуулийн Дөрөв, Тавдугаар бүлэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.4 дүгээр зүйлд заасан ажиллагааг явуулна.

19.2.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүсийн дэглэм тогтоосон үед дараах хязгаарлалтыг тогтооно:

19.2.1.олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээнд хяналт тогтоох, эсхүл террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа дууссанд тооцох хүртэл хугацаанд үйл ажиллагааг нь зогсоох;

19.2.2.радио, харилцаа холбооны хэрэгсэл ашиглахад тусгай хяналт тогтоох.

## **20 дугаар зүйл.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг дууссанд тооцох**

20.1.Террорист үйлдлийг таслан зогсоосон, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүсэд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учрах нөхцөл байдлыг арилгасан тохиолдолд Зөвлөлийн шийдвэрээр террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг дууссанд тооцно.

## **21 дүгээр зүйл.Террорист үйлдлийн хохирол, хор уршгийг арилгах**

21.1.Хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд террорист үйлдлээс үүсэх гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хуульд зааснаар зохион байгуулна.

21.2.Террорист үйлдлийн хохирлыг арилгах арга хэмжээг Засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлнэ.

## **22 дугаар зүйл.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох алба хаагчийн нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгаа**

22.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцохоор томилогдсон зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай бэлтгэл, зориулалт бүхий нэгжийн алба хаагчийг гэнэтийн осол, амь насны даатгалд заавал хамруулж, холбогдох зардлыг төр хариуцна.

22.2.Засгийн газар террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох тусгай бэлтгэл, зориулалт бүхий нэгжийн алба хаагчийн галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж болон бусад эдийн хангалтыг хариуцна.

22.3.Энэ хуулийн 16.1–д заасан байгууллагын алба хаагч террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцсоны улмаас гэмтсэн, эрүүл мэндэд нь хохирол учирсан бол эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү болон хиймэл эрхтэн хийлгэх, амраах, нөхөн сэргээхтэй холбогдох зардлыг төр хариуцна.

22.4.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны үед үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид олгох албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.

22.5.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгжид ажилласан алба хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сартай дүйцүүлэн тооцно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ**

### **23 дугаар зүйл.Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх нийтлэг журам**

23.1.Хориг арга хэмжээг энэ хуульд заасан журмын дагуу даруй хэрэгжүүлнэ.

23.2.Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалт батлах, жагсаалтаас гаргах, түүнийг хянах, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг царцаах, эрхийг түр хязгаарлах, жагсаалттай холбоотой гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх, гуравдагч этгээдийн хөрөнгийг тусгаарлах харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн Засгийн газар батална.

23.3.Тагнуулын байгууллага Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолыг үндэслэн энэ хуулийн 23.2–т заасан журмын дагуу аливаа хүн, хуулийн этгээдийг хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад оруулах талаар холбогдох арга хэмжээг авна.

23.4.Энэ хуулийн 23.2–т заасан журмын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ тухайн хүн, хуулийн этгээдтэй холбогдуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн эсэхээс үл хамаарна.

23.5.Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд өөрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хууль бусаар зөрчсөн гэж үзвэл энэ хуулийн 23.2–т заасан журмын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

23.6.Хүн, хуулийн этгээд аливаа үйлчилгээ үзүүлэхдээ хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, тэдгээрийг санхүүжүүлдэг этгээдийн шууд болон шууд бус өмчлөл, эсхүл хяналтад байгаа хөрөнгийг даруй царцааж тагнуулын байгууллагад 24 цагийн дотор мэдээлнэ.

23.7.Хориг арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах, түүнд хяналт тавих ажлыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19.1–д заасан байгууллага хэрэгжүүлнэ.

#### **24 дүгээр зүйл.Хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх**

24.1.Тагнуулын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн алба болон холбогдох төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд хориг арга хэмжээг хэрэгжүүлэхдээ доор дурдсан хөрөнгийг царцаана:

24.1.1.тодорхой террорист үйлдэл, үйл ажиллагаагаар хязгаарлахгүй хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн өмчлөл буюу хяналтаа тогтоосон бүхий л мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;

24.1.2.хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдээс бүхэлд нь буюу хэсэгчлэн, дангаараа буюу хамтран, шууд болон шууд бусаар өмчлөл буюу хяналтаа тогтоосон бүхий л мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;

24.1.3.энэ хуулийн 24.1.1, 24.1.2–т заасан хөрөнгөөс бий болсон мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө, хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн заавраар, тэдгээрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийн мөнгөн хуримтлал буюу бусад хөрөнгө;

24.1.4.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн тогтоолоор хориг арга хэмжээний жагсаалтад оруулсан бусад хөрөнгө.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **25 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

25.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

25.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол тагнуулын байгууллагаас Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд санал тавьж шийдвэрлүүлнэ:

25.2.1.энэ хуулийн 13.1.2, 13.1.3, 13.1.4–т заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

25.2.2.энэ хуулийн 13.1.2, 13.1.3, 13.1.4–т заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл энэ хуулийн 17.4, 17.5–д заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг албан тушаал бууруулах, албан тушаалаас нь огцруулах, эсхүл төрийн албанаас халах.

25.3.Энэ хуулийн 25.2–т заасан саналыг хүлээн авсан харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтан нь тухайн албан тушаалтанд саналын дагуу холбогдох хариуцлага хүлээлгэж, энэ талаар 14 хоногийн дотор тагнуулын байгууллагад хариу мэдэгдэнэ.

25.4.Энэ хуулийн 25.3–т заасныг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол тухайн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналыг тагнуулын байгууллагаас түүнийг томилох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

25.5.Тагнуулын байгууллагаас энэ хуульд заасан бүрэн эрх, эрх хэмжээний хүрээнд гаргасан шийдвэрийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээд шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэх үүрэгтэй.

25.6.Энэ хуульд заасан байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээд энэ хуульд заасан үүргээ биелүүлсний улмаас бусдад гэм хор учруулсан бол Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

**26 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

26.1.Энэ хуулийг 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 5 дугаар сарын  
13–ны өдөр

Улаанбаатар хот

### МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

*/Шинэчилсэн найруулга/*

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн үндсийг тогтооход оршино.

##### **2 дугаар зүйл.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж**

2.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### **2<sup>1</sup> дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

2<sup>1</sup>.1.Энэ хуульд заасан терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бүхий л зохицуулалтад үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аливаа үйл ажиллагаа нэгэн адил хамаарна.

*/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг;

*/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

3.1.2.“терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг;

*/Энэ заалтыг 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

3.1.3.“бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглаж хийсэн гүйлгээг;

3.1.4.“бэлэн бус мөнгөний гүйлгээ” гэж олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, инкасс, төлбөрийн карт, цахим төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр хийсэн гүйлгээг;

3.1.5.“улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн3 20.2–т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;

*/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

3.1.6. “эцсийн өмчлөгч” гэж:

*/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

3.1.6.а. харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.6.б. харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.6.в. хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.7. “халхавч банк” гэж гүйцэтгэх удирдлага болон үйл ажиллагаа нь тухайн зөвшөөрөл авсан, эсхүл бүртгүүлсэн улсдаа бодитоор оршин байдаггүй, эсхүл тусгай зохицуулалттай ба нэгдсэн хяналт шалгалтад хамрагддаг санхүүгийн байгууллагад хамаардаггүй банкиг банкнийг;

*/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

3.1.8. “харилцагч” гэж энэ хуулийн 4.1–д заасан этгээдээр үйлчлүүлж байгаа этгээдийг;

3.1.9. “хөрөнгө” гэж Иргэний хуулийн 4.83 дугаар зүйлд заасныг;

*/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

3.1.10. “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 2–т заасныг;

*/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

3.1.11. “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн

3.1.20–д заасныг;

*/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

*/Энэ заалтыг 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдрийн хуулиар өөрчлөн  
найруулсан./*

3.1.12.“үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч” гэж үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнийг;

*/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

3.1.13.“хөрөнгийг удирдах” гэж харилцагчийн хөрөнгийг түүний нэрийн өмнөөс ашиглах, эзэмших, захиран зарцуулахыг.

*/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

3.1.14.“санхүүгийн зөвлөх үйлчилгээ” гэж татварын зөвлөх үйлчилгээ, аудит баталгаажуулалтын үйлчилгээг ойлгоно.

*/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуулиар нэмсэн./*

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **4 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээд**

4.1.Дараах этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар энэ хуулийн 16.1–д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй:

4.1.1.банк;

4.1.2.банк бус санхүүгийн байгууллага;

4.1.3.даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;

4.1.4.хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;

*/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

4.1.5.үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;

4.1.6.хадгаламж, зээлийн хоршоо;

4.1.7.үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа

явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;

*/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

*/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

4.1.8. энэ хуулийн 5.1.2–т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;

*/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

*/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

4.1.9. нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн, эсхүл оролцсон бол:

4.1.9.а. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;

4.1.9.б. харилцагчийн хөрөнгийг удирдах;

4.1.9.в. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;

4.1.9.г. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;

4.1.9.д. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

*/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

*/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

4.2. Энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр данс нээх, гүйлгээ хийх, хаагдсан данс ашиглахыг хориглоно.

4.3. Энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хэлбэрээр

хэрэгжүүлэх бөгөөд ийнхүү хэрэгжүүлэхдээ дараах эрсдэлийг харгалзан өөрийн аж ахуйн үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнд нийцүүлэн бодитойгоор үнэлнэ:

4.3.1.харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл;

4.3.2.бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарч үүсэх эрсдэл;

4.3.3.бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл;

4.3.4.газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

4.4.Энэ хуулийн 4.3–т заасан эрсдэлийг үнэлэхэд ашигласан баримт, мэдээллийг энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанд хадгалах ба энэ хугацаанд эрх бүхий хянан шалгагч, улсын байцаагчийн шаардсан даруйд гарган өгөхөд бэлэн байлгана.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

#### **4<sup>1</sup> дүгээр зүйл.Эцсийн өмчлөгчийг тогтоох**

*/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

4<sup>1</sup>.1.Эцсийн өмчлөгчийг дараах дарааллаар шалгаж тогтооно:

4<sup>1</sup>.1.1.хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг;

4<sup>1</sup>.1.2.энэ хуулийн 4<sup>1</sup>.1.1–д заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг;

4<sup>1</sup>.1.3.энэ хуулийн 4<sup>1</sup>.1.1, 4<sup>1</sup>.1.2–т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг.

4<sup>1</sup>.2.Эцсийн өмчлөгчийг шалгаж тогтоох талаар авч хэрэгжүүлэх нарийвчилсан үйл ажиллагааг энэ хуулийн 5.14–т заасан журмаар зохицуулна.

#### **5 дугаар зүйл.Харилцагчийг таньж мэдэх**

5.1.Дараах тохиолдолд энэ хуулийн 4.1–д заасан этгээд харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэгтэй:

5.1.1.бизнесийн харилцаа үүсгэхийн өмнө;

*/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

5.1.2.дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартайгаар 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;

5.1.3.харилцагчийн 24 цагийн дотор хийсэн, хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь энэ хуулийн 5.1.2–т заасан хэмжээнээс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй бол;

5.1.4.харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд;

5.1.5.тухайн харилцагч, тухайн гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн тохиолдолд.

5.2.Энэ хуулийн 5.1–д заасны дагуу харилцагчийг таньж мэдэхийн тулд энэ хуулийн 4.1–д заасан этгээд дараах арга хэмжээ авна:

5.2.1.харилцагч нь иргэн бол түүний овог, эцэг /эх/–ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, иргэний үнэмлэхийн, эсхүл гадаад паспортын хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргуулж авах;

5.2.2.харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газрын хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг гаргуулж авах;

5.2.3.эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс данс нээж, гүйлгээ хийж байгаа эсэхийг мэдэх, ойлгох зорилгоор тухайн бизнесийн харилцааны зорилго,

гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээллийг тодруулах;

5.2.4.харилцагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог, эцэг /эх/–ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийн талаар болон харилцагчийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах;

5.2.5.харилцагч нь хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягталж уг этгээдийн овог, эцэг /эх/–ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, баримт бичигтэй нь тулгаж шалгах;

5.2.6.банк, санхүүгийн байгууллагын хоорондын шилжүүлэг хийгч, хүлээн авагчийн овог, эцэг /эх/–ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, харилцах утасны дугаар, дансны дугаарыг авах.

*/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

5.3.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь харилцагчийн эрсдэлийн түвшинг үнэлж, өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх ба уг үйл ажиллагааг энэ хуулийн 5.14–т заасан журмаар зохицуулна.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

5.4.Харилцагч энэ хуулийн 5.2, 5.3–т заасны дагуу шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзвал энэ хуулийн 4.1–д заасан этгээд түүнд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй.

*/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

5.5.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг энэ хуулийн 5.14–т заасан журмын дагуу эрсдэлийн үнэлгээнд үндэслэн энэ хуулийн 5.2.1, 5.2.2–т заасан хүрээнд хялбаршуулсан байдлаар хийж болно.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

*/Энэ хэсгийг 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдрийн хуулиар өөрчлөн  
найруулсан./*

5.5.1.харилцагч нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага,  
эсхүл хөрөнгийн биржид бүртгэлтэй компани нь хувьцаа эзэмшигч, эцсийн  
өмчлөгчийг ил тод мэдээлэх үүрэгтэй бол;

*/Энэ хэсгийг 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдрийн хуулиар хүчингүй  
болсонд тооцсон./*

5.5.2.ижил түвшний урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг  
мэдээлэх үүрэгтэй этгээд хоорондоо харилцахад;

*/Энэ хэсгийг 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдрийн хуулиар хүчингүй  
болсонд тооцсон./*

5.6.Энэ хуулийн 4.1.1–д заасан этгээд нь гадаад гуйвуулга, шилжүүлэг,  
төлбөр тооцоо хийх зорилгоор гадаад улсын банктай корреспондент харилцаа  
тогтоохоос өмнө дараах мэдээллийг авсан байна:

5.6.1.тухайн банкны үйл ажиллагааны чиглэлийн талаарх мэдээлэл;

5.6.2.тухайн банк нь нийтэд танигдсан байдлын талаарх мэдээлэл;

5.6.3.корреспондент харилцааг тогтоох талаар гаргасан удирдлагын  
шийдвэр, уг харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийг харилцан тохирсон  
тухай мэдээлэл;

5.6.4.тухайн банк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй  
тэмцэх тогтолцоо, дотоод хяналтын хөтөлбөртэй эсэх;

5.6.5.тухайн банк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл  
ажиллагаанд холбогдон шалгагдсан, шалгагдаж байгаа эсэх талаарх мэдээлэл.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөн  
найруулсан./*

5.7.Энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7–д заасан  
этгээдэд:

5.7.1.халхавч банктай харилцахыг;

5.7.2.халхавч банктай харилцаа тогтоосон банктай харилцахыг;

5.7.3.халхавч банктай өмнө нь харилцаа тогтоосон байсан бол харилцааг

үргэлжлүүлэхийг хориглоно.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

5.8.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь шинэ бүтээгдэхүүн, технологи нэвтрүүлэхийн өмнө түүний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдаж болох эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

5.9.Дараах харилцагчийг өндөр эрсдэлтэй харилцагчийн нэгэн адил авч үзнэ:

5.9.1.улс төрд нөлөө бүхий этгээд;

5.9.2.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд;

5.9.3.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

5.10.Энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн хийх, хүлээн авах, дамжуулах шилжүүлэг нь шилжүүлэгч, хүлээн авагчийн талаарх тодорхой мэдээллийг бүрэн агуулсан байх ба шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээлэл тодорхой бус тохиолдолд шилжүүлэг хийх, хүлээн авах, дамжуулахаас татгалзана.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

5.11.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан мэдээлэлд байнгын хяналт тавьж, өөрчлөлт орсон тухай бүрд мэдээллийг шинэчилнэ.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

5.12.Энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7–д заасан

этгээд нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэх тохиолдолд тавигдах шаардлагыг энэ хуулийн 5.14–т заасан журмаар зохицуулна.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

5.13.Гуравдагч этгээдээр харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийлгэх нь энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7–д заасан этгээдийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

5.14.Дараах нарийвчилсан үйл ажиллагааг тусгасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална:

5.14.1.эцсийн өмчлөгчийг шалгаж тогтоох талаар авч хэрэгжүүлэх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.2.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа;

5.14.3.харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.4.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэх тохиолдолд тавигдах шаардлага;

5.14.5.эрсдэлийн үнэлгээний талаарх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.6.дотоод хяналтын хөтөлбөрийн талаар;

5.14.7.хориг арга хэмжээний жагсаалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээ;

5.14.8.холбогдох бусад арга хэмжээ.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

## **6 дугаар зүйл.Тусгай хяналт**

6.1.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд дараах гүйлгээнд тусгайлан хяналт тавих үүрэгтэй:

6.1.1.огцом өөрчлөгдсөн их дүнтэй;

6.1.2.эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй;

6.1.3.улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн;

6.1.4.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийсэн.

6.2.Энэ хуулийн 6.1–д заасан гүйлгээний талаар энэ хуулийн 4.1–д заасан этгээд нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг боломжийн хүрээнд шалгаж, үр дүнг бичгээр хадгална.

**6<sup>1</sup> дүгээр зүйл.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх**

*/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

6<sup>1</sup>.1.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.17, 3.1.18–д заасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд үйлчилгээ үзүүлэхийг хориглоно

*/Энэ хэсгийг 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

6<sup>1</sup>.2.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь хориг арга хэмжээний жагсаалтад хамаарах хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн нэр илэрсэн, мэдсэн даруйд урьдчилан мэдэгдэлгүйгээр холбогдох данс, хөрөнгийн хөдөлгөөнийг шууд зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй болгож, энэ тухай тагнуулын байгууллага, Санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдээлнэ.

*/Энэ хэсэгт 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

6<sup>1</sup>.3.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч нарт харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх ба шаардлагатай бол

хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан арга хэмжээг авна.

6<sup>1</sup>.4.Хориг арга хэмжээний жагсаалтыг энэ хуулийн 4.1–д заасан этгээдэд хүргэх, хориг арга хэмжээ болон хуульд заасан бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх, эдгээр арга хэмжээний хэрэгжилтийн тайлан гаргахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 5.14–т заасан журмаар зохицуулна.

6<sup>1</sup>.5.Мэдээлэх үүрэгтэй этгээд энэ хуулийн 6<sup>1</sup>.2–т заасан мэдээллийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23.2, 23.6–д заасан журмын дагуу мэдээлнэ.

*/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуулиар нэмсэн./*

### **7 дугаар зүйл. Гүйлгээний талаар мэдээлэх**

7.1.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.

7.2.Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1–д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

*/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

7.3.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан этгээд мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам, маягтын дагуу цахим хэлбэрээр ирүүлнэ. Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам, маягтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална.

*/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

7.4.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд Монголбанкны Ерөнхийлөгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан мэдээлэл өгөх журмын дагуу тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад гаргаж өгнө.

7.5.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд шаардлагатай тохиолдолд Санхүүгийн мэдээллийн албаны даргын зөвшөөрснөөр цаасан хэлбэрээр ирүүлж болно.

*/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуулиар нэмсэн./*

## **8 дугаар зүйл.Харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалах**

8.1.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар энэ хуулийн 5, 6 дугаар зүйлд заасны дагуу олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухайн данс хаагдсан, эсхүл гүйлгээ хийгдсэнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд хадгална.

8.2.Энэ хуулийн 8.1–д заасан мэдээлэл, баримт бичгийг энэ хуулийн 4.1–д заасан этгээд эрх бүхий хууль сахиулах байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална.

## **9 дүгээр зүйл.Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл**

9.1.Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл дараах агуулгатай байна:

9.1.1.энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /эх/–ийн нэр, өөрийн нэр;

9.1.2.харилцагч, хүлээн авагчийн талаарх мэдээлэл;

9.1.3.тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, он, сар, өдөр, дансны дугаар, гүйлгээний бусад оролцогч болон данс эзэмшигчийн талаарх мэдээлэл;

9.1.4.тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар;

9.1.5.холбогдох бусад баримт бичиг.

9.2.Санхүүгийн мэдээллийн алба нь сэжигтэй гүйлгээтэй холбогдсон

этгээдийн дансны хуулбар, данс нээхэд ашигласан бичиг баримтын хуулбар, банкны харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг зэрэг нэмэлт мэдээллийг энэ хуулийн 4.1–д заасан этгээдээс гаргуулан авах эрхтэй.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

### **10 дугаар зүйл.Дансанд хяналт тавих**

10.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглаж байгаа гэж үзэх үндэслэл байгаа бол Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн харилцагчийн дансанд хяналт тавьж болно.

### **11 дүгээр зүйл.Хөрөнгө битүүмжлэх, түдгэлзүүлэх**

11.1.Хийгдэхээр хүлээгдэж байгаа гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэлтэй бол Санхүүгийн мэдээллийн албаны дарга тухайн гүйлгээг ажлын гурав хүртэл өдрийн хугацаагаар түдгэлзүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд шүүх уг хугацааг сунгаж болно.

11.2.Энэ хуулийн 11.1–д заасан шийдвэрийг энэ хуулийн 4.1–д заасан этгээдэд бичгээр, боломжгүй бол утсаар мэдэгдэж, шийдвэрийг 24 цагийн дотор хүргүүлнэ.

11.3.Энэ хуулийн 11.1–д заасны дагуу гүйлгээг түдгэлзүүлэх хугацаанд Санхүүгийн мэдээллийн алба дараах арга хэмжээ авна:

11.3.1.тухайн гүйлгээний талаар гадаад, дотоодын холбогдох байгууллагаас шаардлагатай мэдээлэл цуглуулах;

11.3.2.тухайн гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой байсан гэж үзэх баримт, үндэслэл тогтоогдсон бол энэ тухай эрх бүхий хууль сахиулах байгууллагад мэдэгдэж холбогдох баримт бичгийг нэн даруй шилжүүлэн шалгуулах;

11.3.3.тухайн гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсан гэдэг нь тогтоогдвол гүйлгээг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг цуцалж, энэ хуулийн 4.1–д заасан этгээдэд нэн даруй мэдэгдэх.

### **12 дугаар зүйл.Хариуцлагаас чөлөөлөх**

12.1.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл

өгснийг банкны, мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон бусад нууц задруулсан гэж үзэхгүй.

*/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

12.2.Энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

*/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

12.3.Тодорхой гүйлгээг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу түдгэлзүүлснээс иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан нь энэ хуулийн 4.1–д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан болон Санхүүгийн мэдээллийн алба, тус албаны албан хаагчийг Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

12.4.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд болон Санхүүгийн мэдээллийн албаны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан бол хохирлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

### **13 дугаар зүйл.Мэдээллийн нууцлалыг хадгалах**

13.1.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан нь Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг энэ хуулийн 7.4–т зааснаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

13.2.Санхүүгийн мэдээллийн албаны дарга, хянан шалгагч, шинжээч, ажилтан албан үүргийнхээ дагуу олж авсан харилцагчийн гүйлгээтэй холбогдох

мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хугацаанд болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш задруулахыг хориглоно.

#### **14 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт**

*/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

14.1. Энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь түүний төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл түүнтэй адилтгах удирдлагаас баталсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна.

14.2. Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр нь энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцсэн байх ба мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг хангасан байна.

14.3. Дотоод хяналтын хөтөлбөрийг энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн харьяалагддаг санхүүгийн нэгдэл, тэдгээрийн бүх салбар нэгж, охин компани нь нэгэн адил хэрэгжүүлнэ.

14.4. Дотоод хяналтын хөтөлбөрт дараах асуудлыг тусгана:

14.4.1. харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх үйл ажиллагаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлал;

14.4.2. өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам;

14.4.3. шинэ технологи болон өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний зохицуулалт;

14.4.4. харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны журам;

14.4.5. харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхэд дагаж мөрдөх зохицуулалт;

14.4.6. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл, төрийн болон

олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт;

14.4.7.тусгайлан хяналт тавих үйл ажиллагааны журам;

14.4.8.корреспондент банкны харилцаа тогтоох журам;

14.4.9.мөнгөн гуйвуулга, цахим төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам;

14.4.10.сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, хадгалах журам;

14.4.11.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг;

14.4.12.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр;

14.4.13.хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан бусад нөхцөл, шаардлага.

14.5.Дотоод хяналтын хөтөлбөрийг энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь өөрийн харьяалагддаг хяналт тавих эрх бүхий байгууллагад хүргүүлж бүртгүүлнэ.

14.6.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороо, эсхүл бие даасан дотоод хяналтын нэгжээр дамжуулан дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллана.

## **15 дугаар зүйл.Монгол Улсын хилээр бэлэн мөнгө оруулах, гаргах**

15.1.Зорчигч 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлнэ.

15.2.Энэ хуулийн 15.1–д заасны дагуу мэдүүлсэн бэлэн мөнгөний мэдүүлгийг гаалийн байгууллага нэгтгэж, сар бүр холбогдох журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлнэ.

15.3.Энэ хуулийн 15.2–т заасан мэдүүлгийн маягтын загварыг Санхүүгийн мэдээллийн албаны даргатай зөвшилцөж Гаалийн ерөнхий газрын дарга батална.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

### **16 дугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн алба**

16.1. Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл, энэ хуулийн 4.1–д заасан этгээдээс энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага байна.

*/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

16.2. Санхүүгийн мэдээллийн алба нь Монголбанкны дэргэд ажиллана.

16.3. Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг тус албаны дарга, үйл ажиллагааны төсвийг тус албаны даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална.

*/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

16.4. Санхүүгийн мэдээллийн албаны даргыг эрх бүхий хууль сахиулах байгууллагын даргатай зөвшилцөн Монголбанкны Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.

16.5. Санхүүгийн мэдээллийн албаны дарга дараах шаардлагыг хангасан байна:

16.5.1. банк, санхүү, эсхүл хууль зүйн салбарт таваас доошгүй жил ажилласан;

16.5.2. зээлийн болон баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй.

16.6.Санхүүгийн мэдээллийн албаны хянан шалгагч, шинжээч дараах шаардлагыг хангасан байна:

16.6.1.банк, санхүү, эсхүл хууль зүйн салбарт хоёроос доошгүй жил ажилласан;

16.6.2.зээлийн болон баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй.

16.7.Санхүүгийн мэдээллийн албаны дарга нь санхүүгийн мэдээллийн улсын ахлах байцаагч, хянан шалгагч, шинжээч нь санхүүгийн мэдээллийн улсын байцаагч байна.

16.8.Санхүүгийн мэдээллийн албаны улсын ахлах байцаагчийн эрхийг Монголбанкны Ерөнхийлөгч, улсын байцаагчийн эрхийг улсын ахлах байцаагч олгоно.

16.9.Санхүүгийн мэдээллийн албаны дарга болон хянан шалгагч, шинжээч шаардлагатай тохиолдолд хяналт шалгалт хийх, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагаас лавлагаа гаргуулж авах бүрэн эрхтэй.

16.10.Санхүүгийн мэдээллийн албаны дотоод үйл ажиллагаатай холбогдох бусад журам, зааврыг Санхүүгийн мэдээллийн албаны дарга батална.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

### **17 дугаар зүйл. Эрх бүхий хууль сахиулах байгууллагын чиг үүрэг**

17.1.Санхүүгийн мэдээллийн албанд эрх бүхий хууль сахиулах байгууллагын төлөөллийг ажиллуулна.

17.2.Эрх бүхий хууль сахиулах байгууллагын төлөөлөл нь энэ хуулийн 16.9–д заасны дагуу хяналт шалгалт хийх, санхүүгийн лавлагаа гаргуулж авах эрхтэй.

17.3.Энэ хуулийн 17.1–д заасан төлөөллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагын даргын саналыг үндэслэн Санхүүгийн мэдээллийн албаны дарга томилж, чөлөөлнө.

17.4.Шаардлагатай тохиолдолд эрх бүхий хууль сахиулах байгууллага, Санхүүгийн мэдээллийн алба хамтарсан ажлын хэсэг гарган ажиллаж болно.

## **18 дугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн албаны чиг үүрэг**

18.1. Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 10, 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.1. энэ хуулийн 4.1–д заасан этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх;

18.1.2. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг хуульд заасан журмын дагуу эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэх, шилжүүлсэн сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар мэдээллийн сан бүрдүүлэх;

18.1.3. мэдээлэх үүрэгтэй этгээдийн сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор сэжигтэй гүйлгээнд хийсэн дүн шинжилгээний талаарх ерөнхий мэдээлэл, сэжигтэй гүйлгээний нийтлэг хэв шинж, арга хэлбэрийн талаар тогтмол мэдээлэх;

*/Энэ хэсгийг 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

18.1.4. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах, сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх аргачлал боловсруулж энэ хуулийн 4.1–д заасан этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;

18.1.5. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл, сурталчилгаа явуулах;

*/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

18.1.6. хориг арга хэмжээний жагсаалтыг энэ хуулийн 4.1–д заасан этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;

*/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

18.1.7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар нэгдсэн статистик

гаргах, хяналт шалгалт хийх, эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх;

*/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

18.1.8.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний стратеги боловсруулах, уг стратегийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

*/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

18.1.9.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах.

*/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

18.2.Санхүүгийн мэдээллийн албаны хянан шалгагч мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, илэрсэн зөрчлийг арилгахыг энэ хуулийн 4.1–д заасан этгээдээс шаардах, эсхүл эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлж шалгуулах буюу тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгуулах талаар санал боловсруулж эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх эрхтэй.

18.3.Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 4.1–д заасан этгээд, түүний албан тушаалтныг хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавина.

18.4.Санхүүгийн мэдээллийн алба өөрийн үйл ажиллагааны талаарх тайланг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд жил бүр танилцуулна.

18.5.Санхүүгийн мэдээллийн албаны дарга, ажилтан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор иргэний, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн бүртгэл, нийгмийн даатгалын бүртгэл, хилээр нэвтэрсэн тухай бүртгэл, хөрөнгө оруулалтын бүртгэл, татвар төлөлтийн бүртгэл, банк, санхүүгийн байгууллага хоорондын гүйлгээний бүртгэлийн лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулж авах эрхтэй.

*/Энэ хэсгийн 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

18.6. Санхүүгийн мэдээллийн алба нь үйлдвэр хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцож, гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

*/Энэ хэсгийг 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдрийн хуулиар нэмсэн./*

### **19 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналт**

*/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

19.1. Энэ хуулийн 4.1.1–д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Монголбанк, энэ хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7, 4.1.8–д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо, энэ хуулийн 4.1.9–д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Хуульчдийн холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Нотариатчдын танхим, мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох Институт, Санхүүгийн мэдээллийн алба болон тухайн төрлийн үйл ажиллагааны зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих эрх бүхий байгууллага эрсдэлд суурилсан хэлбэрээр тус тус хэрэгжүүлнэ.

*/Энэ хэсэгт 2019 оны 05 дугаар сарын 30–ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

*/Энэ хэсэгт 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан./*

*/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

19.2. Энэ хуулийн 19.1–д заасан эрх бүхий байгууллага, Санхүүгийн мэдээллийн алба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

19.2.1. энэ хуулийн 4.1–д заасан этгээдэд газар дээрх шалгалт хийх, зайнаас хяналт тавих, шалгалтын удирдамж, журам, заавар, зөвлөмж гаргах;

19.2.2.энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, шалгалт хийх зорилгоор баримт, тайлан, мэдээлэл, тайлбар гаргуулан авах;

19.2.3.энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, гүйцэтгэх удирдлага, ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлох;

19.2.4.санхүүгийн нэгдлийн оролцогч нь өөр улсад бүртгэгдсэн, эсхүл байршдаг бол холбогдох хяналт тавих эрх бүхий байгууллага нь тухайн улсын хяналт тавих эрх бүхий байгууллагатай гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан мэдээлэл солилцох, хамтарсан шалгалт хийх хэлбэрээр хамтран ажиллах;

19.2.5.энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалтын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зорилгоор холбогдох хяналт тавих эрх бүхий байгууллага хоорондоо болон Санхүүгийн мэдээллийн албатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах;

19.2.6.энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авч байгаа арга хэмжээ болон хариуцлагын талаарх статистик мэдээг нийтэд түгээх;

19.2.7.санхүүгийн нэгдлийн хэмжээнд хуулийн хэрэгжилтийг шалгах шаардлагатай гэж үзвэл Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийх.

19.3.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан нь хянан шалгагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлөөр хангана.

19.4.Санхүүгийн мэдээллийн алба шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 4.1–д заасан этгээд хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг энэ хуулийн 19.1–д заасан этгээдтэй хамтран хэрэгжүүлж болно.

## **20 дугаар зүйл.Мэдээллийн сан**

20.1.Санхүүгийн мэдээллийн алба энэ хуульд заасан журмын дагуу цуглуулсан мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сантай байна.

20.2.Энэ хуулийн 20.1–д заасан мэдээллийн санд мэдээлэл хадгалах, түүнийг ашиглах журмыг Санхүүгийн мэдээллийн албаны дарга батална.

### **21 дүгээр зүйл.Гадаад улсын ижил төстэй байгууллагатай харилцах**

21.1.Санхүүгийн мэдээллийн алба ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг, нууцлалын байдлаар ижил түвшний, гадаад улсын болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

21.2.Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 21.1–д заасан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн түүнд шаардлагатай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгч болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **22 дугаар зүйл.Хамтын ажиллагааны зөвлөл**

22.1.Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хамтын ажиллагааны зөвлөл ажиллана.

22.2.Хамтын ажиллагааны зөвлөлд гадаад харилцаа, санхүүгийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, прокурорын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл ажиллана.

22.3.Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Санхүүгийн мэдээллийн алба хэрэгжүүлнэ.

22.4.Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн, түүний удирдлагыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

### **22<sup>1</sup> дүгээр зүйл.Үндэсний зөвлөл**

*/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

22<sup>1</sup>.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл

ажиллах бөгөөд уг зөвлөлийг тэргүүлэх албан тушаалтан болон зөвлөлийн бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар батална.

*/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

22<sup>1</sup>.2.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд прокурорын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн, хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөллийг оролцуулна.

*/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

22<sup>1</sup>.3.Үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Санхүүгийн мэдээллийн алба хэрэгжүүлнэ.

## **23 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

23.1.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

23.2.Энэ хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол энэ хуулийн 19.1–д заасан байгууллагын эрх бүхий албан тушаалтан үүссэн нөхцөл байдал, дутагдлыг харгалзан дараах арга хэмжээг авна:

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

23.2.1.дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх, хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

23.2.2.энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;

23.2.3.энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, зогсоох, түдгэлзүүлэх, үйл ажиллагааны зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал гаргах;

*/Энэ заалтад 2019 оны 05 дугаар сарын 30–ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

23.2.4.энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөрчлөхийг үүрэг болгох.

23.3.Эрх бүхий албан тушаалтнаас энэ хуулийн 23.2–т заасны дагуу өгсөн хугацаатай үүрэг, даалгавар, сануулга, шаардлагыг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

*/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн хуулиар нэмсэн./*

#### **24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

24.1.Энэ хуулийг 2013 оны 5 дугаар сарын 31–ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний хүрээнд тогтмол тавигддаг асуултууд**

Мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан асуулга ба холбогдох хариултууд

### **1. Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ Монгол Улсын ямар хууль тогтоомжоор зохицуулагддаг вэ?**

Терроризм ба үй олноор хөнөөх зэвсэгтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалт нь дараах хоёр хууль тогтоомж болон журмаар зохицуулагдана. “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль”; “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”–нд тус тус мэдээлэх үүрэгтэй этгээдэд тусгайлан оногдуулсан үүргүүдийг тусгаж өгсөн.

Түүнчлэн “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль”–ийг үндэслэн НҮБ–ын АЗ–өөс гаргасан тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”–ыг баримтална.

### **2. Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд хуулиар ямар үүрэг хүлээсэн бэ?**

Дээрх хуулиар та дараах тохиолдолд өөрийн хяналт, мэдэлд байгаа хөрөнгийг царцаах шаардлагатай:

- НҮБ–ын АЗ болон Монгол Улсын Засгийн газраас баталсан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн дангаар болон хэсэгчилсэн, шууд болон шууд бус өмчлөл эсхүл хяналтад байгаа хөрөнгө

- Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээдийн дангаар болон хэсэгчилсэн, шууд болон шууд бус өмчлөл эсхүл хяналтад байгаа хөрөнгө
- Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээдийн дангаар болон хэсэгчилсэн, шууд болон шууд бус өмчлөл эсхүл хяналтад байгаа хөрөнгө

Царцаасан хөрөнгө, хөрөнгийн гүйлгээний талаарх мэдээллийг ТТЗ, ТЕГ, СМА–нд дараах цахим хаягийн дагуу 24 цагийн дотор хүргүүлнэ.

Терроризмтой тэмцэх зөвлөл: [fts@nctc.gov.mn](mailto:fts@nctc.gov.mn); Утас: 92263493

Тагнуулын ерөнхий газар: [amlcft@gia.gov.mn](mailto:amlcft@gia.gov.mn) Утас: 92263017

Санхүүгийн мэдээллийн алба: [fiu@mongolbank.mn](mailto:fiu@mongolbank.mn) Утас: 450068

- Дараах этгээдэд аливаа хөрөнгийг (бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн, шууд болон шууд бусаар) удирдах, эсхүл ашиг олгохыг хориглоно:
  - НҮБ–ын АЗ болон Монгол Улсын Засгийн газраас баталсан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд;
  - Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн өмчлөл эсхүл хяналтад байгаа хүн, хуулийн этгээдэд;
  - Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээдэд;
  - Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн шууд удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй хүн, хуулийн этгээдэд;
- Дараах этгээдэд аливаа санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, эсхүл ашиг олгохыг хориглоно:
  - НҮБ–ын АЗ–ийн терроризмын эсрэг тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас баталсан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд;
  - Терроризмтой холбоотой хориг арга хэмжээний жагсаалтад орсон

хүн, хуулийн этгээдийн өмчлөл эсхүл хяналтад байгаа хүн, хуулийн этгээдэд;

- Терроризмтой холбоотой хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээдэд;
- Терроризмтой холбоотой хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн шууд удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй хүн, хуулийн этгээдэд;

### **3. Хүн, хуулийн этгээдийг жагсаалтад орсон эсэх мэдээллийг би хаанаас олж авах вэ?**

Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийг НҮБ–ын албан ёсны цахим хуудас болон Терроризмтой тэмцэх зөвлөл, Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас болон Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны цахим хуудаснаас олж харах боломжтой.

НҮБ–ын хориг арга хэмжээний жагсаалт: <https://www.un.org/securitycouncil/content/un-sc-consolidated-list>

МУ–ын холбогдох байгууллагын цахим хуудас: [www.nctc.gov.mn](http://www.nctc.gov.mn); [www.gja.gov.mn](http://www.gja.gov.mn); [www.fiu.mn](http://www.fiu.mn); [www.frc.mn](http://www.frc.mn)

Дээрх жагсаалт нь хориг арга хэмжээнд орсон хүн, хуулийн этгээдийн талаарх холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг агуулдаг. Хориг арга хэмжээний жагсаалтад оруулах, жагсаалтаас хасах үйл явц нь байнга давтагдаж тогтмол шинжтэй үргэлжилж байдаг тул та жагсаалтын шинэчилсэн хувилбарыг дээрх цахим хуудсанд хандаж тогтмол авч байх шаардлагатай.

### **4. Хүн, хуулийн этгээдийг хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд гэдгийг шалгаж тогтооход надад туслалцаа дэмжлэг хэрэгтэй болвол хэрхэх вэ?**

Хэрэв та тухайн хүн, хуулийн этгээдийг хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд мөн эсэхийг тогтоож чадахгүй, тогтоох боломжгүй байгаа тохиолдолд “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны

аргачлалын хавсралт”–д заасан мэдээлэл хүсэх, түүнийг баталгаажуулах талаарх холбогдох маягтыг бөглөж Терроризмтой тэмцэх зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн албаны цахим шуудангийн хаягаар илгээж тодруулга авах боломжтой.

Энэ тохиолдолд хэрэв танд тухайн хүн, хуулийн этгээдийн талаар эргэлзээтэй асуудал байгаа бол тавьсан хүсэлтийн хариуг иртэл тухайн хөрөнгийг царцаах нь зүйтэй. Хүсэлтэд хариу ирэхгүй байх нь таны хөрөнгө царцаах үүргээ биелүүлээгүй үйлдлийг хариуцлагаас чөлөөлөхгүйг анхаарна уу.

### **5. “Хөрөнгө” гэж юу вэ?**

“Хөрөнгө” гэж мөнгө, эд өмч, санхүүгийн нөөц болон барьцтай эсхүл барьцгүй, биет эсхүл биет бус, хөдлөх эсхүл үл хөдлөх, бодит эсхүл боломжит зэрэг бүх төрлийн эдийн засгийн нөөц болон олж авсан дараах зүйлсийг хэлнэ. Үүнд: 1. бэлэн мөнгө 2. виртуаль эсхүл цахим валют, ба крипто– валют 3. банкны зээл, аяны чек, банкны чек, мөнгөн гуйвуулга 4. үнэт метал, үнэт чулуу 5. бодит эд өмч, хөдлөх хөрөнгө болон усан онгоц 6. хувьцаа, үнэт цаас, бонд ба драфт 7. тооцооны эрх, баталгаа, гүйцэтгэлийн бонд, ба санхүүгийн бусад үүрэг 8. аккредитив, тээврийн баримт бичиг, борлуулалтын баримт бичиг 9. экспортын санхүүжилтийн арга хэрэгсэл 10. байгалийн нөөц 11. нислэгийн багийн үйлчилгээ зэрэг хөдөлмөрийн нөөц 12. санхүүжилт, бараа, үйлчилгээ авахад зориулагдсан эдийн засгийн бусад нөөц 13. электрон эсхүл цахим зэрэг хуулийн баримт бичиг эсхүл арга хэрэгсэл, хөрөнгө нэхэмжлэх нотолгоо, эсхүл сонирхол, эсхүл эрх 14. хөрөнгөөс үүдэлтэй хүү, ногдол ашиг, эсхүл орлого, үнэ цэнэ орно.

### **6. “Хөрөнгө царцаах” гэж юу гэсэн үг вэ?**

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.21–т зааснаар "хөрөнгө царцаах" гэж аливаа хөрөнгө, мөнгөн хөрөнгийн хөдөлгөөнийг эрх бүхий этгээдийн шийдвэрээр албадан битүүмжлэх, хураан авах хүртэл хугацаанд захиран зарцуулах, шилжүүлэх, удирдах эрхийг хязгаарлахыг хэлнэ.

## **7. Хөрөнгө өмчлөх болон хөрөнгийг хянах гэж юу гэсэн үг вэ?**

Хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлын 25–аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд өмчлөх эрх үүснэ. Тухайлбал, хүн аливаа хуулийн этгээдийн /компаний/ 26 хувийг эзэмшдэг бол тухайн компаний өмчлөгч гэж үзнэ. Түүнчлэн өмчлөлийн тухайд эцсийн өмчлөлийн асуудлыг харгалзан үзэх шаардлага гардаг. Тухайлбал, Хэрэв Б компани нь А компанийн нийт хувьцааны 26 хувийг эзэмшдэг бол та Б компаний эцсийн өмчлөгч тэрхүү хувь хүнийг тогтоох шаардлагатай.

Хяналт гэдэг нь хууль ёсны өмчлөлөөс бусад хяналтыг хэлнэ. Хяналтыг гэрээ, хэлэлцээр, харилцан ойлголцлын үндсэн дээр тогтоож болно. Хяналтын дараах жишээ байж болно:

- Тухайн хүн, хуулийн этгээдийн захиргаа, удирдлага, хяналт тавих байгууллагын гишүүдийн дийлэнх хэсгийг томилох, чөлөөлөх бүрэн эрхтэй.
- Зөвхөн тухайн жилийн болон өмнөх санхүүгийн жилийн хугацаанд албан тушаал хашиж байсан этгээдийг тухайн хуулийн этгээдийн захиргаа, удирдлага, хяналтын нэгжийн төлөөлөл бүхий гишүүдээс авсан санал хураалтын олонхын саналыг үндэслэн томилно.
- Бусад хувьцаа эзэмшигчид эсвэл хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн гишүүдтэй тохиролцсоны дагуу дангаараа хяналт тавих, тухайн хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн дийлэнх хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхтэй болно
- Тухайн хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн байгуулсан гэрээ, эсхүл түүний санамж бичигт эсвэл Меморандуумд зааснаар тухайн хуулийн этгээд, аж ахуйн нэгжийг захиран зарцуулах эрх бүхий этгээдэд давуу эрх эдлэх эрхтэй болно.

Банкны данс эсхүл хувь хүний эдийн засгийн нөөцийг хянах, ашиглахыг харуулах боломжтой. Жишээ нь өөрийн хөрөнгийг түнш, гэр бүлийн гишүүдийн нэрээр бүртгүүлсэн, хориг арга хэмжээнд орсон бус хүний данс ашиглан мөнгө хадгалах, шилжүүлэх ажлыг хөнгөвчлөх.

## **8. Жагсаалтад орсон этгээдтэй холбоотой царцаасан хөрөнгийг ашиглах зөвшөөрөл авах боломжтой юу?**

Жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд, эсхүл царцаасан хөрөнгийг эзэмшдэг хувь хүн, хуулийн этгээд царцаасан хөрөнгийг зарцуулах, ашиглах зөвшөөрөл авах хүсэлт гаргаж болно.

Зөвшөөрлийг дараахь үндэслэлээр гаргаж болно:

- Үндсэн зардлыг нөхөхөд хөрөнгө эсхүл санхүүгийн үйлчилгээ шаардлагатай байвал
- Онцгой зардлыг нөхөхөд хөрөнгө эсхүл санхүүгийн үйлчилгээ шаардлагатай байвал
- Өмнөх гэрээний үүргээ биелүүлэхэд шаардагдах хөрөнгө эсхүл санхүүгийн үйлчилгээ
- Энэхүү зөвшөөрөл нь НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн холбогдох тогтоолуудад заасан үндэслэлтэй нийцэж байвал.
- “Үндсэн зардал” нь дараахь зорилгын аль нэгэнд зарцуулсан зардлыг багтаана.
  - хоол хүнс авах, түрээсийн болон “mortgage” төлбөр;
  - эм, эмчилгээ хийлгэх
  - татвар төлөх, даатгалын шимтгэл төлөх, үйлчилгээний төлбөр
  - мэргэжлийн зохих төлбөрийг төлөх
  - хууль ёсны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлын төлбөр
  - царцаасан хөрөнгийг тогтмол хадгалах, засвар үйлчилгээ хийхэд зориулж Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн үүрэг, үйлчилгээний төлбөр төлөх.
- “Онцгой зардал” гэж үндсэн зардал эсвэл гэрээний үүрэг биш аливаа төлбөрийг хэлнэ:
  - шаардлагатай байх
  - НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн холбогдох тогтоолын заалтыг зөрчөөгүй;
  - НҮБ–ын Аюулгүйн зөвлөл эсхүл түүний хороод батална. “Гэрээний

үүрэг” гэж тухайн этгээд, байгууллагын томилогдсон өдрөөс өмнө хийгдсэн гэрээ, хэлэлцээрийн дагуу төлбөр хийх шаардлагатай бөгөөд төлбөр нь НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн холбогдох тогтоолын заалтыг зөрчөөгүй байх ёстой.

**9. Хэрэв би санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд яах вэ?**

Монгол Улсын Засгийн газар НҮБ–ын гишүүн улсын хувьд санхүүгийн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн. Иймд хэрэв та үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээнэ. Энэхүү хариуцлага нь зөрчлийн шинжтэй үйлдэл бол Зөрчлийн тухай хуулиар эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол Эрүүгийн хуулинд заасны дагуу тус тус торгох, хуулийн этгээдийг татан буулгах, эрүүгийн хариуцлага тус тус оногдуулна.

**10. Энэ асуудлаар интернэтээс нэмэлт мэдээ, мэдээллийг хаанаас авч болох вэ?**

Нэмэлт мэдээ, мэдээллийг та дараах байгууллагуудын албан ёсны цахим хуудас болон доорх цахим шуудангийн хаяг, утасны дугаараас лавлах боломжтой.

Терроризмтой тэмцэх зөвлөл: [tfs@nctc.gov.mn](mailto:tfs@nctc.gov.mn); Утас: 92263493

Тагнуулын ерөнхий газар: [amlcft@gia.gov.mn](mailto:amlcft@gia.gov.mn) Утас: 92263017

Санхүүгийн мэдээллийн алба: [fiu@mongolbank.mn](mailto:fiu@mongolbank.mn) Утас: 450068

НҮБ болон бусад байгууллагуудын цахим хуудас:

- НҮБ–ын хориг арга хэмжээ: <https://www.un.org/securitycouncil/sanctions/information>
- Санхүүгийн үйл ажиллагааны ажлын хэсэг: <https://www.fatf-gafi.org>
- Мөнгө угаах асуудлаарх Ази, Номхон далайн бүлэг: [www.apgml.org](http://www.apgml.org)
- Евроазийн бүлэг: <https://eurasiangroup.org>

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжилтийн эх үүсвэр

- Security Council Panel of Experts Reports: [https://www.un.org/securitycouncil/sanctions/1718/panel\\_experts/reports](https://www.un.org/securitycouncil/sanctions/1718/panel_experts/reports)
- Guidance on proliferation financing obligations:

<https://fatf-gafi.org/publications/financingofproliferation/documents/guidancecounter-proliferation-financing.html>

<https://rusi.org/publication/other-publications/countering-proliferation-financemodel-law-second-edition>

- Proliferation financing typologies reports:

<https://projectalpha.eu/final-report-typologies-of-proliferation-finance/>

<https://www.fatfgafi.org/publications/methodsandtrends/documents/typologiesreportonproliferationfinancing.html>

- Proliferation financing risk assessment guides:

<https://rusi.org/publication/other-publications/guide-conducting-nationalproliferation-financing-risk-assessment>

<https://www.cnas.org/press/press-release/the-financing-of-wmd-proliferationconducting-risk-assessments>

**Банк болон мөнгөн гуйвуулгын үйлчилгээний салбаруудын талаарх асуултауд**

**12. Би жагсаалтад орсон хүн эсхүл байгууллагын дансыг хааж, шилжүүлж болох уу?**

Та тухайн хүн эсхүл байгууллагын дансыг хаах эсхүл шилжүүлэх зөвшөөрөл авах шаардлагатай.

**13. Би гуравдагч этгээдээс царцаасан дансанд төлбөр хийж болох уу?**

Тодорхой нөхцөлд та гуравдагч этгээдээс царцаасан данс руугаа төлбөр хийхийг зөвшөөрч болно. Гэсэн хэдий ч эдгээр төлбөрийг мөн царцаах ёстой. Үүнийг хийхийн өмнө та төлбөр хийх зөвшөөрлийг ТЕГ, СМА-наас авах шардлагатай.

**14. Би заасан хүн эсхүл хуулийн этгээдийн дансны хүүг ашиглах боломжтой юу?**

Царцаасан дансанд хүүг зөвшөөрөлгүйгээр олгох боломжтой.

**15. Би дансны алдааг засах боломжтой юу?**

Хэрэв данс тэмдэглэгээ хийхээс өмнө нээсэн бөгөөд дансны ашиглалтын нөхцөл нь алдааг засах боломжийг олгодог бол та зөвшөөрөлгүйгээр залруулга хийх боломжтой. Залруулгын үр дүнд данс руу орсон аливаа зээлийг мөн царцаах ёстой. Та гүйлгээний талаар ТЕГ, СМА–нд нэн даруй мэдэгдэх хэрэгтэй.

**16. Би хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд зээлийн болон хадгаламжийн данс, карт нээж болох уу?**

Та хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн зээлийн карт, түүний нэр дээрх бүх дансыг царцаах ёстой. Харин шинээр зээлийн болон хадгаламжийн данс, карт нээж өгөхөөр бол зөвшөөрөл шаардагдана. Та данс, картуудыг тодорхой хязгаарын дотор ашиглахыг зөвшөөрсөн зөвшөөрөл бий эсэх, мөн данс, картыг зөвшөөрөгдсөн хэмжээнд ашиглахад тавих, түүнийг баталгаажуулах хяналтын систем бий эсэхэд анхаарах шаардлагатай.

**17. Монгол Улсаас гадуур байрлаж буй жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдээс Монгол Улсад байрлаж буй жагсаалтад ороогүй иргэн, хуулийн этгээдэд мөнгөн хөрөнгө шилжүүлсэн тохиолдолд хэрхэх вэ?**

Гадаадад байгаа тодорхой нэг хүн, байгууллагын санхүүжилт Монголд ирэхэд эсхүл дэлхийн аль ч улсын санхүүгийн байгууллагад ирэхэд хаагдах ёстой.

**18. Аюулгүй хадгаламжийн хайрцганд хориг арга хэмжээ хэрхэн хэрэгждэг вэ?**

Та тодорхой хүн, байгууллагын эзэмшдэг сейфиийг мөн адил царцаах ёстой. Энэ нь сейф буюу касс нь эдийн засгийн нөөц байж болно, эсхүл тодорхой хүн эсхүл байгууллагад хамаарах хөрөнгө, эдийн засгийн нөөцийг хадгалахад ашиглагддагтай холбоотой юм. Тухайн хүн эсхүл байгууллагын хувьд ийм найдвартай эх үүсвэр байгаа гэх байдлаар ТЕГ, СМА–нд мэдэгдэх ёстой. Хэрэв агуулга тодорхойгүй байвал ТЕГ, СМА тайланд үүнийг тодруулах ёстой. Тайлагнахаас өмнө хайрцгийг нээх, хайх шаардлагагүй. Хүн, аж ахуйн нэгж нь зөвшөөрөлгүйгээр сейфд нэвтрэх эрхгүй байх ёстой.

## **Даатгалын салбарт тавих асуултууд**

### **19. Даатгалын сүлжээнд хориг арга хэмжээ авахыг хэн хариуцах вэ?**

Монгол Улсын хориг арга хэмжээний тухай хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчид санхүүгийн хориг арга хэмжээгээ өөрөө дагаж мөрдөх үүрэгтэй.

Даатгуулагч, давхар даатгуулагч, андеррайтерууд гол үйлчлүүлэгчид эсхүл өргөдөл гаргагчдыг хүн, хуулийн этгээдийн жагсаалтад бий эсэхийг шалгах, энэ чиглэлээр тодорхой албан тушаалтныг томилох шаардлагатай.

Даатгал нь төлөөлөгч, брокер, төлөөлөгч, төлөөлөгчийн эрх мэдлээр дамжуулан олгогдсон бол та Монголын хориг арга хэмжээ авахтай холбоотой эрсдэлийг бууруулахын тулд гуравдагч этгээдийн систем, хяналт хангалттай байх ёстой. Үүнд дараах зүйлс орно: • хориг арга хэмжээний талаар бизнесийнхээ талаар тодорхой тайлбар гаргах • хориг арга хэмжээг дагаж мөрдөх бодлогыг хянах • өргөдөл гаргагчдаас санхүүгийн хориг, хяналтын тогтолцоог эерэгээр батлахыг шаардах.

### **Агентууд ба брокеруудад зориулсан асуулт**

Та ихэвчлэн үйлчлүүлэгчидтэй шууд харьцдаг тул даатгалд хамрагдахдаа үйлчлүүлэгчид болон даатгалын хүлээн авагчдад зохих хориг арга хэмжээ авах хангалттай мэдээлэл хүлээн авах ёстой. Хоригийг дагаж мөрдөх талаар даатгагч эсхүл андеррайтерийн тавьсан тодорхой шаардлага нь талуудын тохиролцооны сэдэв болно.

### **20. Би тэтгэвэр, холбогдох бүтээгдэхүүнийг ажил олгогчдод өгдөг тул ажилтнууд нь хэн болохыг мэдэхгүй байж магадгүй юм. Би хориг арга хэмжээг хэрхэн дагаж мөрдөх вэ?**

Тухайн гэрээ хэлэлцээрээс хамаарч ажил олгогчтой гэрээ байгуулсан байх магадлалтай тул ажил олгогч нь хөдөлмөрийн гэрээний дагуу ажилчдад тэтгэмж олгоно. Та хориг арга хэмжээний шалгалт хийхдээ эхлээд ажил олгогчдоо анхаарлаа хандуулах хэрэгтэй. Тухайлбал, тодорхой ажилчдыг анхаарлын төвд оруулах, жишээлбэл, тусгай андеррайтер хийх эсхүл тэтгэмжийг шууд төлөх зэрэг тохиолдолд ажилчдын мэдээлэлтэй холбоотой хориг арга хэмжээ авах шаардлагатай.

**21. Хэрэв намайг даатгуулахаар тохиролцсоны дараа жагсаалтад хэн нэгнийг оруулсан бол би юу хийх ёстой вэ?**

Жагсаалтад оруулснаар заавал хүчингүй болгох албагүй. Та өөрийн хамрах хүрээг ТЕГ, СМА–нд нэн даруй тайлагнаж, нэмэлт зөвлөгөө авах хэрэгтэй. Заасан хувь хүн эсхүл хуулийн этгээдэд нэхэмжлэл гаргахаас өмнө танд зөвшөөрөл хэрэгтэй.

**22. Даатгалын нэхэмжлэлийн хариуд би орон сууц, тээврийн хэрэгсэл гэх мэт хөрөнгөд түр зуурын нэвтрэх эрхийг өгч чадах уу?**

Танд зөвшөөрөл хэрэгтэй болно. Та дараах тохиолдлуудад хөрөнгийг зарцуулах эрхтэй: • хязгаарлагдмал хугацаа, жишээ нь, нэг долоо хоногоос бага • хувийн хэрэглээнд, жишээлбэл тээврийн хэрэгслийг хувийн хэрэгцээнд зориулан, арилжааны зориулалтаар ашиглахгүй.

**Хуульч, өмгөөллийн салбарт тавих асуултууд**

**23. Жагсаалтад орсон хүн эсхүл байгууллагад хууль эрх зүйн зөвлөгөө өгч болох уу?**

Тиймээ, та тухайн хүн эсхүл байгууллагад хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх боломжтой боловч тухайн үйлчилгээг үзүүлсэн төлбөрийг зөвшөөрөлтэйгээр авах боломжтой. Царцаасан хөрөнгийг ашиглан тодорхой хүн, хуулийн этгээд, аливаа хүн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хууль ёсны төлбөр, зардлыг төлөхийг хориглоно. Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд үзүүлсэн хууль зүйн үйлчилгээнд зориулж зохих хууль ёсны төлбөрийг төлөх зөвшөөрөл авах боломжтой. Хуулийн үндсэн үйлчилгээ үзүүлэхийн тулд урьдчилан зөвшөөрөл авах нь зүйтэй бөгөөд ингэснээр тухайн иргэн, хуулийн этгээд жагсаалтад үлдсэн тохиолдолд ямар төлбөрийг буцаан олгохыг эртнээс мэдэх нь зүйтэй. Компанийг бий болгох үйлчилгээ үзүүлэх гэх мэт хууль эрх зүйн зарим үйлчилгээ нь НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн терроризмтой холбоотой тогтоолоор хориглогдсон "санхүүгийн үйлчилгээ" –г агуулдаг.

**24. Би үйлчлүүлэгчийн мөнгийг царцаах шаардлагатай юу?**

Та өөрийн мэдэлд байгаа үйлчлүүлэгчийн эзэмшдэг эсхүл хянасан аливаа хөрөнгийг царцаах ёстой..

**25. Хэрэв жагсаалтад орсон хүн эсхүл хуулийн этгээдийн хууль ёсны үйлчилгээг жагсаалтад ороогүй этгээд төлөөлөн гүйцэтгэж байгаа бол надад зөвшөөрөл авах шаардлага бий юу?**

Та зөвшөөрөл авах шаардлагатай болно.

**26. Ямар гүйлгээг хийхийг зөвшөөрдөг вэ?**

Хөрөнгө царцсан тохиолдолд зөвшөөрөл нь зөвхөн зохих хууль эрх зүйн төлбөр, хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой төлбөрийг төлж болно. Зөвшөөрлийн үндэслэл нь хуулийн байгууллагаас төлсөн байсан ч бусад үйлчилгээний төлбөрийг төлөхийг зөвшөөрдөггүй. Эдгээр хязгаарлалт нь хууль ёсны үйлчилгээнд зориулж гуравдагч этгээд төлбөр төлдөг байсан ч хамаарна.

**27. Хуулийн “зохих хэмжээний” зардлыг юу гэж үздэг вэ?**

Та тухайн зохих хэмжээний зардлыг гаргах таньд нэн шаардлагатай гэдгийг ТЕГ, СМА–нд батлах ёстой. Ингэхдээ: • зардлын хэмжээг барагцаагаар тооцох • зардлын задаргааг гаргаж тайлагнах • холбогдох этгээдүүдэд буюу гэрч, өмгөөлөгч гэх мэт этгээдүүдэд төлвөл зохих төлбөрийг тодорхойлох.

**28. Хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлэхэд хуульчийн давуу эрх хэрхэн нөлөөлөх вэ?**

Хуулиар хүлээсэн мэдээлэх үүрэг нь хуульчдыг мэдээллээр хангах шаардлага тавиагүй. Хуулийн мэргэжилтнүүд өөрийн чиг үүрэг, эрхийн хүрээнд ямар мэдээлэл авах боломжтой талаар тодорхойлсон байх шаардлагатай.

ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБА